# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ХАМРАН СУРГАЛТ НЭМЭГДЭЖ БАЙГАА Ч ТӨРИЙН ӨМЧИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН НЭГ БҮЛГИЙН ХҮҮХДИЙН ТОО ХҮЧИН ЧАДЛААС 2 ДАХИН ХЭТЭРСЭН, СУРГАЛТЫН ЧАНАРЫГ ҮНЭЛЖ ДҮГНЭХ БОЛОМЖ БҮРДЭЭГҮЙ БАЙНА

2020 оны 1 дүгээр сар

АУДИТЫН СЭДЭВ: ТӨРӨӨС СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ ОЛГОЖ БАЙГАА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ҮР ДҮН

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ АУДИТОРЫН**
**ТУШААЛ**

2020 оны 01 сарын 30 өдөр Дугаар А/13 Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.39 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг УИХ-ын Төсвийн байнгын хороо, УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, хэрэгжилт үр дүнг 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд /Ё.Баатарбилэг/, Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/, Барилга, хот байгуулалтын сайд /Х.Баделхан/, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга /Р.Дагва/ нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар/С.Оюунгэрэл/-т даалгасугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг / Б.Хишигтогтох/-т үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ

\\10.10.10.20\Bichig_Khereg\Tushaal\2020\EA-In A Tushaal\0130GAG1.Docx

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2020 оны 01 дугаар сарын 30-ны .... өдрийн
А/13. дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**“Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт**

*/сая төгрөг/*

| № | Зөрчлийн товч утга | Албан шаардлагын дугаар | Зөрчлийн дүн |
|---|---|---|---|
| 1 | БСШУСЯ нь дангаар болон бусад яамтай хамтран Боловсролын тухай хууль, СӨБ-ын тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд заасан 4 дүрэм, 7 журам, 1 стандартыг баталж мөрдүүлээгүй, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй | 01/02 | - |
| | **Нийт дүн** | | - |

## АГУУЛГА


Товчилсон үгийн тайлбар .....2

Хүснэгтийн товьёг .....3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл .....5

БҮЛЭГ 1. ХУУЛЬД ЗААСАН ДҮРЭМ, ЖУРАМ, СТАНДАРТЫГ БҮРЭН БАТЛААГҮЙ, ЗАРИМ НОРМ НОРМАТИВ, ДҮРЭМ, ЖУРМЫГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ШИНЭЧЛЭЭГҮЙ БАЙНА .....6

*СӨБ-ын эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй, харилцан уялдаагүй, боловсролын талаар баримтлах бодлогод тусгасан зорилт, арга хэмжээг бүрэн тусгаж төлөвлөөгүй байна* .....6

*СӨБ олгох бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг хөтөлбөр, үндсэн чиглэлд бүрэн тусгаж боловсруулаагүй, уялдуулаагүй байна* .....9

*Яамны газар, нэгжүүдийн чиг үүрэгт боловсролын салбарын нэгдсэн бодлого, стратеги, хөтөлбөрийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, зохицуулах чиг үүрэг тусгагдаагүй байна* .....11

*Боловсролын салбарын мэдээллийн технологи хариуцсан нэгжийг бий болгох шаардлагатай байна* .....11

*Санхүүжилтийн үйл ажиллагаа Төсвийн тухай хуульд заасны дагуу явагдаж байна* .....14

БҮЛЭГ 2. ХАМРАН СУРГАЛТ НЭМЭГДЭЖ БАЙГАА Ч НЭГ АНГИД БАЙХ ХҮҮХДИЙН ТОО ХҮЧИН ЧАДЛААС 2 ДАХИН ХЭТЭРСЭН, СУРГАЛТЫН ЧАНАРЫГ ҮНЭЛЖ ДҮГНЭХ БОЛОМЖ БҮРДЭЭГҮЙ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ҮР НӨЛӨӨТЭЙ ХЯНАЛТ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА .....17

*СӨБ-ын байгууллагыг шинээр барих, өргөтгөх, засварлах дунд хугацааны бодлого, төлөвлөлтгүй байна* .....17

*Хот байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд тавих хяналт сул, барилгын норм ба дүрэмд шинээр баригдах орон сууцны хороолол, хотхоныг цэцэрлэгийн барилгын хамт төлөвлөж, барих зохицуулалтгүй байна* .....26

*Сургуулийн өмнөх насны хүүхэд бүр СӨБ-ын үйлчилгээнд бүрэн хамрагдаагүй байна* .....28

*СӨБ-ын чанарын үнэлгээ хийгдэхгүй байна.* .....32

*Цэцэрлэгийн багш ажилтны нэгдсэн судалгаанд үндэслэн ажлын байрны эрэлт хэрэгцээг тухай бүр тодорхойлдоггүй, хүний нөөцийн нэгдсэн бодлого төлөвлөгөө боловсруулаагүй, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна* .....36

*Зарим багш, эрхлэгч зохих шаардлага хангаагүй, үндсэн болон туслах багш бэлтгэж буй байгууллагуудын сургалтын чанар харилцан адилгүй байна* .....39

*Төсвийн төлөвлөлт бодитой бус, тусгай зориулалтын шилжүүлэг, зардлын зарцуулалтад тавих хяналт сул, төсөв хэмнэх боломжийг алдаж байна* .....42

*Салбарын яам, аймаг, НБГ-ын зүгээс тусгай зориулалтын шилжүүлэг, зардлын зарцуулалтад тавих хяналт сул, төсөв хэмнэх боломжийг алдаж байна* .....45

*СӨБ олгох үйлчилгээнд тавьж буй хяналт үр нөлөөгүй байна.* .....51

*Яамны хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын нэгжийн үндсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй, СӨБ-ын талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр дүнг үнэлж дүгнэх ажлыг төлөвлөж хэрэгжүүлээгүй, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын үр нөлөө хангалтгүй байна.* .....53

Холбогдох байгууллагын санал: .....57

Саналд өгсөн тайлбар: .....62

ДҮГНЭЛТ: .....63

ЗӨВЛӨМЖ: .....64

ХАВСРАЛТУУД: .....65

## Товчилсон үгийн тайлбар

| | |
|---|---|
| ААНБ | Аж ахуйн нэгж, байгууллага |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АНЗД | Аймаг, нийслэлийн Засаг дарга |
| АХБ | Азийн хөгжлийн банк |
| БГД | Баянгол дүүрэг |
| БЗД | Баянзүрх дүүрэг |
| БНбД | Барилгын норм ба дүрэм |
| БСШУС | Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд |
| БСШУЯ | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам |
| БСШУСЯ | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам |
| БСШУСС | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд |
| БСУГ | Боловсрол, соёл урлагийн газар |
| БХБС | Барилга, хот байгуулалтын сайд |
| БШУС | Боловсрол, шинжлэх ухааны сайд |
| БХБЯ | Барилга, хот байгуулалтын яам |
| БУМС | Боловсролын удирдлагын мэдээллийн систем |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЗГХЭГ | Засгийн газрын хэрэг эрхлэх газар |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| АНИТХ | Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |
| НБГ | Нийслэлийн боловсролын газар |
| НЗД | Нийслэлийн Засаг дарга |
| НМХГ | Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар |
| НХХС | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |
| НҮБ | Нэгдсэн үндэстний байгууллага |
| НЭМҮТ | Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв |
| МУБИС | Монгол Улсын боловсролын их сургууль |
| МХГ | Мэргэжлийн хяналтын газар |
| МХЕГ | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| СӨББГ | Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар |
| СӨБ | Сургуулийн өмнөх боловсрол |
| СӨБС | Сургуулийн өмнөх боловсролын сургууль |
| СБД | Сүхбаатар дүүрэг |
| СХД | Сонгинохайрхан дүүрэг |
| СХОГ | Санхүү, хөрөнгө оруулалтын газар |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| ТНБД | Төрийн нарийн бичгийн дарга |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| УБЕГ | Улсын бүртгэлийн ерөнхий газар |
| УИХ | Улсын Их Хурал |
| ХБНГУ | Холбооны Бүгд Найрамдах Герман Улс |
| ХШҮДАГ | Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газар |
| ХНХЯ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХУД | Хан-Уул дүүрэг |
| ЦЕГ | Цагдаагийн ерөнхий газар |
| ЧД | Чингэлтэй дүүрэг |
| ШУБС | Шинжлэх ухаан, боловсролын сайд |
| ЭМС | Эрүүл мэндийн сайд |
| ЭМХТ | Эрүүл мэндийн хөгжлийн төв |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |

## Хүснэгтийн товьёг


| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|---|---|
| Хүснэгт 1 | Нийслэлийн хувийн цэцэрлэгийн тоо, хамран сургалтын хувь | 23 |
| Хүснэгт 2 | Сургуулийн өмнөх насны хүүхдийн барилгын хүчин чадал, давхрын хязгаар, барилгын галд тэсвэршилтийн зэрэг хоорондын хамаарал | 26 |
| Хүснэгт 3 | Хувийн цэцэрлэгт нэмэлт элсэлтээр хамруулсан хүүхдийн судалгаа | 32 |
| Хүснэгт 4 | Олон улсын СӨБ-ын хөтөлбөрийн судалгаа | 32 |
| Хүснэгт 5 | Боловсролын үнэлгээний талаарх хууль, хөтөлбөрийн холбогдох заалтууд | 33 |
| Хүснэгт 6 | Төрийн болон хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийн 1 бүлэгт ногдож буй хүүхдийн дундаж үзүүлэлт | 36 |
| Хүснэгт 7 | Багш, ажилчдын цалингийн өсөлтийн судалгаа (мянган төгрөгөөр) | 37 |
| Хүснэгт 8 | МУБИС-ийн СӨБ-ын мэргэжлээр элсэн төгсөгчдөд төрөөс олгосон тэтгэлгийн судалгаа (сая төгрөгөөр) | 38 |
| Хүснэгт 9 | СӨБ-ын туслах ажилтан индексээр төгсгөж буй сургалтын төв, төгсөгчийн судалгаа | 41 |
| Хүснэгт 10 | СӨБ эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ (мян.төгрөгөөр) | 43 |
| Хүснэгт 11 | 2016-2018 оны Орон нутгийн төсвийн санал /21 аймаг, нийслэл (сая төгрөгөөр) | 43 |
| Хүснэгт 12 | Санхүүжих хүүхдийн тоо /2018 он/ | 44 |
| Хүснэгт 13 | Нийт урсгал зардалд тусгай зориулалтын шилжүүлгийн эзлэх дүн (сая төгрөгөөр) | 45 |
| Хүснэгт 14 | СӨБ-ын тусгай зориулалтын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төгрөгөөр) | 45 |
| Хүснэгт 15 | Хоолны зардлын зарцуулалт 2016-2018 он (тэрбум төгрөгөөр) | 46 |
| Хүснэгт 16 | Хүнс нийлүүлэгч компаниудын үйл ажиллагааны үзүүлэлт (сая төгрөгөөр) | 48 |
| Хүснэгт 17 | Хувийн цэцэрлэгт олгосон хувьсах зардлын санхүүжилт | 49 |
| Хүснэгт 18 | Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл (сая төгрөгөөр) | 51 |
| Хүснэгт 19 | Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт, шалгалтын хамарсан хүрээ | 55 |
| Хүснэгт 20 | Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт, шалгалтын зөрчлийн агуулга | 55 |


## Дүрслэлийн товьёг


| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|---|---|
| Дүрслэл 1 | Сургуулийн өмнөх боловсролын удирдлагын үндсэн чиг үүргийн хуваарилалт | 12 |
| Дүрслэл 2 | Төсвийн цаглабар | 15 |
| Дүрслэл 3 | Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн СӨБ-ын салбарын хөрөнгө оруулалтын гүйцэтгэл (сая төгрөгөөр) | 17 |
| Дүрслэл 4 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн шилжих болон шинэ цэцэрлэгийн барилгын судалгаа (сая төгрөгөөр) | 18 |
| Дүрслэл 5 | Орон нутагт шинээр барихаар төлөвлөсөн цэцэрлэгийн хүчин чадал болон хүчин чадлын хэтрэлт | 18 |
| Дүрслэл 6 | Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн СӨБ-ын салбарын гүйцэтгэл (сая төгрөгөөр) | 18 |
| Дүрслэл 7 | Улсын төсвийн хөрөнгөөр 2017-2018 онд шинээр барихаар төлөвлөсөн цэцэрлэг | 19 |
| Дүрслэл 8 | Ашиглалтад орсон цэцэрлэг (хүчин чадлаар) | 19 |
| Дүрслэл 9 | Цэцэрлэгийн хүчин чадал | 21 |
| Дүрслэл 10 | Цэцэрлэгийн хүчин чадлын зөрүү/хэтрэлт | 22 |
| Дүрслэл 11 | Анги дүүргэлтийн судалгаа | 23 |
| Дүрслэл 12 | Хувийн цэцэрлэгүүдийн хүчин чадал | 23 |
| Дүрслэл 13 | Улсын цэцэрлэгийн барилгын насжилтын судалгаа (тоогоор) | 24 |
| Дүрслэл 14 | Аймгийн цэцэрлэгүүдийн барилгын насжилтын судалгаа | 24 |
| Дүрслэл 15 | СӨБ-д 2016-2018 онд хамрагдалтын хувь (насны бүтцээр) | 29 |
| Дүрслэл 16 | СӨБ-ын хамран сургалтын байдал | 29 |
| Дүрслэл 17 | Хувилбарт сургалтын хамрагдалт, хэлбэр | 30 |
| Дүрслэл 18 | Хувилбарт сургалтын хамран сургалтын хувь | 30 |
| Дүрслэл 19 | Хүүхдийн ахицыг үнэлэх цикл | 34 |
| Дүрслэл 20 | Багшийн илүү цагийн судалгаа | 35 |
| Дүрслэл 21 | Багшийн илүү цагийн шалтгаан | 35 |
| Дүрслэл 22 | Улсын хэмжээнд СӨБ байгууллагын нийт ажилчдын судалгаа | 36 |
| Дүрслэл 23 | Дунджаар 1 багшид ногдох хүүхдийн тоог улсын хэмжээнд харьцуулсан харьцуулалт | 36 |
| Дүрслэл 24 | Улсын хэмжээнд 2015-2019 оны хичээлийн жилд ажиллаж буй мэргэжлийн багш нарын судалгаа | 38 |
| Дүрслэл 25 | СӨБ-ын байгууллагын эрхлэгч, аргазүйч, үндсэн туслах багшийн боловсролын зэргийн судалгаа /2018-2019 оны хичээлийн жил/ | 40 |
| Дүрслэл 26 | Багш ажилчдын эрүүл мэндийн үзлэгт хамрагдалтын байдал | 42 |
| Дүрслэл 27 | Багш ажилчдын эрүүл мэндийн үзлэгийн төлбөр төлдөг хэлбэр | 42 |
| Дүрслэл 28 | Төсвийн санал 2016-2018 он (сая төгрөгөөр) | 43 |
| Дүрслэл 29 | Зардлын гүйцэтгэл (тэрбум төгрөгөөр) | 45 |
| Дүрслэл 30 | Зарим нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт (төгрөгөөр) | 48 |
| Дүрслэл 31 | Цэцэрлэгийн хоолны чихэрлэг зүйлсийн дундаж хэрэглээ, илчлэгийн хэмжээ, /гр, ккал/ | 49 |

## Хавсралтын товьёг



| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|---|---|
| Хавсралт 1 | “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого” Сургуулийн өмнөх боловсролын тухай хуультай нийцэж байгаа талаарх судалгаа | 65 |
| Хавсралт 2 | Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024/, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2016, 2017, 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан зорилт, арга хэмжээний нийцэл, уялдааны харьцуулсан нэгтгэл | 66-67 |
| Хавсралт 3 | Сургуулийн өмнөх, бага боловсролын хэлтсийн 2016, 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд СӨБ-ын чиглэлээр авч хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний судалгаа | 68-69 |
| Хавсралт 4 | СӨБ хариуцсан мэргэжилтнүүдийн харьцуулалт | 70 |
| Хавсралт 5 | Улсын төсвийн хөрөнгөөр 2016-2018 онд хэрэгжихээр төлөвлөгдсөн боловч хэрэгжиж эхлээгүй төсөл, арга хэмжээ | 71 |
| Хавсралт 6 | Хөтөлбөрийн хүүхдийн ахиц, хөгжлийн үнэлгээний харьцуулалт | 71-72 |
| Хавсралт 7 | 2017-2019 онд төгссөн СӨБ-ын багш нарын дипломын хавсралт дах судалсан хичээлийн харьцуулалт | 72 |
| Хавсралт 8 | 2016-2019 оны хичээлийн жилд төрийн болон хувийн их дээд сургуульд СӨБ-ын багш мэргэжлээр суралцагчдын мэдээлэл | 73-74 |
| Хавсралт 9 | Тусгай зориулалтын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/ | 74 |
| Хавсралт 10 | Төрийн өмчийн цэцэрлэгүүдийн зардлын зарцуулалт (зардлын зүйлээр, сая төгрөгөөр) | 75 |
| Хавсралт 11 | Хүнс нийлүүлэгч компаниудын үйл ажиллагааны үзүүлэлтүүд (сая төгрөгөөр) | 76 |
| Хавсралт 12 | БСШУСЯ-аас Засгийн газрын Хяналт шинжилгээ,үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим санд Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээг хийж оруулсан үнэлгээнд хийсэн судалгаа | 77-78 |

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**

**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2019 оны 04 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын ”Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 2019 оны А/45 дугаар тушаалын дагуу “Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн”-д Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

**Аудитын зорилт**

Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүнд улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Төрөөс сургуулийн өмнөх боловсролын талаар баримталж буй бодлогыг хэрэгжүүлэх тогтолцоо оновчтой байгаа эсэх;
- Бодлогын хэрэгжилт үр нөлөөтэй, үр дүнтэй байгаа эсэх;

**Аудитын хамарсан хүрээ**

Аудитыг БСШУСЯ, ЭМЯ, БХБЯ, ХНХЯ, Сангийн яам, УБЕГ, МХЕГ, НЭМҮТ, БХТ, аймаг, нийслэлийн ЗДТГ, хот байгуулалт, хөгжлийн асуудал, Газар зохион байгуулалт хариуцсан харьяа агентлаг байгууллагууд, Боловсролын газар, төрийн болон хувийн өмчийн цэцэрлэгүүдийн 2016-2018 оны үйл ажиллагааг /сүүлийн 3 хичээлийн жил/ хамруулан гүйцэтгэлээ.

**Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100-д үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горим, асуудлын шинжилгээний дагуу БСШУСЯ, аймаг, нийслэлийн боловсролын газар, төрийн болон хувийн цэцэрлэгийн санхүү, үйл ажиллагааны тайлан, бусад шаардлагатай баримт материал, сүүлийн 3 жилийн байдлаарх үндсэн үзүүлэлтийн судалгаанд дүн шинжилгээ хийж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах зэргээр нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын бүрэлдэхүүн, хугацаа**

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор С.Оюунгэрэл удирдаж, аудитын менежер Б.Саруул чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Хишигтогтох, аудитор М.Наранжаргал, Э.Уянга, Ж.Мөнхбилгүүн, Э.Мөнхмандах нар болон орон нутаг дахь төрийн аудитын газрын аудиторууд хамтран 2019 оны 9 дүгээр сараас 12 дугаар сар хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

# БҮЛЭГ 1. ХУУЛЬД ЗААСАН ДҮРЭМ, ЖУРАМ, СТАНДАРТЫГ БҮРЭН БАТЛААГҮЙ, ЗАРИМ НОРМ НОРМАТИВ, ДҮРЭМ, ЖУРМЫГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ШИНЭЧЛЭЭГҮЙ БАЙНА

***СӨБ-ын эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй, харилцан уялдаагүй, боловсролын талаар баримтлах бодлогод тусгасан зорилт, арга хэмжээг бүрэн тусгаж төлөвлөөгүй байна***

1.1. СӨБ олгох үйл ажиллагаанд Боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай болон холбогдох бусад хууль, эрх зүйн орчны хүрээнд хамаарах 14 хууль, УИХ-аас баталсан 3 тогтоол, МУЗГ-ын 11 тогтоолыг мөрдөж байна.

1.2. СӨБ олгох үйлчилгээ нь сургуульд элсэхийн өмнөх насны бүх хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангахад чиглэгдэж Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-5.1.4-т зааснаар дараах зорилтыг үндсэн болон хувилбарт сургалтаар олгоход чиглэгдсэн байна.

- *бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болгох,*
- *хэл яриа, сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх, хүрээлэн байгаа орчин, юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох,*
- *хүүхдийн гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэн дүрслэн зурах, урлан бүтээх, дуулж хөгжимдөх, бүжиглэх чадвар эзэмшихэд туслах,*
- *хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх,бусдыг хүндэтгэн харилцах, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгаж, мэдээлэх чадвартай болох, ардын ёс заншлыг танин мэдэхэд нь туслах*

1.3. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, СӨБ олгох, үйлчилгээ үзүүлэх, холбогдох харилцааг зохицуулах чиглэлээр батлагдсан хуулиуд өөр хоорондоо болон тухайн хуулийн холбогдох заалтууд хоорондоо бүрэн уялдаагүй байна. Үүнд.

- *СӨБ-ын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “Цэцэрлэг нь Боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т заасан боловсролын стандартыг хэрэгжүүлнэ” гэж заасан ч Боловсролын тухай хуулийн 11.3 дахь заалт[1] нь хүчингүй болсон байгаа нь хууль хоорондын уялдаа хангагдаагүй;*
- *Төрийн өмчийн цэцэрлэгийн хувьд Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-т эцэг, эх, асран хамгаалагч “хүүхдэдээ тохирох цэцэрлэгийн хэв шинж, үйлчилгээний хэлбэрийг сонгох” эрхтэй байхаар заасан боловч Боловсролын тухай хуулийн 28¹ дугаар зүйлийн 28¹.1.6-д аймаг, нийслэлийн Боловсролын газар “орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох” эрхтэй байхаар заасантай уялдаагүй;*
- *Багшийн хөгжлийг дэмжих хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын нийт хувьсах зардлын хоёр хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулна”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т “Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, ААНБ эрсдэлийн түвшнээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна” гэж заасан боловч Төсвийн тухай хууль, бусад хуулиудтай хэрхэн уялдах нь тодорхойгүй;*
- *Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “хүүхдийн цэцэрлэг” гэж /цаашид “цэцэрлэг” гэх/ 2 наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх цогц үйл ажиллагаа бүхий сургалтын байгууллагыг, 7.2 дахь заалтад “Сургуулийн өмнөх боловсролд 2 наснаас сургуульд элсэх хүртэлх насны бүх хүүхдийг хамруулна” гэж, мөн хуулийн 9.7 дахь заалтад ”Цэцэрлэг нь эцэг, эх, асран хамгаалагчийн санал, хүсэлтэд үндэслэн Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8.7, 8.8, 8.9, 8.10-т заасан нөхцөл бүрдсэн тохиолдолд 2 хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж болно” гэж тус тус заасан нь харилцан уялдаагүй байна.*

1.4. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3[2]-д заасны дагуу БСШУСС-ын 2013 оны А/327 дугаар тушаалаар баталсан “*Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого*” нь үндсэн зорилгоо тодорхойлоогүй, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулиар тодорхойлсон агуулга, стандартыг бүрэн тусгаагүй, хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдтэй нийцүүлэн шинэчлэн боловсруулаагүй, зохион байгуулалтын шинжтэй байна. */Дэлгэрэнгүйг Хавсралт 1-с үзнэ үү/* Тухайлбал,

[1] 11.3 дахь заалтыг 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан, 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан, 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.

[2] СӨБ-ын тухай хууль 5.3 Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлоготой байх

- *Бодлогын зорилгыг тодорхойлоогүйгээс Хуулийн 3.1-т заасан “Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэсэн зорилготой нийцсэн эсэх нь тодорхойгүй;*
- *Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-т “... ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болгох...”, 5.1.4-т “... хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгаж, мэдээлэх чадвартай болох, ардын ёс заншлыг танин мэдэхэд...” гэж заасныг бүрэн тусгаагүй;*

## Хуульд заасан дүрэм, журам, стандартыг боловсруулаагүй, хуульд нийцүүлэн зарим норм норматив, дүрэм, журмыг шинэчлэн тогтоогоогүй байна

1.5. Төрөөс СӨБ олгох, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан Боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд заасан 6 дүрэм, 8 журам, 6 стандарт, 4 норм норматив, холбогдох хөтөлбөрийг тус тус боловсруулж баталж, мөрдүүлэхээр зааснаас салбарын яам, холбогдох яамдтай хамтран 2 дүрэм[3], 1 журам[4], 3 стандарт, 4 норм норматив[5]-ийг баталсан байна.

1.6. Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2016 оны 13 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол, бага насны хүүхдийн хөгжлийн MNS 5420-1:2011” стандарт хүчингүй болсон, мөн дараах холбогдох норм норматив, дүрэм, журмыг хуульд нийцүүлэн шинэчлэн батлаагүй байна. Тухайлбал,

- *Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-т “...нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно” гэж заасны дагуу МУЗГ-ын 2012 оны 94 дүгээр, 2016 оны 242 дугаар тогтоолоор баталсан ч уг итгэлцүүрийг жил бүр шинэчлээгүй;*
- *МУЗГ-ын 2012 оны “Хоолны зардлын дундаж норматив батлах тухай” 106 дугаар тогтоолд заасан цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын хэмжээг үнийн өсөлт, инфляцын түвшинтэй уялдуулан шинэчлэн батлаагүй;*
- *БСШУСС, Сангийн сайдын хамтран баталсан 2017 оны А/167/292 дугаар “Орон тооны жишиг норматив батлах тухай” тушаалыг дээрх сайд нарын хамтарсан 2018 оны А/024/11 тушаалаар хүчингүй болгож “Төрийн болон орон нутгийн өмчийн ЕБС-ийн багшаас бусад захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны шинэчилсэн норматив”-ыг баталсан нь СӨБ олгох, үйлчилгээ үзүүлж буй байгууллагад хамааралгүйгээс СӨБ-ын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8[6]-д заасан хуулийн шаардлагыг хангаагүй;*
  *ШУБС, Сангийн сайдын 1995 оны 227/199 дүгээр хамтарсан тушаалаар “Хүүхдийн цэцэрлэгийн захиргаа-үйлчилгээний ажилтны орон тооны үлгэрчилсэн норматив” баталсан ч[7] БСШУСС, Сангийн сайдын 2018 оны А/817/287 дугаар тушаалаар хүчингүй болгосон;*
- *БСШУС-ын 2003 оны 321 дүгээр тушаалаар баталсан “ЕБС, цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх тоон болон чанарын шалгуур үзүүлэлт”, 2008 оны 68 дугаар тушаалаар баталсан “Хүүхдийн цэцэрлэгийн аюулгүй байдлын дүрэм”, 2012 оны А/131 дүгээр тушаалаар баталсан “Сургуулийн өмнөх боловсролыг эзэмшүүлэх хувилбарт сургалт зохион байгуулах журам” зэргийг Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, сургалтын хөтөлбөр, орчны стандарттай нийцүүлэн шинэчлээгүй байна.*

1.7. СХЗГ-ын техникийн хороогоор 2019 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр *“Цэцэрлэг, ЕБС түүний дотуур байрны орчны эрүүл ахуйн шаардлага”* стандартыг хэлэлцсэн гэсэн шалтгаанаар Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 “*...эрүүл ахуй, ариун цэврийн дүрмийг...батална*” гэсэн заалт хэрэгжээгүй байна.

1.8. БСШУСЯ нь дангаар болон бусад яамтай хамтран Боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд заасан 4 дүрэм, 7 журам, 3 стандартыг баталж мөрдүүлээгүй, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна Үүнд:

***Дүрэм:***
- *Тусгай болон сувиллын цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм / БСШУСЯ, ЭМЯ/*
- *Асрамжийн болон халамжийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм /БСШУСЯ, ХНХЯ/*

---

[3] Цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм, Хүүхдийн цэцэрлэгийн аюулгүй байдлын дүрэм /БСШУС-ын 2015 оны 405 дугаар, 2008 оны 68 дугаар тушаал/
[4]Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам,
[5] Хоолны зардлын дундаж норматив,СӨБ-ын байгууллагын сургалтын орчин стандартын 5.2 “...барилга байгуулам”, 6 дугаар бүлэг сургалтын хэрэглэгдэхүүнд
[6] Цэцэрлэгт эрхлэгч, арга зүйч, багш, туслах багш, эмч, тогооч болон үйлчилгээний бусад ажилтан ажиллана.
[7] Сангийн сайдын 2012 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 156 дугаар тушаалаар “Орон тооны жишиг тогтоох аргачлал, орон тооны дээд жишиг норматив” баталсан ч уг тушаалыг хүчингүй болсон тухай мэдэгдлийг ЗГХЭГ-т 2012 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хүргүүлсэн

- *Цэцэрлэг, түүний байрны орчны эрүүл ахуй, ариун цэврийн дүрэм /БСШУСЯ /*
- *Багшийн ёс зүйн хорооны дүрэм /БСШУСЯ /*

***Журам:***

- *Цэцэрлэгийн багшид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, ажил, мэргэжлийн онцлогоос шалтгаалан нэмэгдэл цалин олгох журам /Засгийн газар/*
- *Багшид ажлын гүйцэтгэлд суурилсан урамшууллыг олгох журам /Засгийн газар/*
- *Хүүхдийн чадвар,чадамж,хөгжлийн ахицыг үнэлэх журам /БСШУСЯ/*
- *Цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг үнэлэх журам /БСШУСЯ/*
- *СӨБ эзэмшүүлэхэд шаардагдах ном, гарын авлага, сургалтын үзүүлэн зохиох, хэвлүүлэх, түгээх журам /БСШУСЯ/*
- *Цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам /БСШУСЯ/*
- *Багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журам /БСШУСЯ, ХНХЯ/*

***Стандарт:***

- *Цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний эрүүл, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн стандарт /БСШУСЯ, холбогдох яамд/*
- *Тусгай цэцэрлэгт ажиллаж байгаа нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог тогтооно. /БСШУЯ, ХНХЯ,Сангийн яам/*
- *"Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрны орчны эрүүл ахуйн шаардлага" /БСШУЯ, ЭМЯ /*

***Журам:***

- *Цэцэрлэгийн багшид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, ажил, мэргэжлийн онцлогоос шалтгаалан нэмэгдэл цалин олгох журам /Засгийн газар/*
- *Багшид ажлын гүйцэтгэлд суурилсан урамшууллыг олгох журам /Засгийн газар/*
- *Хүүхдийн чадвар,чадамж,хөгжлийн ахицыг үнэлэх журам /БСШУСЯ/*
- *Цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг үнэлэх журам /БСШУСЯ/*
- *СӨБ эзэмшүүлэхэд шаардагдах ном, гарын авлага, сургалтын үзүүлэн зохиох, хэвлүүлэх,түгээх журам /БСШУСЯ/*
- *Цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам/БСШУСЯ/*
- *Багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журам /БСШУСЯ, ХНХЯ/*

***Стандарт:***

- *Цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний эрүүл, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн стандарт /БСШУСЯ, холбогдох яамд/*
- *Тусгай цэцэрлэгт ажиллаж байгаа нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог тогтооно. /БСШУЯ, ХНХЯ,Сангийн яам/*
- *"Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрны орчны эрүүл ахуйн шаардлага" /БСШУЯ, ЭМЯ /*

1.9. БСШУСЯ холбогдох хуульд заасан дүрэм, журам, стандарт, нормативыг баталж мөрдүүлээгүй нь салбарын сайд, СӨББГ-ын удирдлага удаа дараа солигдсон, хүний нөөц тогтвор суурьшилгүй, шилжилт, хөдөлгөөн ихтэй, ажлын төлөвлөлт хангалтгүй, тухайн мэргэжилтний мэдлэг мэргэжил, ажлын хариуцлага сулаас шалтгаалсан бөгөөд энэ нь дараах хүндрэлийг үүсгэж байна. Үүнд:

- *Тусгай цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэмгүйгээс БЗД-ийн 10 дугаар, СБД-ийн 186 дугаар тусгай цэцэрлэгүүд нь үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн зохицуулалтгүй, ердийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийг үндэслэн өөрийн онцлогийг тусгасан цэцэрлэгийн дүрмийг боловсруулсан;*
- *Тусгай цэцэрлэгт ажиллаж байгаа нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо*[8]*, харьцааг тодорхой зааж өгөөгүйгээс Дархан-уул аймгийн 7 дугаар цэцэрлэгийн тусгай бүлэгт "Хүүхдийн сэргээн засалт, хөгжлийн төвийн бүтэц, үйл ажиллагаа, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлагыг"*[9] *баримтлан ажилладаг;*
- *Завхан аймгийн Улиастай сумын 2 дугаар цэцэрлэгийн дэргэд 2019 оноос хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан 1 бүлэг шинээр нээж ажиллуулсан ч боловсон хүчин бэлтгэгдээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгт хамруулах, түүний харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдээгүйгээс ажиллах боломжгүй;*
- *Сувиллын цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэмгүйгээс СХД-ийн 41 дүгээр цэцэрлэг нь СӨБ олгох үйлчилгээг үзүүлдэггүй, эрүүл мэндийн чиглэлээр сувилахуйн үйл ажиллагааг явуулах чиг үүрэгтэй;*
- *Цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг үнэлэх журамгүйгээс үйлчилгээний чанарыг үнэлэх боломжгүй;*
- *Цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний эрүүл, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн стандартгүйгээс төрийн өмчийн цэцэрлэгүүдэд нийлүүлэгдэж буй хүнсний эрүүл, аюулгүй байдалд тавих хяналт бүрэн хэрэгжихгүй байна. Тухайлбал, Нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгүүдэд хүнс нийлүүлж буй "Өсвөр үе хүнс", "Багачууд*

[8] СӨБ-ийн тухай хуулийн 8.14-т "СӨБ олгож байгаа байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамаарч тусгай мэргэжлийн багш, туслах багш, эмч, сэргээн засалч, нийгмийн ажилтан ажиллуулж болно"
[9] Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны 58 дугаар тогтоолоор баталсан MNS 6419:2013 үндэсний стандарт

*хүнс", "Асгат" "Хүнс хангамж" ОНӨААТҮГ нь мах, хүнсний ногоог бэлтгэн нийлүүлэхдээ тухайн бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн бичгийг үндэслэдэг байна.*

1.10. БСШУС, Сангийн сайдын 2008 оны хамтарсан 56/64 дүгээр тушаалаар "*Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сангийн үлгэрчилсэн дүрэм*"-ийг баталж, цэцэрлэг сантай байж болохоор заасан нь Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.11[10] дэх заалттай нийцэхгүй байна.

***СӨБ-ын зорилгод нийцсэн Сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулан мөрдүүлж байна***

1.11. БСШУСС-ын 2015 оны А/301 дүгээр тушаалаар "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр"-ийг баталж, уг хөтөлбөрийн зорилго, зорилтыг Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т "*Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино*" заасантай нийцүүлэн тодорхойлсон байна.

1.12. Цэцэрлэг нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр БСШУС-ын 2005 оны 405 дугаар тушаалаар баталсан "Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм"-д нийцүүлэн өөрийн хэв шинж, үйл ажиллагааны онцлогт тохирсон, удирдлага зохион байгуулалт, сургалтын үйл ажиллагаа, орчин, багш, бусад ажилтан, эцэг эх, асран хамгаалагчийн эрх, үүргийн талаар тусгасан дүрэм боловсруулж мөрдөхөөр заасан ч зарим цэцэрлэгийн дүрэм үлгэрчилсэн дүрэмд нийцээгүй, зарим цэцэрлэг нь дүрэм боловсруулж батлаагүй байна. Тухайлбал,

- *Улаанбаатар хот: аудитад хамрагдсан хувийн "Тэнүүн төгөл", "Глобал", "Хүүхэд-Эрдэнэ" зэрэг цэцэрлэгүүдийн дүрэм үлгэрчилсэн дүрэмд нийцээгүй, "Булганзул", "Хараацай", "Бяцхан ход ход" цэцэрлэгүүд нь цэцэрлэгийн дүрэмгүй;*
- *Хэнтий аймаг: 8 дугаар цэцэрлэг, "Жүржхэн" цэцэрлэг нь цэцэрлэгийн дүрэмгүй;*
- *Орхон аймаг: Цэцэрлэгүүд дүрмээ боловсруулахдаа өөрийн цэцэрлэгийн онцлогийг тусгаагүй;*
- *Увс аймаг: цэцэрлэгийн дүрмийг баталгаажуулсан хүний гарын үсэг, тамга тэмдэггүй, нийтлэг үндэслэлийг тодорхойлоогүй, сургалтын орчны стандарт, ногоон байгууламж, эцэг эх асран хамгаалагчийн талаар тодорхой заалтуудыг тусгаагүй;*
- *Сэлэнгэ аймаг: 15 цэцэрлэг нь цэцэрлэгийн дүрэмд өөрийн онцлогийг тусгаагүй;*
- *Баянхонгор аймаг: Богд, Баацагаан сумдын цэцэрлэг цэцэрлэгийн дүрмийг боловсруулсан ч батлаагүй, Жинст, Баян-Овоо, Бууцагаан сумын Баянбүрдийн бага цэцэрлэг нь цэцэрлэгийн дүрэмгүй.*

***СӨБ олгох бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг хөтөлбөр, үндсэн чиглэлд бүрэн тусгаж боловсруулаагүй, уялдуулаагүй байна***

1.13. УИХ-ын 2015 оны 12 дугаар тогтоолоор "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024 он/-ыг баталсан ч түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулаагүй нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйл 8.5[11]-д заасантай нийцээгүй байна.

1.14. Дээрх тогтоолын 2-т "*Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого*"-ын стратегийн зорилтыг Монгол Улсын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэх гэж заасан ч Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2016, 2017, 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд бодлогын баримт бичгийн 3.8[12], 3.18[13]-ыг бүрэн тусгаагүй байна. */дэлгэрэнгүй хавсралт 2-с үзнэ үү/*

1.15. Уг бодлогын 5.1-т "*Багш бэлтгэх сургалтын байгууллагын хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчныг сайжруулж, бүх талын дэмжлэг үзүүлнэ*", 5.3-т "*Боловсролын мэргэшсэн удирдах болон бусад ажилтныг хүний нөөцийн төлөвлөлт, бодлоготой уялдуулан сургаж бэлтгэх, дадлагажуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ*" гэж

[10] 39.11.Сургалтын байгууллага нь сургууль хөгжүүлэх сантай байж болох бөгөөд сангийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.
[11] Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль 8.5. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ.
[12] 3.8 Боловсролын байгууллагад өмчийн хэлбэр харгалзахгүй адил тэгш шаардлага тавьж, хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлнэ
[13] 3.18 Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ, дотоод мониторингийн тогтолцоог хөгжүүлнэ

заасныг хэрэгжүүлэх хөтөлбөргүй, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан төлөвлөөгүй байна.

1.16. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын 1 дэх[14] заалтыг хэрэгжүүлэхдээ I үе шатны[15] хүрээнд зорилгоо хангах арга хэмжээг бүрэн төлөвлөөгүй байна. Тухайлбал,

- *"Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын Зорилт 1-т "Хүүхэд бүрийг ... монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшүүлнэ" гэсэн зорилтыг хангахуйц арга хэмжээг Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016, 2017, 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд бүрэн тусгагдаагүй.*

1.17. УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан *"Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр" болон уг хөтөлбөрийг* хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөний 3.2.2-т *"Хүүхэд бүр цэцэрлэгт" хөтөлбөрийг хэрэгжүүлж хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгоно"* гэсэн зорилтыг хэрэгжүүлэх бие даасан хөтөлбөр боловсруулж батлаагүй, МУЗГ-ын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн жагсаалтад тусгагдаагүй байна.

1.18. Дээрх тогтоолын 2-т *"Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган хэрэгжүүлэх"* гэж заасан ч Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2016, 2017, 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд зорилтыг хангахуйц арга хэмжээг бүрэн тусгаж төлөвлөөгүй байна. */дэлгэрэнгүй хавсралт 2-с үзнэ үү/* Тухайлбал,

- *3.2.7-д "Цэцэрлэг, сургуулийн орчин гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагчтай болгоно";*
- *3.2.9-д " Боловсролын түвшин, чиглэл тус бүрээр үнэлгээний систем, шалгуур, аргачлалыг хянан сайжруулж үйлчилгээний чанар, үр дүнг эцэг, эх, суралцагчдын оролцоотой үнэлэх боломжтой болгоно";*
- *3.2.15-д "Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд хүүхдийг хүнлэг, эх оронч, үндэсний ухамсар, бахархалтай иргэн болж төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, хүмүүжил олгох агуулгыг тусган хэрэгжүүлнэ";*
- *3.2.3-д "Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид шилжүүлнэ" заасан зорилтыг хангах хүрээнд СӨБ олгох, үйлчилгээ үзүүлэх хүрээнд цэцэрлэгийн ачааллыг бууруулах арга хэмжээ тусгагдаагүй.*

1.19. БСШУСЯ нь 2016-2018 онд боловсролын мастер төлөвлөгөөгүй ажилласан бөгөөд Монголын Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөний хэрэгжилтэд тус яамны зүгээс үнэлгээ хийсэн гэх боловч баримтаар нотлогдохгүй байна.

1.20. МУЗГ-ын 2016 оны "Зарим яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах" тухай 91 дүгээр тогтоол[16], МУЗГ-ын 2017 оны *"Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"* тухай 267 дугаар тогтоолоор СӨБ-ын бодлогын газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, стратегийн зорилт, гол зорилт, гүйцэтгэх үндсэн үүрэг, чиг үүргийг тодорхойлж өгсөн байна. Үүнд:

- ***Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл**: СӨБ-ын сургалтын чанарыг дээшлүүлэх, өрсөлдөх чадвартай хүний нөөц бэлтгэх, багш бэлтгэх тогтолцоог хөгжүүлэх;*
- ***Үйл ажиллагааны стратегийн зорилт**: Боловсролын хөгжлийн бодлогын шинжилгээ хийх, хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;*
- ***Үйл ажиллагааны гол зорилт:** СӨБ-ын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бодлогын шинжилгээ хийх, хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, сургалтын агуулга, арга зүй, үнэлгээ, сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсронгуй болгох, салбарын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, хүний нөөцийг хөгжүүлэх, бодлогын хэрэгжилтийг хангахад зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх, бодлогын удирдамжаар хангах.*

[14] "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр,Эдийн засаг,нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл,улсын төсөвт тусган үе шаттайгаар хэрэгжүүлэх"
[15] **I үе шат (2016-2020):** СӨБ-ын тогтолцооны төрөл хэлбэрийг өргөтгөж, хүртээмж, чанарыг сайжруулан СӨБ-ын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 70 хувийг хамруулах нөхцөл бүрдүүлэх.
[16] МУЗГ-ын 2017 оны 267 дугаар тогтоолоор хүчингүй болгосон

1.21. Гэтэл СӨБ-ын бодлогын газрын 2017 оны[17] үйл ажиллагааны төлөвлөгөөнд нэгжийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл[18], стратегийн зорилтод[19] тусгасан гол зорилтыг хангахуйц арга хэмжээг бүрэн төлөвлөөгүй, бага дунд боловсролыг хөгжүүлэх чиглэлд түлхүү хандуулсан байна. */дэлгэрэнгүй хавсралт 3-с үзнэ үү /* Тухайлбал,

- *Бага, дунд боловсролын суралцагчийн үнэлгээний журмыг шинэчлэн боловсруулна /2017 он/*
- *Бага боловсролын түвшинд сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа хийнэ. /2017 он/*

1.22. Зарим аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, салбарын яамтай байгуулсан гэрээнд МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2[20], 3.2.3[21], 3.2.7[22]-т заасан арга хэмжээг бүрэн тусгаж төлөвлөөгүй, уялдуулаагүй байна. Тухайлбал,

- *Дундговь аймаг - Бүх сумдад гэр цэцэрлэг, зайны болон зуны сургалт, ээлжийн бүлэг ажиллуулж малчдын хүүхдийг, 5 настай хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулах, багш нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах бодлого,чиглэлтэй холбоотой асуудлыг тусгаагүй;*
- *Сүхбаатар аймаг - СӨБ-ын байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжих боломжтой, тодорхой, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлтээр дэвшүүлээгүй, хөтөлбөрийг МУЗГ, салбар яамдын бодлого, чиг үүрэгтэй уялдуулж чадаагүй;*
- *Булган аймаг - Цэцэрлэгийн орчны гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камержуулалтын талаар авах хөрөнгө оруулалтын арга хэмжээ тусгагдаагүй;*
- *Баян-өлгий аймаг - "Цэцэрлэгийн орчин гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагчтай болгоно" гэсэн арга хэмжээг төлөвлөөгүй байна.*

## ***Яамны газар, нэгжүүдийн чиг үүрэгт боловсролын салбарын нэгдсэн бодлого, стратеги, хөтөлбөрийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, зохицуулах чиг үүрэг тусгагдаагүй байна***

### ***Боловсролын салбарын мэдээллийн технологи хариуцсан нэгжийг бий болгох шаардлагатай байна***

1.23. Боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-т "*Боловсролын удирдлага нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага[23], засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага[24], боловсролын байгууллагын[25] болон түүний өөрийн удирдлагаас[26] бүрдэнэ*" гэж заасан байна.

[17] Сургуулийн өмнөх, бага боловсролын хэлтэс нэртэй 2017 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-нд хийх үйл ажиллагааны төлөвлөгөө

[18] СӨБ-ын сургалтын чанарыг дээшлүүлэх, өрсөлдөх чадвартай хүний нөөц бэлтгэх, багш бэлтгэх тогтолцоог хөгжүүлэх;

[19] Боловсролын хөгжлийн бодлогын шинжилгээ хийх, хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;

[20] "Хүүхэд бүр цэцэрлэгт" хөтөлбөрийг хэрэгжүүлж хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгоно."

[21] "Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид шилжүүлнэ.",

[22] "Цэцэрлэг, сургуулийн орчин гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагчтай болгоно."

[23] Боловсролын тухай хуулийн 27.2 Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь аймаг, нийслэлд боловсролын газар, нийслэлийн дүүрэгт боловсролын хэлтэс байна.

[24] Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 7.1.1 аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, 7.1.2 баг, хорооны иргэдийн Нийтийн хурал 7.1.3 Энэ хуулийн 7.1.1, 7.1.2-т заасан Хурлын хуралдааны чөлөө цагт тэдгээрийн Тэргүүлэгчид 7.1.4 аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга

[25] Боловсролын тухай хуулийн 33 дугаар зүйл Боловсролын сургалтын байгууллагын удирдлага: 33.1.Өмчийн бүх хэлбэрийн боловсролын сургалтын байгууллагыг үүсгэн байгуулагч буюу түүний эрх олгосон этгээдийн томилсон захирал, эрхлэгч удирдана.

[26] Боловсролын тухай хуулийн 34 дүгээр зүйл Боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлага 34.1.Боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлагыг ... цэцэрлэгийн зөвлөл, ... хэрэгжүүлнэ.

*Дүрслэл 1. Сургуулийн өмнөх боловсролын удирдлагын үндсэн чиг үүргийн хуваарилалт*

| | |
|---|---|
| Засгийн газар | • 1 хүүхдэд ногдох хувьсах зардлын нормативыг батлах,<br>• багш ажилтнуудад олгох нэмэгдэл цалин, үр дүнгийн урамшууллын хэмжээ, олгох журмыг батлах<br>• Хоолны зардлын улсын төсвөөс санхүүжүүлэх хувь, хэмжээг тогтоох, |
| Салбарын яам | • СӨБ-ын цөм хөтөлбөр,сургалтын бодлого, харьяа байгууллагын бүтэц, дүрэм, СӨБ-ын үйлчилгээнд мөрдөх үлгэрчилсэн дүрэм,журам, стандарт, норм норматив, ёс зүйн дүрэм, нийтлэг шаардлага, ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт зэргийг дангаараа эсхүл бусад яамтай хамтран батлах,<br>• боловсролын хөгжлийн ойрын болон хэтийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх<br>• Хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, |
| Аймаг, нийслэлийн ИТХ | • Аймаг, нийслэлд шинээр барих сургууль, цэцэрлэгийн урт хугацааны төлөвлөлтийг газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж, эзэмшил, ашиглалтын эдэлбэр газрыг шаардлагад нийцсэн талбайн хэмжээний дагуу нөөцөд авах шийдвэр гаргах |
| Аймаг, нийслэлийн Засаг дарга | • Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох<br>• орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах, эрхлэгчийг томилох, төлөөлөх<br>• Зориулалтын барилга байгууламжаар хангах, боловсролын байгууллагад дэмжлэг үзүүлэх, хичээлийн байр, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном, сурах бичгээр хангах ажлыг зохион байгуулах |
| Сум, дүүргийн Засаг дарга | • боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;<br>• хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх ажлыг захиргааны удирдлагаар хангах;<br>• төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх; |
| Боловсролын газар, хэлтэс | • боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах;<br>• тухайн нутаг дэвсгэрийн цэцэрлэгт удирдлагын болон мэргэжлийн туслалцаа үзүүлэх,<br>• боловсролын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх;<br>• тайлан, мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад гаргаж өгөх;<br>• орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хамран сургах тойрог тогтоох;<br>• багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах. |
| Цэцэрлэгийн зөвлөл | • цэцэрлэгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам батлах,<br>• дэг журам, дотоод зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох;<br>• үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх;<br>• эрхлэгчийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, дэмжлэг үзүүлэх;<br>• сургалтын төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу тогтоох.<br>• цэцэрлэгийн хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд санал өгөх,<br>• батлагдсан төсөв, сангийн зарцуулалтад хяналт тавих, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлттэй танилцах, мэдээлэх |
| Цэцэрлэгийн эрхлэгч | • боловсролын талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, биелэлтийг дүгнэх, тайлагнах;<br>• цэцэрлэгийг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх;<br>• багш, ажилтныг сонгон авч ажиллуулах, өөрчлөх, чөлөөлөх;<br>• төсөв, санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, төсөв хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах;<br>• санхүү, нягтлан бодох бүртгэл, статистикийн мэдээ, тайланг хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь гаргах<br>• стандарт, норм, норматив, багшийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулах. |

*Эх сурвалж: Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль*

1.24. МУЗГ, салбарын яам, аймаг, нийслэлийн НИТХ, Засаг дарга, Боловсролын газар, хэлтэс болон цэцэрлэгийн СӨБ олгохтой холбоотой үндсэн чиг үүргийг Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд дээрх байдлаар тодорхойлсон байна.

1.25. Гэвч аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагуудын зүгээс тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцахад цэцэрлэгийн зөвлөл байгуулагдаагүй, үйл ажиллагаа жигдрээгүй байдал түгээмэл ажиглагдаж байгаа нь хуулиар тодорхойлсон чиг үүрэг бүрэн хэрэгжихгүй байгааг харуулж байна. Тухайлбал,

- *Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн цэцэрлэгүүдийн хувьд тухайн шатны дүүргийн Засаг дарга төрийг төлөөлөх гишүүдийг томилоогүй, хувийн цэцэрлэгүүдийн хувьд хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй зэргээс түүвэрт хамрагдсан 100 цэцэрлэгийн 23 хувьд цэцэрлэгийн зөвлөл байгуулагдаагүй;*
- *Хөвсгөл, Говь-сүмбэр дахь Төрийн аудитын байгууллагаас тухайн аймагт үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэгүүдийн цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах зөвлөмж өгсөн байна*

1.26. Боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т заасан СӨБ-ын сургалтын байгууллага нь цэцэрлэг, цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор байхаар заасан хэдий ч цогцолборын бүтэц, түүний удирдлагын талаар тодорхой зохицуулалтгүй, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 3 цэцэрлэг-бага сургуулийн цогцолбор нэгдсэн удирдлагагүй сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

***Газар, нэгжүүдийн чиг үүрэгт нэгдсэн бодлого, стратеги, хөтөлбөрийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, зохицуулах чиг үүрэг тусгагдаагүй байна***

1.27. МУЗГ-ын 2016 оны 3 дугаар тогтоол, 2018 оны 58, 370 дугаар тогтоолоор яамдын зохион байгуулалтын бүтцийг батлахдаа БСШУСЯ нь СӨБ, ерөнхий боловсрол, дээд боловсролын бодлогын газруудтай, бусад яамдын хувьд нэгдсэн бодлого төлөвлөлтийн газартай байхаар баталсан байна.

1.28. Гэвч МУЗГ-ын 2016 оны 91 дүгээр тогтоолоор баталсан "*БСШУСЯ-ны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр*" нь яамны бүтэцтэй нийцээгүй байсан бөгөөд МУЗГ-ын 2017 оны 267 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт боловсролын талаарх нэгдсэн бодлого, стратеги, хөтөлбөрийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, зохицуулах чиг үүрэг тусгагдаагүй байна.

1.29. БСШУСЯ нь 2013-2019 онд боловсролын салбарт мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, мэдээллийн сан бий болгох БУМС-ийг улсын төсвийн нийт 5.1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хөгжүүлж эхэлсэн бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилээс цэцэрлэгийн үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийг бодит регистрийн дугаарт үндэслэн улсын хэмжээнд давхцалгүйгээр бүртгэхэд ашиглаж эхэлсэн байна.

1.30. Уг систем нь СӨБ, ерөнхий боловсрол, их дээд боловсролын нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, сургалтын байгууллагын хүний нөөц, суралцагчдын бүртгэл, статистик тайлан боловсруулалт, шилжилт хөдөлгөөн, боловсролын бичиг баримтын лавлагаа зэрэг үйл ажиллагааг явуулах боломж олгож байгаа ч системийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлт, зүгшрүүлэлт зэргийг 9-25 иргэн 1 жилийн хугацаатай зөвлөх үйлчилгээний гэрээгээр гүйцэтгэж иржээ.

1.31. МУЗГ-ын 2016 оны 3 дугаар тогтоолоор баталсан БСШУСЯ-ны зохион байгуулалтын бүтцэд Мэдээллийн технологи, статистикийн хэлтэстэй байхаар тусгагдсан ч Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Шинжлэх ухаан, технологийн бодлого, зохицуулалтын газар тус бүр 1 мэргэжилтэнтэй ажиллаж байсан төдийгүй МУЗГ-ын 2017 оны 206 дугаар тогтоолоор баталсан БСШУСЯ-ны зохион байгуулалтын шинэчилсэн бүтцэд Мэдээллийн технологи, статистикийн хэлтэсгүй байхаар тусгажээ.

1.32. МУЗГ-ын 2019 оны 161 дүгээр тогтоолоор Мэдээллийн технологи, статистикийн хэлтэстэй байхаар баталсан болович өнөөдрийг хүртэл хүний нөөц бүрэн бүрдээгүй, 4 орон тоо бүхий тус хэлтэс мэргэжлийн программистын хүрэлцээ, санхүүгийн нөөц, статусын хувьд боловсролын мэдээллийн нэгдсэн системийн боловсруулалт, хөгжүүлэлт, хэвийн үйл ажиллагааг хариуцах боломжгүй байна.

- *Уг системийг хөгжүүлэхтэй холбоотойгоор АХБ, улсын төсвийн хөрөнгөөр 2012-2016 онд 4.3 тэрбум төгрөгийн сервер, тоног төхөөрөмж худалдан авсан болович сүүлийн жилүүдэд төхөөрөмжийг шинэчлэх, мэргэжлийн байгууллагаар байнгын засвар үйлчилгээ хийлгэх хөрөнгө батлагдаагүйгээс өнөөдөр нөөц сервергүй ажиллаж, системийн хэвийн үйл ажиллагаа алдагдах, гадны халдлагад өртөх, хэрэглэгчдийн мэдээлэл алдагдах эрсдэлтэй байна.*

1.33. Иймд БУМС, мэдээллийн сан, бүх шатны боловсролын байгууллагуудыг хамарсан нэгдсэн сүлжээний хөгжүүлэлт, сайжруулалт, ашиглалт, аюулгүй, найдвартай, тогтвортой байдлыг хариуцан ажиллах чиг үүрэгтэй, мэдээллийн технологийн мэргэшсэн мэргэжилтнүүд тогтвор суурьшилтай ажиллах боломж бүхий бүтцийг бий болгох шаардлагатай байна.

***Яамны аппаратын хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн их, газрын даргаар үүрэг гүйцэтгэгч ажиллах явдал нийтлэг байна***

1.34. Аудитын хамрах хугацаанд салбарын сайд 3 удаа солигдсон, яамны газар хэлтсийн дарга нар /*2016 онд 6 газар, 7 хэлтэс, 2017 онд 7 газар, 1 хэлтэс, 2018 онд 8 газар, 3 хэлтэс*/ үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байсан, Сургуулийн өмнөх, бага боловсролын хэлтэс 2016 онд 3

орон тоотой, СӨББГ 2017-2018 онд 5-6 орон тоотой, нэгжийн дарга, мэргэжилтнүүд тогтвор суурьшил муутай ажиллаж иржээ. /*Дэлгэрэнгүйг Хавсралт 4-с үзнэ үү*/

1.35. Төрийн албаны зөвлөлийн 2018 оны 78 дугаар тогтоолоор тус яаманд хяналт, шалгалт хийсэн дүнг үндэслэн "*хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд Төрийн албаны тухай хууль тогтоомжийг баримтлахгүй байна*" гэж дүгнэсэн бөгөөд Төрийн албаны тухай хууль, "*Төрийн жинхэнэ удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам*"-ыг зөрчиж томилогдсон нийт 21 албан тушаалтныг хууль тогтоомжид нийцүүлэн сонгон шалгаруулалтаар нөхөхийг даалгасан боловч 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бүрэн биелүүлээгүй байна. Тухайлбал,

- *Сул ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулах – Дээд боловсролын бодлогын газрын дарга, СӨББГ-ын дарга, Соёл урлагийн бодлогын газрын дарга, Олон улсын төсөл хөтөлбөр гадаад хамтын ажиллагааны газрын дарга;*
- *Сул ажлын байрны "дүгнэлт гаргуулах сонгон шалгаруулалт"-аар нөхөх – СХОГ-ын дарга, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;*
- *Төрийн албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалт өгөөгүй нийт 15 албан хаагч.*

1.36. НБГ-ын СӨБ хариуцсан мэргэжилтэн нь орон нутаг дахь БСУГ-ын СӨБ хариуцсан мэргэжилтнээс 3-5 дахин олон цэцэрлэг хариуцан ажиллаж байгаагаас хууль тогтоомжид заасан чиг үүрэг бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна. Тухайлбал,

- *Аймгийн БСУГ-ын СӨБ хариуцсан мэргэжилтэн дунджаар 35 цэцэрлэг хариуцаж байхад нийслэлийн БГД, БЗД, СХД-ийн 1 мэргэжилтэн 108-192 цэцэрлэг хариуцаж байна;*
- *Нийслэлийн хэмжээний бүх цэцэрлэгүүдийн хүүхдийн хоолны үйлдвэрлэл, эрүүл мэндийн үйлчилгээ, эрүүл ахуй аюулгүй байдал зэргийг НБГ-т эрүүл ахуй, аюулгүй байдлын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан 1 мэргэжилтэн хариуцаж байна.*

1.37. Боловсролын тухай хуульд 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр сум, дүүргийн Засаг даргад цэцэрлэгийн эрхлэгчийг томилох, чөлөөлөх эрх олгосон бөгөөд уг нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр байна.

1.38. Зарим аймгийн БСУГ нь байгууллагын ажиллах журмыг боловсруулж батлуулаагүй, хуульд заасан чиг үүргийг ажилтны ажлын байрны тодорхойлолтод бүрэн тусгаагүй, СӨБ хариуцсан мэргэжилтэнгүй байгаа зэргээс тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэгүүдийг мэргэжлийн арга зүй, удирдлагаар хангах, ажлын үр дүнд дүн шинжилгээ хийх, ажлын гүйцэтгэл, ур чадварыг сайжруулах арга хэмжээ авах, дотоод хяналт хэрэгжүүлэх чиг үүргүүд бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна. Тухайлбал,

- *Дундговь, Дорноговь аймгийн БСУГ нь Боловсролын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4*[27]*-д заасны дагуу БСШУС-ын 2013 оны А/315 тоот тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэлийн Боловсролын газрын үлгэрчилсэн журам"-д нийцүүлэн байгууллагын ажиллах журмыг боловсруулж батлуулаагүй;*
- *Дорноговь аймгийн БСУГ-ын ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн* $28^1$*.1.6*[28]*,* $28^1$*.1.7*[29]*-д заасан чиг үүрэг тусгагдаагүй. СӨБ хариуцсан мэргэжилтэн 2019 оны 2 дугаар сард чөлөөлөгдсөн боловч Төрийн албаны салбар зөвлөлийн нөөцөд тухайн албан тушаалд тохирох боловсон хүчин бүртгэгдээгүй тул 2019 оны 3 дугаар сараас цэцэрлэгийн арга зүйч гэрээгээр давхар гүйцэтгэж байна;*
- *Өмнөговь аймгийн БСУГ нь 2018 оны 9 дүгээр сараас хойш СӨБ хариуцсан мэргэжилтэнгүй байсан бөгөөд 2019 оны 9 дүгээр сард албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан Төрийн албаны зөвлөлд батлуулахаар хүргүүлж, мэргэжилтэн томилогдсон;*
- *Говь-сүмбэр аймгийн БСУГ-ын СӨБ хариуцсан мэргэжилтэн нь 2018 онд солигдсон, одоо ажиллаж буй мэргэжилтэн нь төрийн албаны шалгалтад тэнцээгүй, жинхлэн томилогдоогүй;*
- *Баян-Өлгий, Баянхонгор, Дундговь, Сүхбаатар аймгуудын БСУГ төсвийн мэргэжилтэнгүй ажиллаж байна.*

### *Санхүүжилтийн үйл ажиллагаа Төсвийн тухай хуульд заасны дагуу явагдаж байна*

1.39. Орон нутгийн боловсролын байгууллагын төсөв нь Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1[30] болон Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2[31]-т заасны дагуу

[27] Боловсролын тухай хуулийн 16.4.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагын бүтэц, дүрэм болон аймаг, нийслэлийн боловсролын газрын ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.
[28] Боловсролын тухай хуулийн $28^1$.1.6 орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох;
[29] Боловсролын тухай хуулийн $28^1$.1.7 орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах;
[30] Боловсролын тухай хуулийн 40.1.Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг тогтмол болон нормативд зардлаар санхүүжүүлнэ.
[31] Төсвийн тухай хуулийн 61.2.Энэ хуулийн 61.1-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээний үндсэн дээр улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлнэ.

тусгай зориулалтын шилжүүлэг хэлбэрээр салбарын ТЕЗ-ийн багцад батлагдан, аймаг, нийслэлд хуваарилагдаж байна. Аймаг, нийслэлийн ИТХ нь тусгай зориулалтын шилжүүлгийг орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгон баталдаг бөгөөд санхүүжилт Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарын дагуу хэрэгжиж байна.

*Дүрслэл 2. Төсвийн цаглабар*




1.40. СӨБ-ын үйлчилгээ авч буй нэг хүүхдэд ногдох зардлыг нийт хүүхдийн тоонд үржүүлэх зарчмаар СӨБ-ын боловсролын байгууллагын төсвийг төлөвлөж, хуваарилдаг бөгөөд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүнийг МУЗГ жил бүр шинэчлэн тогтоохоор Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3[32]-т заасан байна.

1.41. Төрийн өмчийн цэцэрлэгийн тогтмол зардал, хүүхдийн хоолны зардлын тодорхой хувь[33], төрийн болон хувийн цэцэрлэгт хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж иржээ.

1.42. Орон нутгийн өмчийн ашиглалтыг сайжруулах, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх, төсвийн төвлөрлийг бууруулж, орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилгоор тусгай зориулалтаар санхүүждэг орон нутгийн цэцэрлэг, ЕБС-ийн тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх зохицуулалтыг[34] 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Боловсролын тухай хуульд оруулсан байна.

1.43. БСШУСС нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан МУЗГ-ын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг Аймаг, нийслэлийн Засаг даргатай улсын төсөв батлагдсанаас хойш ажлын 14 өдрийн дотор байгуулан ажиллаж байна.

[32] Боловсролын тухай хуулийн 40.3.Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно.

[33] Төмөр замын харьяа цэцэрлэг эцэг эхчүүдээс хүүхдийн хоолны мөнгөний тодорхой хувийг гаргуулдаг

[34] Боловсролын тухай хуулийн 40.2.Төрийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс, ...цэцэрлэгийн байршлыг харгалзан хүүхдийн хоолны зардлын тодорхой хувь, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ашгийн болон ашгийн төлөө бус цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.

1.44. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Төсвийн тухай 15 дугаар зүйлийн 15.2[35], 22 дугаар зүйлийн 22.6.6[36], 42 дугаар зүйлийн 42.2.2[37]-д заасны дагуу батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр батлах, түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөвт зохицуулалт хийх эрхтэй бөгөөд Сангийн сайдын тушаалаар баталсан сар, улирлын төсвийн хуваарийн хүрээнд цэцэрлэгүүдийн сар, улирлын хуваарийг баталж, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс санхүүжилтийн эрхийг олгож байна.

1.45. Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 7.5.3.г[38]-д заасны дагуу зарим аймаг тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг сумын дүнгээр тусгаж, сумын засаг дарга цэцэрлэг тус бүрийн төсвийг баталж, төсвийн зохицуулалт хийж байгаа нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6-д заасантай нийцээгүй төдийгүй БСУГ-ын зүгээс жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх, үр дүнг тооцох боломжгүйд хүргэж байна. Тухайлбал,

- *Дорнод аймгийн Хэрлэн сумын ИТХ нь цэцэрлэгүүдийн санхүүжилтийг байгууллага бүрээр хуваарилан баталж, Засаг дарга төсвийн зохицуулалт хийж, цэцэрлэгүүдийн төсвийн гүйцэтгэлийг хянаж, сар бүрийн санхүүжилтийг олгож байгаагаас аймгийн БСУГ нь төсвийн гүйцэтгэлд хяналт тавих боломжгүйд хүрч байна.*

[35] Төсвийн тухай хуулийн 15.2.Энэ хуулийн 39.1-д заасан гэрээгээр тусгай зориулалтын шилжүүлэг хүлээн авсан төсвийн төвлөрүүлэн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг дарга байна.
[36] Төсвийн тухай хуулийн 22.6.6.төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах;
[37] Төсвийн тухай хуулийн 42.2.Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно: 42.2.2.төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд;
[38] Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 7.5.3.г/ аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт олгох тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг зориулалтын чиг үүрэг, сум, дүүрэг тус бүрээр;

# БҮЛЭГ 2. ХАМРАН СУРГАЛТ НЭМЭГДЭЖ БАЙГАА Ч НЭГ АНГИД БАЙХ ХҮҮХДИЙН ТОО ХҮЧИН ЧАДЛААС 2 ДАХИН ХЭТЭРСЭН, СУРГАЛТЫН ЧАНАРЫГ ҮНЭЛЖ ДҮГНЭХ БОЛОМЖ БҮРДЭЭГҮЙ, БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ҮР НӨЛӨӨТЭЙ ХЯНАЛТ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА

## *СӨБ-ын байгууллагыг шинээр барих, өргөтгөх, засварлах дунд хугацааны бодлого, төлөвлөлтгүй байна*

2.1. УИХ-ын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд СӨБ-ын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг төлөвлөжээ.

- *3.2.2.1-т “Цэцэрлэг барих төр, орон нутгийн болон олон улсын тусламжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлж, СӨБ-д хамрагдаагүй хүүхдийн тоог 2017 онд 7 хувь, 2018 онд 29 хувиар бууруулах;*
- *3.2.3-т “Анги дүүргэлт хэт өндөртэй цэцэрлэгийн ачааллыг бууруулах” зорилтын хүрээнд “цэцэрлэгийн эрэлт, хэрэгцээ өндөр байгаа хот сууринд хөрөнгө оруулалтыг төвлөрүүлж, цэцэрлэгийн барилга шинээр барих, өргөтгөх, засварлах дунд хугацааны төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах”.*

2.2. Улсын төсвөөс боловсролын салбарт 2016-2018 онд оруулсан хөрөнгө оруулалтын 17.1 орчим хувь буюу нийт 83,278.4 сая төгрөгийг СӨБ-ын барилга байгууламж барихад зарцуулсан байна.

*Дүрслэл 3. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн СӨБ-ын салбарын хөрөнгө оруулалтын гүйцэтгэл (сая.төгрөгөөр)*




*Эх сурвалж: Сангийн яам, БСШУСЯ*

2.3. БСШУСЯ-ны СХОГ нь 2016-2018 оны цэцэрлэгийн барилга барих хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө аймаг, сум, хороо, баг тус бүрээр хүн амын нягтаршил, өрхийн тоо, барилгын насжилттай уялдуулж дүн шинжилгээ хийгээгүй аймаг, орон нутгаас ирүүлсэн саналыг нэгтгэх байдлаар хийсэн байна.

2.4. БСШУСЯ-аас Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3[39]-т заасны дагуу 2016-2018 оны төсвийн төсөлд нийт 389,275.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 362,988.4 сая төгрөгөөр санхүүжих, 51570 хүүхдийн хүчин чадал бүхий 464 цэцэрлэгийн барилгыг шинээр барих болон үргэлжлүүлэн санхүүжүүлэх саналыг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

[39] Төсвийн тухай хууль 8.4.3 ТЕЗ жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

*Дүрслэл 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн шилжих болон шинэ цэцэрлэгийн барилгын судалгаа /сая төгрөгөөр/*




*Эх сурвалж: БСШУСЯ*

2.5. УИХ-аас тухайн онуудын төсвийн хуулиар 225,342.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 99,876.0 сая төгрөгөөр санхүүжих, 23480 хүүхдийн хүчин чадал бүхий давхардсан тоогоор 173 шилжих болон шинэ цэцэрлэг барихаар баталсан нь бодит хэрэгцээтэй бүрэн уялдаагүй байна. Тухайлбал,

- *Булган, Говьсүмбэр, Дархан-Уул аймгийн цэцэрлэгүүд нийт 5286 хүүхдээр хүчин чадал хэтэрсэн байхад цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй;*
- *Өвөрхангай, Хөвсгөл аймагт аймгийн цэцэрлэгүүд нийт 10391 хүүхдээр хүчин чадал хэтэрсэн байхад 750 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг барихаар батлагдсан.*

2.6. Улсын хэмжээнд 2016-2018 онд цэцэрлэгийн хүчин чадлын хэтрэлт дунджаар 106126 хүүхэд байсан боловч шинээр барихаар төлөвлөсөн цэцэрлэгийн хүчин чадал нь үүний 13.5 хувьтай тэнцүү байна.

*Дүрслэл 5. Орон нутагт шинээр барихаар төлөвлөсөн цэцэрлэгийн хүчин чадал болон хүчин чадлын хэтрэлт /хүүхдийн тоо/*




*Эх сурвалж: Сангийн яам*

*Дүрслэл 6. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн СӨБ-ын салбарын гүйцэтгэл /сая төгрөг/*




*Эх сурвалж: Сангийн яам*

2.7. Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд цэцэрлэг шинээр барихаар төлөвлөөгүй, 2017-2018 онд шинээр нийт 140,199.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 65,869.5 сая төгрөгөөр санхүүжих, 14320 хүүхдийн хүчин чадал бүхий 90 цэцэрлэг барихаар төлөвлөж, 52,877.6 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

*Дүрслэл 7. Улсын төсвийн хөрөнгөөр 2017-2018 онд шинээр барихаар төлөвлөсөн цэцэрлэг /хүүхдийн тоо/*




*Эх сурвалж: Сангийн яам*

2.8. БСШУСЯ-ны СХОГ нь СӨБ-ын байгууллагыг шинээр барих, өргөтгөх, засварлах дунд хугацааны бодлого, төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй, цэцэрлэгийн барилга байгууламжийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлээгүй нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан "*Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам*"-ын 3.6[40]-д заасантай нийцээгүй төдийгүй МУЗГ-ын 2016 оны 91 дүгээр, 2017 оны 267 дугаар тогтоолоор баталсан тус газрын чиг үүргээ[41] хэрэгжүүлээгүйг харуулж байна.

***Ашиглалтад орсон цэцэрлэгийн барилга байгууламжийн тоо, мэдээ зөрүүтэй байна***

2.9. Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллагаас ирүүлсэн "*Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж, хандивын хөрөнгөөр 2016-2018 онд ашиглалтад орсон цэцэрлэгүүдийн судалгаа*"-аас үзэхэд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийг хөгжүүлэх сан, гадаадын зээл тусламж, концессын гэрээгээр нийт 159,875.2 сая төгрөгийн өртөгтэй, 17450 хүүхдийн хүчин чадалтай, 136 цэцэрлэг ашиглалтад орсон байна.

*Дүрслэл 8. Ашиглалтад орсон цэцэрлэг /хүчин чадал, цэцэрлэгийн тоо/*




*Эх сурвалж: Аймаг, нийслэл дэх төрийн аудитын газар*

[40] Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам 3.6 Төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэлийн тухайн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь тухайн захиалагчийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй харилцан уялдсан байхын зэрэгцээ салбарын гол тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтын ач холбогдол, тухайн төслийн хэрэгжилттэй уялдуулан эрэмбэлсэн байна.
[41] МУЗГ-ын 2017.09.20-ны өдрийн 267 дугаар тогтоол, "Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" хавсралтын 3.3.9 "Санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг" БСШУСЯ-ны СХОГ нь салбарын хөрөнгө оруулалтын бодлогыг төлөвлөх, төсөв боловсруулах, үр ашгийн шинжилгээ хийх, хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэх

2.10. БСШУСЯ-ны СХОГ нь орон нутгийн болон орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр баригдсан цэцэрлэгийн тоог нэгтгээгүй, 2016-2018 онд нийт 98,019.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 12295 хүүхдийн хүчин чадалтай, 106 цэцэрлэг ашиглалтад орсон гэж зөрүүтэй тайлагнасан төдийгүй 48 цэцэрлэг нь дээрх хугацаанд хамаарахгүй бодит бус байна.

***Шинээр барихаар төлөвлөсөн цэцэрлэгүүд бүрэн хэрэгжээгүйгээс цэцэрлэгийн хамрагдалт нэмэгдэх боломжийг хязгаарласан байна***

2.11. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016-2018 онд нийт 61 цэцэрлэг ашиглалтад оруулахаар баталснаас 26,032.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 9,883.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй, 16 цэцэрлэгийн барилга нь зураг төсөвгүй, барилгын норм, дүрмийг зөрчсөн, газар чөлөөлөөгүй зэрэг шалтгаанаар хэрэгжээгүйгээс, 2590 хүүхдийн цэцэрлэгт хамрагдах боломж алдагдсан байна. /*Дэлгэрэнгүйг Хавсралт 5-с үзнэ үү*/ Тухайлбал,

- *Сэлэнгэ аймгийн Мандал суманд 2018 оны байдлаар хамран сургалт 66 хувьтай, 808 хүүхэд цэцэрлэгт хамрагдаагүй, нийт цэцэрлэгийн хүчин чадал 302 хүүхдээр хэтэрсэн байна.*
  *Тус суманд 2014 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж эхэлсэн 100 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч "Талын монгол групп" ХХК нь барилгын норм, дүрэм зөрчиж, батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгээгүйгээс[42] барилгын ажлыг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болжээ. Аудитаар тус цэцэрлэгийн барилгын ажил гүйцэтгэх гэрээ болон барилга угсралтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн дүнг БСШУСЯ болон Барилгын хөгжлийн төвөөс аудитад ирүүлээгүй болно.*
  *Захиалагчийн хяналт үр нөлөөтэй хэрэгжээгүй, захиалагч болон гүйцэтгэгч талууд 2016 оноос хойш уг төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар ажил хийгээгүй, зогсонги байдалтай байгаагаас улсын төсвийн хөрөнгө оруулалт үр ашиггүй болжээ.*



*Зураг 1. "Талын монгол групп" ХХК-ийн гүйцэтгэсэн Сэлэнгэ аймгийн Мандал сумын 100 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилга*

2.12. Нийслэлд шинээр барихаар төлөвлөсөн 7 цэцэрлэгийн барилга газрын асуудал шийдээгүйгээс хэрэгжиж эхлээгүй нь Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7[43], 42.8[44] дахь заалтын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна. Үүнд:

- *Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 240 ор /Улаанбаатар, СХД, 125 дугаар цэцэрлэг/*
- *Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, СХД, 11 дүгээр хороо/*
- *Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, СХД, 23 дугаар хороо/*
- *Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар, СХД, 16 дугаар хороо/*
- *Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, БГД, 21 дүгээр хороо/*
- *Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар, БГД, 16 дугаар хороо, Гандангийн дэнж/*
- *Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, БЗД, 4, 5, 14 дүгээр хороо/*

2.13. Мөн аудитын хамарсан хугацаанд дараах төсөл, арга хэмжээ улсын төсвөөс санхүүжилт авсан боловч барилга угсралтын ажил хийгээгүй, хэрэгжээгүй байгаа нь ашиглалтад орох хугацаа хойшлох, хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг алдахад хүргэж хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна. Үүнд:

- *Архангай аймгийн Хангай суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжиж эхэлсэн 50 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгч "Баянмогод" ХХК нь банкны баталгаагаар 488.8 сая төгрөг буюу 100 хувийн санхүүжилт авсан боловч газар чөлөөлснөөс өөр ажил хийгээгүй;*
- *Говь-Алтай аймгийн Халиун суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжиж эхэлсэн 100 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэл 18.1 хувьтай боловч гүйцэтгэгч "Баянмогод" ХХК-д бодит ажлын гүйцэтгэлээс 357.8 сая төгрөгөөр илүү буюу 500.0 сая төгрөгийн санхүүжилтийг банкны баталгаагаар авсан;*

[42] Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2016 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 18-07-02/ 104 дугаар дүгнэлтээр *"зураг төсөл боловсруулсан Барилга байгууламж ХХК нь зохиогчийн хяналтыг хангалтгүй гүйцэтгэсэн, гүйцэтгэгч "Талын монгол групп" ХХК нь барилга угсралтын ажлыг гүйцэтгэхдээ барилгын норм, дүрэм зөрчиж, батлагдсан зураг төслийн дагуу ажил гүйцэтгээгүйгээс ажлыг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй байна"*

[43] Боловсролын тухай хууль 42.7 Аймаг, нийслэлийн ИТХ нь шинээр барих сургууль, цэцэрлэгийн урт хугацааны төлөвлөлтийг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж, сургууль, цэцэрлэгийн эзэмшил, ашиглалтын эдэлбэр газрыг сургалтын орчинд тавигдах шаардлагад нийцсэн талбайн хэмжээний дагуу нөөцөд авах шийдвэр гаргана

[44] Боловсролын тухай хууль 42.8 Энэ хуулийн 42.7-д заасны дагуу шинээр барих сургууль, цэцэрлэгийн нөөцийн газрыг өөр зориулалтаар эзэмшүүлэх, ашиглуулах, худалдахыг хориглоно.

- *Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжиж эхэлсэн 200 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилга баригдаж эхлээгүй болович гүйцэтгэгч “Харужин” ХХК-д 250.0 сая төгрөгийн санхүүжилтийг банкны баталгаагаар авсан байна.*

2.14. Улсын төсөв, гадныг зээл тусламжаар 2016-2018 онд нийслэл, орон нутагт баригдсан цэцэрлэгийн барилга байгууламж орчны стандартад нийцээгүй, чанарын шаардлага хангахгүй байх тохиолдол гарсан байна. Тухайлбал,

- *Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгонд 2016 онд Япон улсын засгийн газрын төслийн бус буцалтгүй тусламжаар баригдсан 100 хүүхдийн хүчин чадалтай, 763.5 сая төгрөгийн өртөг бүхий барилга суулт өгсөн, дээврээс ус гоождог , тааз нь цав гарсан;*
- *Хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан Сүхбаатар сумын 7 дугаар багийн Хөгжил хотхоны 1 дүгээр давхарт байршилтай, 200 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгыг улсын комиссын 2017 оны 2017/09 дугаар актаар ашиглалтад оруулсан бөгөөд 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2,300.0 сая төгрөгөөр худалдан авсан байна. Уг барилгын гал тогооны өрөөнд газардуулга хийгдээгүй, дээд давхраас ус гоождог, халуун усны тохиргоо алдагддаг, 1 анги болон коридорт агааржуулалтгүй зэрэгээр цэцэрлэгийн барилгын болон орчны стандартыг хангахгүй байна;*
- *Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр суманд концессын гэрээгээр баригдсан цэцэрлэгийн барилгад ашиглалтын явцад дээврээс ус гоожсон, гүйцэтгэгч нэг удаа засвар үйлчилгээ хийсэн болович дахин борооны ус ханаар орсон байдалтай байна;*
- *Дархан-Уул аймагт 26 дугаар цэцэрлэг: Гал тогооны өрөөний талбай хангалтгүй, агуулахын өрөөгүй, хоол бэлтгэлд зориулагдсан 6.8м2 цонхгүй өрөөг агуулах болгон ашиглаж байгаа болович агааржуулалт хийгдээгүй. ариун цэврийн өрөөний бохирын шугам ил хийгдсэн, 2 бүлгээс бохир үнэртдэг, ашиглалтын явцад барилгын хана, цонхонд суулт өгсний улмаас ангиудын 3 цонх хагарсан, таазны шавар цуурч, цав гарсан байна;*
  *27 дугаар цэцэрлэг: Цэцэрлэгийн зүүн талын явган хүний зам эвдэрсэн, барилгын хаяавчны плита унасан, хашааны хаалганы гагнаас салсан, зарим ангиудын шаланд чийг өгч, паркет пөмбийсөн, крантнуудын уян хоолойноос ус алддаг, мултарч унадаг, гал тогооны уур гаргагч уур сорохгүй, уур гаргагчийг дагаж ус гоождог, узелийн халуун усны насос ажиллахгүй байна;*
- *Нийслэлийн СХД-ийн 252 дугаар цэцэрлэг засварласан ахуйн үйлчилгээний барилгад үйл ажиллагаа явуулдаг, СХД-ийн 253 дугаар цэцэрлэг 00-ийн өрөөнд пааргүй, ЧД-ийн 18 дугаар цэцэрлэг 00-ийн өрөөнд пааргүй, хананд цууралт ихтэй, хөрсний ус гарч зоорины давхар усанд автсанаас НМХГ-аас дүгнэлт гарсан;*
- *Ховд аймгийн 15 дугаар цэцэрлэгийн зарим ангиуд унтлагын өрөө нь тусдаа биш, гадна тохижилтын ажил хийгдээгүй, 1 дүгээр цэцэрлэг нь агааржуулагч муу, гал тогооны цахилгаан шаардлага хангахгүй зэрэг зөрчил дутагдал байна.*

## ***Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувь нэмэгдсэн болович төрийн өмчит цэцэрлэгт нэг ангид ногдох хүүхдийн тоо 2 дахин хэтэрсэн байна***

2.15. Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм БНбД 2-66-88-ын 1.9-т *“ердийн цэцэрлэгийн нэг бүлэгт 20 хүүхэдтэй”*, БСШУС-ын 2005 оны 405 дугаар тушаалаар баталсан “Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 2.3-т 1 бүлэгт үндсэн сургалттай цэцэрлэгт 20-25, гэр цэцэрлэгт 20 хүүхэдтэй байхаар заасан байна.

2.16. Улсын хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилд 155126 хүүхдийн хүчин чадалтай 1435 төрийн болон хувийн хэвшлийн цэцэрлэг үйл ажиллагаа явуулсан нь сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 48 хувийг хамруулах хүчин чадалтай байна.

*Дүрслэл 9. Цэцэрлэгийн хүчин чадал /хүүхдийн тоо/*




*Эх сурвалж: БСШУСЯ*

2.17. Өмчийн хэлбэрээр нь авч үзвэл төрийн өмчийн цэцэрлэг тоогоороо нийт цэцэрлэгийн 62 хувь, баталсан хүчин чадлын 78 хувийг эзэлж байна. Байршлын хувьд 53 хувь нь орон нутагт, 47 хувь нь нийслэлд, үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 47 орчим хувь нь нийслэлд оршин сууж байгаагаас цэцэрлэгийн ачаалал их байна.

2.18. Улсын хэмжээнд нэг аймагт дунджаар 35 цэцэрлэг байгаа бөгөөд 2018 оны байдлаар Говьсүмбэр аймагт хамгийн бага буюу 11 цэцэрлэг, Төв аймагт хамгийн их буюу 49 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна.

*Дүрслэл 10. Цэцэрлэгийн хүчин чадлын хэтрэлт*




*Эх сурвалж: БСШУСЯ*

2.19. Цэцэрлэгийн хүрэлцээ хангалтгүйгээс төрийн өмчийн цэцэрлэгт “Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-д заасан нэг бүлэгт байх хүүхдийн тоо, Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм БНбД 2-66-88-ын 5.2[45] заалтууд мөрдөгдөхгүй байна. Тухайлбал,

- *Төрийн өмчийн цэцэрлэгт 2016-2018 онд жилд дунджаар 102772 хүүхэд хүчин чадлаас хэтэрч хамрагдсан бөгөөд нэг бүлэгт ногдох хүүхдийн тоо “Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-д заасныаас 2 дахин илүү байна.*

2.20. Мөн улсын хэмжээнд анги дүүргэлт аймаг, нийслэлд харилцан адилгүй, төрийн өмчийн цэцэрлэгт дунджаар 36, хувийн цэцэрлэгт дунджаар 22 хүүхэд байгаа бөгөөд аудитын хүрээнд түүвэрт хамрагдсан нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгийн нэг бүлэгт 41-65 хүүхэд суралцаж байгаа нь “*Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм*”-д заасныаас 13-40 хүүхдээр хэтэрсэн байна. Тухайлбал,

- *ХУД-ийн 12, 65 дугаар цэцэрлэгийн нэг бүлэгт тус бүр 32 хүүхэд;*
- *СБД-ийн 135, 143 дугаар цэцэрлэгт 18-20 хүүхэд;*
- *БГД-ийн 95 дугаар цэцэрлэгт 16 хүүхэд;*
- *БГД-ийн 157 дугаар цэцэрлэгт 28 хүүхэд;*
- *ЧД-ийн 222 дугаар цэцэрлэгт 13 хүүхэд;*
- *ЧД-ийн 124 дүгээр цэцэрлэгт 20 хүүхэд;*
- *БЗД-ийн 122 дугаар цэцэрлэгт 40 хүүхэд;*
- *БЗД-ийн 122 дугаар цэцэрлэгт 19 хүүхэд;*
- *СХД-ийн 80 дугаар цэцэрлэгт 19 хүүхдээр тус тус хэтэрсэн байна.*

2.21. ЭМХТ-с гаргасан “Эрүүл мэндийн үзүүлэлт”-д 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлд амьсгалын замын халдварт өвчин хотод 46.2 хувь, орон нутагт 67.0 хувийг эзэлж байгаа бөгөөд нэг ангид стандарт, дүрэмд заасныаас олон тооны хүүхэд хамрагдаж байгаа нь амьсгалын замын халдварт өвчин тархах эрсдэлийг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болж байна.

[45] Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм БНбД 2-66-88-ын 5.2 сургуулийн өмнөх насны ердийн хэв шинжийн барилгын өрөөний нэг хүүхдэд ногдох талбайг дараах байдлаар тогтооно. Үүнд: цэцэрлэгийн насны хүүхдийн бүлэг 5.5 мкв-аас ихгүй байна

*Дүрслэл 11. Анги дүүргэлтийн судалгаа /2016-2018 оны дундаж/*




*Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик*

2.22. Харин төрийн байгууллагуудын зүгээс хувийн цэцэрлэгт Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм БНбД 2-66-88-ын 5.2-т "*нэг хүүхдэд ногдох талбай ... цэцэрлэгийн насны хүүхдийн бүлэг 5.5 мкв-аас ихгүй байна*" гэсэн заалтын хэрэгжилтэд хяналт тавьж ажилладгаас хүчин чадлаас тэдийлэн хэтэрдэггүй нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7[46] заалт өмчийн хэлбэрээс шалтгаалан ялгаатай хэрэгжиж байгааг харуулж байна.

2.23. Улсын хэмжээнд 2018 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй нийт 1435 цэцэрлэгийн 543 нь хувийн цэцэрлэг /*үүнээс 441 нь нийслэлд байршилтай*/ бөгөөд 44 хувь нь 50 хүртэлх, 36 хувь нь 100 хүртэлх, 15 хувь нь 150 хүртэлх, 3 хувь нь 200 хүртэлх, 1.3 хувь нь 250 хүртэлх, 0.9 хувь нь 370 хүртэлх хүүхдийн хүчин чадалтай байна.

*Дүрслэл 12. Хувийн цэцэрлэгүүдийн хүчин чадал /хүүхдийн тоо/*




*Эх сурвалж: Аудитын явцад авсан хувийн өмчийн цэцэрлэгүүдийн судалгаа*

2.24. Нийт хувийн цэцэрлэгийн 75 орчим хувь нь өөрийн өмчийн байранд, 25 орчим хувь нь түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг боловч хөрөнгө оруулалт ихээр шаарддагаас 44.2 хувь нь хүчин чадал харьцангуй бага буюу 50 хүртэлх хүүхдийн хүчин чадалтай бөгөөд нийслэлийн нийт цэцэрлэгийн 63 хувийг эзэлж буй хувийн цэцэрлэг хамран сургалтын 45 хувийг эзэлж байна.

*Хүснэгт 1. Нийслэлийн хувийн цэцэрлэгийн тоо, хамран сургалтын хувь*

| Хэвшил | 2016 он | | 2017 он | | 2018 он | |
|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Хамран сургалтын хувь | Тоо | Хамран сургалтын хувь | Тоо | Хамран сургалтын хувь |
| Төрийн | 243 | 73.9 | 254 | 73.9 | 258 | 72.7 |
| Хувийн | 407 | 26.1 | 434 | 26.1 | 441 | 27.3 |

[46] Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль 8.7 цэцэрлэг нь барилга байгууламж, сургалтын орчны стандарт, хүүхдийн хоол хүнс, эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлын норм, нормативыг өмчийн хэлбэр харгалзахгүй мөрдөнө

2.25. Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм БНбД 2-66-88-ын 2.6-д ердийн хэв шинжийн сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага дээд тал нь 14 бүлэгтэй байхаар заасан боловч зарим цэцэрлэг 14-өөс дээш бүлэгтэй үйл ажиллагаа явуулж байгаагийн дийлэнх нь Улаанбаатар хотод байна. Тухайлбал,

- *15 бүлэгтэй - Булган аймгийн Хишиг-Өндөр сумын цэцэрлэг, Нийслэлийн БГД-ийн 120 дугаар цэцэрлэг*
- *16 бүлэгтэй - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын цэцэрлэг, БЗД 22 дугаар цэцэрлэг, СХД 91 дүгээр цэцэрлэг, ЧД 124 дүгээр цэцэрлэг*
- *18 бүлэгтэй - Ховд аймгийн Булган сумын цэцэрлэг, Нийслэлийн БЗД-ийн 115 дугаар цэцэрлэг.*

2.26. Улсын цэцэрлэгийн барилга, өргөтгөлийн барилгын насжилтыг авч үзэхэд сүүлийн арван жилд хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор 0-15 жилийн насжилттай барилга 58 хувийг, 30-45 жилийн насжилттай барилга 22 хувь, 45-аас дээш жилийн насжилттай барилга 11 хувийг эзэлж байна.

*Дүрслэл 13. Улсын цэцэрлэгийн барилгын насжилтын судалгаа /барилгын тоо/*




*Эх сурвалж: БСШУСЯ-ны Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс /2019 оны байдлаар/*

2.27. Үүнээс 0-15 жилийн насжилттай барилгын 25 хувь, 15-30 жилийн насжилттай барилгын 19 хувь, 30-45 жилийн насжилттай барилгын 25 хувь, 45-60 жилийн насжилттай барилгын 35 хувь, 60-аас дээш жилийн насжилттай барилгын 39 хувь нь нийслэлд байршилтай байна.

*Дүрслэл 14. Аймгийн цэцэрлэгүүдийн барилгын насжилтын судалгаа*




*Эх сурвалж: БСШУСЯ-ны Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс /2019 оны байдлаар/*

2.28. Аймаг, орон нутагт зарим цэцэрлэгийн барилгын ашиглалтын хугацаа дууссанаас акталсан, зориулалтын бус байранд үйл ажиллагаа явуулсан, урсгал болон их засвар хийгээгүй нь Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1[47], Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7[48], “Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм /БНбД 13-04-03/”[49]-д заасантай нийцээгүй, хүүхдийн эрүүл, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал,

- *Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 3 дугаар цэцэрлэг нь Арьс өнгөний эмнэлгийн зориулалтаар 1966 онд баригдаж, 1991 онд актлагдсан байранд 2019 оныг хүртэл үйл ажиллагаа явуулсан байна. Одоогийн байдлаар тус цэцэрлэг "Думан" зочид буудлын өрөөнүүдийг түрээслэн үйл ажиллагаа явуулж байна;*
- *Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын 1 дүгээр цэцэрлэгийн үндсэн барилга 1974 онд баригдсанаас хойш 45 жил их засвар хийгээгүй;*
- *Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 6 дугаар цэцэрлэг нь арьс ширний үйлдвэрийн зориулалтаар баригдсан байранд 1975 оноос хойш 44 жил үйл ажиллагаа явуулж, 2018 онд акталсан байна;*
- *Дорнод аймгийн Хэрлэн сумын 1,5,8,14 дүгээр цэцэрлэг, Гурванзагал, Дашбалбар, Чойбалсан, Чулуунхороот сумдын цэцэрлэг ашиглалтад орсноос хойш 28-56 жилийн хугацаанд их засвар хийгдээгүй;*
- *Говь-сүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн 2 бүлэг, “Хонгорхон” хувийн цэцэрлэгийн 1 бүлэг болон “Буян”, “Тунгаамал” гэсэн хувийн цэцэрлэгүүд орон сууцны зориулалттай байранд, Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг, “Бужинхэн” хувийн цэцэрлэг конторын зориулалттай байранд үйл ажиллагаа явуулж байна;*
- *Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын 50 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулснаас 8 жилийн дараа ашиглах боломжгүй болсноос сумын ЗДТГ-ын орон сууцны барилгад үйл ажиллагаа явуулж байна. Тус барилгад улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд 46.5 сая, 2017 онд 79.5 сая төгрөгийн засвар хийгдсэн нь үр ашиггүй болсон байна;*
- *Дундговь аймгийн Сайнцагаан сумын 6 дугаар цэцэрлэгийн барилгад 21 жилийн дараа засвар хийсэн;*
- *Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 100 хүүхдийн хүчин чадалтай 1 дүгээр цэцэрлэгийн барилгад ашиглалтад орсноос 57 жилийн дараа урсгал засвар хийсэн боловч санхүүжилтийг бүрэн шийдээгүйн улмаас дутуу хийгдэж, бохир үнэртдэг, мөөгөнцөртсөн байна;*
- *Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын цэцэрлэгт ашиглалтад орсноос хойш 49 жилийн дараа их засвар хийсэн;*
- *Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 1 дүгээр цэцэрлэгийн барилгыг Мэргэжлийн хяналтын газраас ашиглах боломжгүй дүгнэлт 2012, 2017 онд гаргасан боловч одоог хүртэл үйл ажиллагаа явуулж байна. Мөн тус сумын 4 дүгээр цэцэрлэгт МХЕГ-аас 2017, 2018 онд их засвар хийх шаардлагатай гэсэн боловч хийгээгүй;*
- *Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн барилга нь ашиглалтад ороод 36 жил болсон тул Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газраас 8 удаа дүгнэлт гаргаж, үйл ажиллагаа явуулахыг хориглосон боловч барилгын талбайн хэмжээг томруулан 75 хүүхдийг хүлээн авч ажиллаж байна;*
- *Төв аймгийн Дэлгэрхаан сумын Дэгдээхэй цэцэрлэгийн барилга анх 1962 онд ашиглалтад орсноос хойш 57 жилийн хугацаанд их засварт ороогүй, бүлгийн ариун цэврийн өрөөнд суултуур, угаалтуур байхгүй.*



*Зураг 2. Баян-Өлгий аймгийн 3 дугаар цэцэрлэг*



*Зураг 3. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэг*

[47] Боловсролын тухай хууль 42.1 “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна

[48] Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль 8.7 Цэцэрлэг нь барилга байгууламж, сургалтын орчны стандарт, хүүхдийн хоол хүнс, эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлын норм, нормативыг өмчийн хэлбэр харгалзахгүй мөрдөнө

[49] *БНбД 13-04-03 “урсгал засвар хийх хугацаа 3-5 жил, их засвар хийх хугацаа 15-20 жил”*



*Зураг 4. Төв аймгийн Дэгдээхэй цэцэрлэгийн ариун цэврийн өрөөний байдал*

2.29. Зарим аймгийн цэцэрлэгт анги, танхимыг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй байна. Үүнд:

- *Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сум - 2018 оны байдлаар сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 66 хүүхэд хамрагдаагүй үлдсэн болович тус сумын цэцэрлэг 2 ангийг агуулахын зориулалтаар ашигласнаас 50 хүүхдийг цэцэрлэгт хамруулах боломжийг алдсан байна.*
- *Дундговь аймгийн Луус сумын 100 хүүхдийн хүчин чадалтай, 4 бүлэгтэй цэцэрлэгт 2016-2018 онд дунджаар 66 хүүхэд хамрагдаж, бүрэн хүчин чадлаар ажиллагаагүйгээс 2018 онд 1 бүлгийг хаасан байна.*

2.30. Шинээр барих цэцэрлэгийн давхрын хязгаарыг "Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм" БНбД 2-66-88"-ийн 4.5-д "*сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагыг 2 давхраас илүүгүй"* гэж заасан болович "Олон нийт, иргэний барилгын зураг төсөл зохиох норм, дүрэм" БНбД 31-03-03-ийн 3.4-т барилгын хүчин чадал, барилгын галд тэсвэршилтийн зэргээс хамааран 1-3 давхар байхаар зөрүүтэй заасан байна. Үүнд:

*Хүснэгт 2. Сургуулийн өмнөх насны хүүхдийн барилгын хүчин чадал, давхрын хязгаар, барилгын галд тэсвэршилтийн зэрэг хоорондын хамаарал*

| *Барилгын хүчин чадал* | *Гал тэсвэршилтийн зэрэг* | *Давхрын тоо* |
|---|---|---|
| *50 хүртэлх* | *IV* | *1* |
| *160 хүртэлх* | *III* | *2* |
| *320 хүртэл* | *II, I* | *2-3* |

*Эх сурвалж: "Олон нийт, иргэний барилгын зураг төсөл зохиох норм, дүрэм" /БНбД 31-03-03/*

### *Хот байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд тавих хяналт сул, барилгын норм ба дүрэмд шинээр баригдах орон сууцны хороолол, хотхоныг цэцэрлэгийн барилгын хамт төлөвлөж, барих зохицуулалтгүй байна*

2.31. Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5[50], 6 дугаар зүйлийн 6.1.4[51] 8 дугаар зүйлийн 8.1.5[52]-д заасны дагуу УИХ, Засгийн газар, ИТХ нь нийслэл, бүсийн хөгжлийн тулгуур төв хот, аймгийн *"хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"[53]*-г АНИХ нь *"хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө"[54]*-г батлах эрхтэй бөгөөд 16 аймаг нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөө баталсан, 5 аймаг нь батлаагүй байна. Үүнд:

- *Дархан-Уул аймаг 2004 онд;*
- *Өвөрхангай аймаг 2009 онд;*
- *Улаанбаатар, Дорноговь, Сэлэнгэ аймгууд 2013 онд;*
- *Говь-сүмбэр аймаг 2014 онд;*
- *Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий аймгууд 2015 онд;*
- *Говь-Алтай, Сүхбаатар аймгууд 2016 онд;*
- *Дундговь, Баянхонгор, Ховд, Дорнод аймгууд 2017 онд;*
- *Увс аймаг 2018 онд;*

---

[50] Хот байгуулалтын тухай хууль 5.1.Улсын Их Хурал хот байгуулалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.1.5.нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах.

[51] Хот байгуулалтын тухай хууль 6.1.Засгийн газар хот байгуулалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 6.1.4.бүсийн хөгжлийн тулгуур төв хот, түүнчлэн томоохон уул уурхайн орд газар, үйлдвэр, нисэх онгоцны буудлыг даган бий болсон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах;

[52] Хот байгуулалтын тухай хууль 8.1 Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хот байгуулалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.1.5.бүс нутгийн хөгжлийн төслийн үндсэн шийдэлтэй уялдуулан орон нутгийн зэрэглэлтэй хот болон тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах;

[53] Хот байгуулалтын тухай хууль 3.1.3."хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" гэж хот, тосгоны хүн амын эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах таатай орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн хот байгуулалтын үндсэн баримт бичгийг;

[54] Хот байгуулалтын тухай хууль 3.1.12."хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө" гэж хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайн дүүрэг, орон сууцны болон гэр хорооллын газар зохион байгуулалт, барилгажилт, тохижилтын төлөвлөлт, инженерийн шугам сүлжээний хангамжийг нарийвчлан тодотгож төлөвлөсөн хот байгуулалтын үйл ажиллагааны баримт бичгийг;

- *Төв аймаг 2019 онд баталсан;*
- *Архангай, Булган, Орхон, Баян-Өлгий, Завхан аймгууд батлаагүй байна.*

2.32. БХБЯ нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй аймгуудад “хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулахыг чиглэл болгосон боловч хэрэгжилт хангалтгүй байна.

2.33. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй, боловсруулах шатандаа байгаа аймгуудын хувьд шинээр барих СӨБ-ын байгууллагын барилгыг хот төлөвлөлтийн системтэйгээ уялдуулж, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж буй эсэх нь тодорхойгүй байна.

2.34. АНИХ нь Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7[55] -д заасны дагуу шинээр барих цэцэрлэгийн барилгын эзэмшил, ашиглалтын эдэлбэр газрыг нөөцөд авах шийдвэрийг гаргаагүй, зарим аймгийн хувьд ИТХ-аас нөөцөд авах тухай гаргасан тогтоолын хэрэгжилт хангалтгүй байгаа нь цэцэрлэгийн хүртээмжид сөргөөр нөлөөлсөн байна. Тухайлбал,

- *Дорнод аймгийн Чойбалсан хотын ерөнхий төлөвлөгөөнд шинээр 16 цэцэрлэгийн барилга тусгасан боловч тус байршилд ААНБ, иргэнд өмчлөл, эзэмшлээр газар олгосон;*
- *Говь-сүмбэр аймгийн Сүмбэр сумд барих 6, Шивээговь суманд барих 6 цэцэрлэгийн эзэмшил газрыг Иргэдийн хурлын тогтоол гаргаж, нөөцөд аваагүй;*
- *Дундговь аймгийн ерөнхий төлөвлөгөөнд туссан 8 цэцэрлэгийн газрыг нөөцөд төлөвлөснөөс өөр байршилд, 1000 метр квадратаар дутуу олгосон;*
- *Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд 4 цэцэрлэг шинээр барихаар төлөвлөснөөс 1 цэцэрлэгийн барилга төлөвлөгдсөн газарт баригдаагүй байна.*

2.35. Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газраас Нийслэл дэх Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн 2019 оны 01/3512 дугаар албан бичгээс үзэхэд 2016-2018 онд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийт 199 цэцэрлэг барихаар төлөвлөсөн боловч үүнээс 161 цэцэрлэг буюу 80.9 хувийг ашиглалтад хүлээн аваагүй байна.

***Шинээр барих орон сууцны хорооллын барилгын зураг төсөлд цэцэрлэгийг хамт төлөвлөн барих зохицуулалт тусгагдаагүй байна***

2.36. УИХ-ын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.3.1-т цэцэрлэгийн хүрэлцээг сайжруулах зорилгоор *“Улаанбаатар хот, аймгийн төвд шинээр барих орон сууцны хороолол, хотхоны зураг төсөл, ерөнхий төлөвлөгөөнд цэцэрлэгийг заавал тусгаж төлөвлөх чиглэлээр холбогдох норм, дүрэмд өөрчлөлт оруулж, тусгасан нөхцөлд газрын зөвшөөрлийг шийдвэрлэж байх зохицуулалтыг бий болгох”* арга хэмжээг төлөвлөсөн байна.

2.37. Аудитын хамарсан хугацаанд БХБЯ уг заалтыг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээгүй, Монгол Улсад одоо мөрдөж буй "*Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлтийн норм ба дүрэм*"-д шинээр барих орон сууцны барилгын зураг төсөлд СӨБ-ын байгууллага буюу цэцэрлэгийн барилгыг хамт төлөвлөн барих заалт тусгаагүй байна.

2.38. ЗТБХБС-ын 2010 оны 418 дугаар тушаалаар баталсан "*Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлтийн норм ба дүрэм*" /БНбД 31-01-10/-ийн 4.15-д *“... 2 талдаа цонхтой орон сууцны барилгад 10 хүртэлх хүүхдийн багтаамжтай гэрийн цэцэрлэг байрлах өрөө тасалгаа ... байрлуулахыг зөвшөөрнө”* гэж заасан байна.

2.39. МУЗГ-ын 2016 оны “Цэцэрлэгийн хүрэлцээг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 40 дүгээр тогтоолын 1-д *“Улаанбаатар хотод сургуулийн өмнөх боловсрол олгох цэцэрлэгийн хүрэлцээг сайжруулах зорилгоор шинээр барих орон сууцны хороолол, хотхон болон конторын зориулалттай 9-өөс дээш давхар барилгын зураг төсөлд цэцэрлэг төлөвлөн тусгаж байхаар холбогдох норм, дүрэмд өөрчлөлт оруулахыг БХБС Г.Мөнхбаярт үүрэг болгосон байна.”*

[55] Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь шинээр барих сургууль, цэцэрлэгийн урт хугацааны төлөвлөлтийг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж, сургууль, цэцэрлэгийн эзэмшил, ашиглалтын эдэлбэр газрыг сургалтын орчинд тавигдах шаардлагад нийцсэн талбайн хэмжээний дагуу нөөцөд авах шийдвэр гаргана.

2.28. Аймаг, орон нутагт зарим цэцэрлэгийн барилгын ашиглалтын хугацаа дууссанаас акталсан, зориулалтын бус байранд үйл ажиллагаа явуулсан, урсгал болон их засвар хийгээгүй нь Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1[47], Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7[48], “Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм /БНбД 13-04-03/”[49]-д заасантай нийцээгүй, хүүхдийн эрүүл, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал,

- *Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 3 дугаар цэцэрлэг нь Арьс өнгөний эмнэлгийн зориулалтаар 1966 онд баригдаж, 1991 онд актлагдсан байранд 2019 оныг хүртэл үйл ажиллагаа явуулсан байна. Одоогийн байдлаар тус цэцэрлэг "Думан" зочид буудлын өрөөнүүдийг түрээслэн үйл ажиллагаа явуулж байна;*
- *Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын 1 дүгээр цэцэрлэгийн үндсэн барилга 1974 онд баригдсанаас хойш 45 жил их засвар хийгээгүй;*
- *Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 6 дугаар цэцэрлэг нь арьс ширний үйлдвэрийн зориулалтаар баригдсан байранд 1975 оноос хойш 44 жил үйл ажиллагаа явуулж, 2018 онд акталсан байна;*
- *Дорнод аймгийн Хэрлэн сумын 1,5,8,14 дүгээр цэцэрлэг, Гурванзагал, Дашбалбар, Чойбалсан, Чулуунхороот сумдын цэцэрлэг ашиглалтад орсноос хойш 28-56 жилийн хугацаанд их засвар хийгдээгүй;*
- *Говь-сүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн 2 бүлэг, “Хонгорхон” хувийн цэцэрлэгийн 1 бүлэг болон “Буян”, “Тунгаамал” гэсэн хувийн цэцэрлэгүүд орон сууцны зориулалттай байранд, Баянтал сумын 4 дүгээр цэцэрлэг, “Бужинхэн” хувийн цэцэрлэг конторын зориулалттай байранд үйл ажиллагаа явуулж байна;*
- *Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын 50 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулснаас 8 жилийн дараа ашиглах боломжгүй болсноос сумын ЗДТГ-ын орон сууцны барилгад үйл ажиллагаа явуулж байна. Тус барилгад улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд 46.5 сая, 2017 онд 79.5 сая төгрөгийн засвар хийгдсэн нь үр ашиггүй болсон байна;*
- *Дундговь аймгийн Сайнцагаан сумын 6 дугаар цэцэрлэгийн барилгад 21 жилийн дараа засвар хийсэн;*
- *Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 100 хүүхдийн хүчин чадалтай 1 дүгээр цэцэрлэгийн барилгад ашиглалтад орсноос 57 жилийн дараа урсгал засвар хийсэн боловч санхүүжилтийг бүрэн шийдээгүйн улмаас дутуу хийгдэж, бохир үнэртдэг, мөөгөнцөртсөн байна;*
- *Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын цэцэрлэгт ашиглалтад орсноос хойш 49 жилийн дараа их засвар хийсэн;*
- *Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 1 дүгээр цэцэрлэгийн барилгыг Мэргэжлийн хяналтын газраас ашиглах боломжгүй дүгнэлт 2012, 2017 онд гаргасан боловч одоог хүртэл үйл ажиллагаа явуулж байна. Мөн тус сумын 4 дүгээр цэцэрлэгт МХЕГ-аас 2017, 2018 онд их засвар хийх шаардлагатай гэсэн боловч хийгээгүй;*
- *Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэгийн барилга нь ашиглалтад ороод 36 жил болсон тул Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газраас 8 удаа дүгнэлт гаргаж, үйл ажиллагаа явуулахыг хориглосон боловч барилгын талбайн хэмжээг томруулан 75 хүүхдийг хүлээн авч ажиллаж байна;*
- *Төв аймгийн Дэлгэрхаан сумын Дэгдээхэй цэцэрлэгийн барилга анх 1962 онд ашиглалтад орсноос хойш 57 жилийн хугацаанд их засварт ороогүй, бүлгийн ариун цэврийн өрөөнд суултуур, угаалтуур байхгүй.*



*Зураг 2. Баян-Өлгий аймгийн 3 дугаар цэцэрлэг*



*Зураг 3. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 7 дугаар цэцэрлэг*

[47] Боловсролын тухай хууль 42.1 “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна

[48] Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль 8.7 Цэцэрлэг нь барилга байгууламж, сургалтын орчны стандарт, хүүхдийн хоол хүнс, эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлын норм, нормативыг өмчийн хэлбэр харгалзахгүй мөрдөнө

[49] *БНбД 13-04-03 “урсгал засвар хийх хугацаа 3-5 жил, их засвар хийх хугацаа 15-20 жил”*



*Зураг 4. Төв аймгийн Дэгдээхэй цэцэрлэгийн ариун цэврийн өрөөний байдал*

2.29. Зарим аймгийн цэцэрлэгт анги, танхимыг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар нь ашиглаагүй байна. Үүнд:

- *Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сум - 2018 оны байдлаар сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 66 хүүхэд хамрагдаагүй үлдсэн болович тус сумын цэцэрлэг 2 ангийг агуулахын зориулалтаар ашигласнаас 50 хүүхдийг цэцэрлэгт хамруулах боломжийг алдсан байна.*
- *Дундговь аймгийн Луус сумын 100 хүүхдийн хүчин чадалтай, 4 бүлэгтэй цэцэрлэгт 2016-2018 онд дунджаар 66 хүүхэд хамрагдаж, бүрэн хүчин чадлаар ажиллагаагүйгээс 2018 онд 1 бүлгийг хаасан байна.*

2.30. Шинээр барих цэцэрлэгийн давхрын хязгаарыг “Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм” БНбД 2-66-88”-ийн 4.5-д “*сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагыг 2 давхраас илүүгүй”* гэж заасан боловч “Олон нийт, иргэний барилгын зураг төсөл зохиох норм, дүрэм” БНбД 31-03-03-ийн 3.4-т барилгын хүчин чадал, барилгын галд тэсвэршилтийн зэргээс хамааран 1-3 давхар байхаар зөрүүтэй заасан байна. Үүнд:

*Хүснэгт 2. Сургуулийн өмнөх насны хүүхдийн барилгын хүчин чадал, давхрын хязгаар, барилгын галд тэсвэршилтийн зэрэг хоорондын хамаарал*

| *Барилгын хүчин чадал* | *Гал тэсвэршилтийн зэрэг* | *Давхрын тоо* |
|---|---|---|
| *50 хүртэлх* | *IV* | *1* |
| *160 хүртэлх* | *III* | *2* |
| *320 хүртэл* | *II, I* | *2-3* |

*Эх сурвалж: “Олон нийт, иргэний барилгын зураг төсөл зохиох норм, дүрэм” /БНбД 31-03-03/*

***Хот байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд тавих хяналт сул, барилгын норм ба дүрэмд шинээр баригдах орон сууцны хороолол, хотхоныг цэцэрлэгийн барилгын хамт төлөвлөж, барих зохицуулалтгүй байна***

2.31. Хот байгуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5[50], 6 дугаар зүйлийн 6.1.4[51] 8 дугаар зүйлийн 8.1.5[52]-д заасны дагуу УИХ, Засгийн газар, ИТХ нь нийслэл, бүсийн хөгжлийн тулгуур төв хот, аймгийн *“хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”[53]*-г АНИХ нь *“хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”[54]*-г батлах эрхтэй бөгөөд 16 аймаг нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөө баталсан, 5 аймаг нь батлаагүй байна. Үүнд:

- *Дархан-Уул аймаг 2004 онд;*
- *Өвөрхангай аймаг 2009 онд;*
- *Улаанбаатар, Дорноговь, Сэлэнгэ аймгууд 2013 онд;*
- *Говь-сүмбэр аймаг 2014 онд;*
- *Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий аймгууд 2015 онд;*
- *Говь-Алтай, Сүхбаатар аймгууд 2016 онд;*
- *Дундговь, Баянхонгор, Ховд, Дорнод аймгууд 2017 онд;*
- *Увс аймаг 2018 онд;*

[50] Хот байгуулалтын тухай хууль 5.1.Улсын Их Хурал хот байгуулалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.1.5.нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах.

[51] Хот байгуулалтын тухай хууль 6.1.Засгийн газар хот байгуулалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 6.1.4.бүсийн хөгжлийн тулгуур төв хот, түүнчлэн томоохон уул уурхайн орд газар, үйлдвэр, нисэх онгоцны буудлыг даган бий болсон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах;

[52] Хот байгуулалтын тухай хууль 8.1 Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хот байгуулалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.1.5.бүс нутгийн хөгжлийн төслийн үндсэн шийдэлтэй уялдуулан орон нутгийн зэрэглэлтэй хот болон тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах;

[53] Хот байгуулалтын тухай хууль 3.1.3.“хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” гэж хот, тосгоны хүн амын эрүүл, аюулгүй амьдрах, ажиллах таатай орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн хот байгуулалтын үндсэн баримт бичгийг;

[54] Хот байгуулалтын тухай хууль 3.1.12.”хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” гэж хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу тухайн дүүрэг, орон сууцны болон гэр хорооллын газар зохион байгуулалт, барилгажилт, тохижилтын төлөвлөлт, инженерийн шугам сүлжээний хангамжийг нарийвчлан тодотгож төлөвлөсөн хот байгуулалтын үйл ажиллагааны баримт бичгийг;

- *Төв аймаг 2019 онд баталсан;*
- *Архангай, Булган, Орхон, Баян-Өлгий, Завхан аймгууд батлаагүй байна.*

2.32. БХБЯ нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй аймгуудад “хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулахыг чиглэл болгосон боловч хэрэгжилт хангалтгүй байна.

2.33. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй, боловсруулах шатандаа байгаа аймгуудын хувьд шинээр барих СӨБ-ын байгууллагын барилгыг хот төлөвлөлтийн системтэйгээ уялдуулж, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж буй эсэх нь тодорхойгүй байна.

2.34. АНИХ нь Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7[55] -д заасны дагуу шинээр барих цэцэрлэгийн барилгын эзэмшил, ашиглалтын эдэлбэр газрыг нөөцөд авах шийдвэрийг гаргаагүй, зарим аймгийн хувьд ИТХ-аас нөөцөд авах тухай гаргасан тогтоолын хэрэгжилт хангалтгүй байгаа нь цэцэрлэгийн хүртээмжид сөргөөр нөлөөлсөн байна. Тухайлбал,

- *Дорнод аймгийн Чойбалсан хотын ерөнхий төлөвлөгөөнд шинээр 16 цэцэрлэгийн барилга тусгасан боловч тус байршилд ААНБ, иргэнд өмчлөл, эзэмшлээр газар олгосон;*
- *Говь-сүмбэр аймгийн Сүмбэр сумд барих 6, Шивээговь суманд барих 6 цэцэрлэгийн эзэмшил газрыг Иргэдийн хурлын тогтоол гаргаж, нөөцөд аваагүй;*
- *Дундговь аймгийн ерөнхий төлөвлөгөөнд туссан 8 цэцэрлэгийн газрыг нөөцөд төлөвлөснөөс өөр байршилд, 1000 метр квадратаар дутуу олгосон;*
- *Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд 4 цэцэрлэг шинээр барихаар төлөвлөснөөс 1 цэцэрлэгийн барилга төлөвлөгдсөн газарт баригдаагүй байна.*

2.35. Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газраас Нийслэл дэх Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн 2019 оны 01/3512 дугаар албан бичгээс үзэхэд 2016-2018 онд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийт 199 цэцэрлэг барихаар төлөвлөсөн боловч үүнээс 161 цэцэрлэг буюу 80.9 хувийг ашиглалтад хүлээн аваагүй байна.

***Шинээр барих орон сууцны хорооллын барилгын зураг төсөлд цэцэрлэгийг хамт төлөвлөн барих зохицуулалт тусгагдаагүй байна***

2.36. УИХ-ын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.3.1-т цэцэрлэгийн хүрэлцээг сайжруулах зорилгоор *“Улаанбаатар хот, аймгийн төвд шинээр барих орон сууцны хороолол, хотхоны зураг төсөл, ерөнхий төлөвлөгөөнд цэцэрлэгийг заавал тусгаж төлөвлөх чиглэлээр холбогдох норм, дүрэмд өөрчлөлт оруулж, тусгасан нөхцөлд газрын зөвшөөрлийг шийдвэрлэж байх зохицуулалтыг бий болгох”* арга хэмжээг төлөвлөсөн байна.

2.37. Аудитын хамарсан хугацаанд БХБЯ уг заалтыг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээгүй, Монгол Улсад одоо мөрдөж буй "*Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлтийн норм ба дүрэм*"-д шинээр барих орон сууцны барилгын зураг төсөлд СӨБ-ын байгууллага буюу цэцэрлэгийн барилгыг хамт төлөвлөн барих заалт тусгаагүй байна.

2.38. ЗТБХБС-ын 2010 оны 418 дугаар тушаалаар баталсан "*Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлтийн норм ба дүрэм*" /БНбД 31-01-10/-ийн 4.15-д *“... 2 талдаа цонхтой орон сууцны барилгад 10 хүртэлх хүүхдийн багтаамжтай гэрийн цэцэрлэг байрлах өрөө тасалгаа ... байрлуулахыг зөвшөөрнө”* гэж заасан байна.

2.39. МУЗГ-ын 2016 оны “Цэцэрлэгийн хүрэлцээг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 40 дүгээр тогтоолын 1-д *“Улаанбаатар хотод сургуулийн өмнөх боловсрол олгох цэцэрлэгийн хүрэлцээг сайжруулах зорилгоор шинээр барих орон сууцны хороолол, хотхон болон конторын зориулалттай 9-өөс дээш давхар барилгын зураг төсөлд цэцэрлэг төлөвлөн тусгаж байхаар холбогдох норм, дүрэмд өөрчлөлт оруулахыг БХБС Г.Мөнхбаярт үүрэг болгосон байна.”*

[55] Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь шинээр барих сургууль, цэцэрлэгийн урт хугацааны төлөвлөлтийг аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын хөгжлийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгаж, сургууль, цэцэрлэгийн эзэмшил, ашиглалтын эдэлбэр газрыг сургалтын орчинд тавигдах шаардлагад нийцсэн талбайн хэмжээний дагуу нөөцөд авах шийдвэр гаргана.

2.40. Уг норм ба дүрэмд орон сууцны барилгад байрлах цэцэрлэг 10 хүртэлх хүүхдийн багтаамжтай байхаар заасан нь “Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм” /БНбД 2-66-88”-ийн 1.9-т *“ердийн цэцэрлэгийн нэг бүлэгт 20 хүүхэдтэй”*, “Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 2.3-т “1 бүлэгт үндсэн сургалттай цэцэрлэгт 20-25 хүүхэдтэй байх” гэж заасантай нийцээгүй төдийгүй хүн амын тоо өсөлттэй, цэцэрлэгийн хүртээмж хангалтгүй байгаа өнөөгийн нөхцөлд хамран сургалтыг төдийлөн нэмэхээргүй байна.

2.41. Сүүлийн 3 жилд батлагдсан 275 орон сууцны барилга, хороолол барих архитектурын төлөвлөлтийн даалгаварт 111 цэцэрлэгийг ашиглалтад оруулахаар төлөвлөсөн бөгөөд орон сууцны барилгууд бүрэн баригдсан боловч холбогдох мэргэжлийн байгууллагын зүгээс архитектур төлөвлөлтийн даалгаврын дагуу зураг төслийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэхэд тавих хяналт хангалтгүйгээс цэцэрлэгийн барилгын 61.3 хувийг ашиглалтад оруулаагүй байна.

***Сургуулийн өмнөх насны хүүхэд бүр СӨБ-ын үйлчилгээнд бүрэн хамрагдаагүй байна***

2.42. УИХ, Засгийн газраас баталсан бодлогын баримт бичигт сургуулийн сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийн талаар дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

**УИХ-ын тогтоол 2015.01.29, Дугаар 12**

- "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай"
- 7.6-д "Монгол хүүхэд бүр үндсэн, цагийн, улирлын, ээлжийн явуулын багшийн, нүүдлийн зэрэг хэлбэрээр СӨБ-ын үйлчилгээнд хамрагдсан байна"

**УИХ-ын тогтоол 2016.02.05, Дугаар 19**

- “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030 батлах тухай”
- 2.2.3.Мэдлэгт суурилсан нийгэм ба үр чадвар бүхий Монгол хүн:
- Зорилт 1.Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшүүлнэ.
- I үе шат (2016-2020): Сургуулийн өмнөх боловсролын тогтолцооны төрөл хэлбэрийг өргөтгөж, хүртээмж, чанарыг сайжруулан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 70 хувийг хамруулах нөхцөл бүрдүүлэх.

**УИХ-ын тогтоол 2016.09.09, Дугаар 45**

- "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай"
- Боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, амьдралд нийцтэй болгоно. Хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт суралцах боломжтой болно.
- 3.2.2.“Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлж хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгоно.
- 3.2.5.“Байгууллагын цэцэрлэг”-ийн хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, татварын бодлогоор дэмжинэ.

2.43. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн $7^1$ дугаар зүйлийн $7^1$.2-т *“Сургуулийн өмнөх боловсролд 2 наснаас сургуульд элсэх насны бүх хүүхдийг хамруулна”,* 14 дүгээр зүйлийн 14.2.2-т *“хүүхдийг сургуульд элсэхийн өмнөх насанд нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд заавал хамруулах, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах”* гэж заасны дагуу эцэг, эх, асран хамгаалагч нь 5 настай хүүхдийг заавал хамруулах үүрэгтэй байна.

2.44. БСШУСЯ нь 2016-2018 онд жилд хамран сургалт дунджаар 82 хувьтай, 253.0 мянган хүүхэд цэцэрлэгт хамрагдсан гэж тайлагнасан бөгөөд байршлын хувьд Баян-өлгий аймагт хамгийн бага буюу 61 хувь, Завхан аймагт хамгийн их буюу 91 хувьтай, насны бүтцийн хувьд 2 настай хүүхэд хамгийн бага буюу 64 хувь, 5 настай хүүхдүүд хамгийн их буюу 89 хувьтай байна.

*Дүрсэлэл 15. СӨБ-д 2016-2018 онд хамрагдалтын хувь /насны бүтцээр, 2016-2018 оны дундаж/*




*Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик*

2.45. БСШУСЯ боловсролын салбарын статистик мэдээ гаргахдаа хамруулбал зохих хүүхдийг 2-5 насны хүүхдийн тоогоор, харин хамруулсан хүүхдийг 2-5 настай хүүхдийн тоон дээр 2 хүртэлх болон 6 настай хүүхдийг нэмж тооцсоноос дээрх мэдээлэлд жилд дунджаар 8600 хүүхдийн тоогоор хамран сургалтын хувийг нэмсэн байна. СӨБ-ын үйлчилгээний 2016-2018 онд хамрагдалтыг “Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль”-ийн $7^1$ дугаар зүйлийн $7^1$.2-т заасан насны нийт хүүхдүүдийн дунджаар гаргахад хамран сургалт 76 хувь болж, 73.0 мянган хүүхэд хамрагдаагүй үлдсэн байна.

2.46. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд заасан насанд хамаарахгүй буюу 2 хүртэлх болон 6 настай хүүхдийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулж байгаа нь уг хуульд заавал хамруулахаар заасан 5 настай 9590 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж сургуульд бэлтгэгдэх боломжийг алдсан байна.

*Дүрсэлэл 16. СӨБ-ын хамран сургалтын байдал /хувь, хүүхдийн тоо/*




*Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик*

2.47. Цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд эцэг, эх, асран хамгаалагчаар дамжуулан гэр бүлийн орчинд СӨБ олгох зорилгоор дараах хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

- *БСШУСС-ын 2018 оны А/487 дугаар тушаалаар баталсан “Бага насны хүүхдийг гэр бүлийн орчинд хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд цэцэрлэгт хамрагдах боломжгүй 4-5 настай хүүхдийг тэдний эцэг, эх, асран хамгаалагчаар дамжуулан гэр бүлийн орчинд нь албан бус СӨБ олгох,*

## Зохион байгуулах орчин, багшийн хүрэлцээ хангалтгүйгээс хувилбарт сургалтын хамралт буурсан байна

2.48. Төрийн өмчийн цэцэрлэгүүд Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9[56], 8 дугаар зүйлийн 8.4[57] заалтын дагуу 2016-2018 онд 2-5 насны нийт хүүхдийн 12.9 орчим хувь буюу 21590-23705 цэцэрлэгт хамрагдаж чадаагүй хүүхдийг хувилбарт сургалтад хамруулжээ.

[56] Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль 4.1.9.“хувилбарт сургалт” гэж үндсэн сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх “ээлжийн бүлгийн”, “явуулын багшийн”, “нүүдлийн бүлгийн” сургалтын үйл ажиллагаа;
[57] Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль 8.4.Цэцэрлэг нь хамран сургах тойргийнхоо цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалт зохион байгуулж, тэдний эцэг, эх, асран хамгаалагчид мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.

*Дүрслэл 17. Хувилбарт сургалтын хамрагдалт, хэлбэр*




*Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик*

2.49. Хувилбарт сургалтад нүүдлийн бүлгийн сургалт[58] хамгийн өндөр буюу дунджаар 15940 хүүхэд, ээлжийн бүлгийн сургалтад 4131 хүүхэд, явуулын багшийн сургалтад 2900 хүүхэд хамруулсан боловч анги танхим, гэр цэцэрлэг, багшийн хүрэлцээгүйгээс 2018 онд хамрагдалт буурсан байна.

2.50. 2016-2018 онд Баянхонгор, Булган, Говь-Алтай, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Увс аймгууд нийт 2-5 настай хүүхдүүдийн 18-25 хувийг хувилбарт сургалтад хамруулсан нь хамгийн өндөр байгаа бол Дархан-Уул, Улаанбаатар хотод 0.5-1.0 хувьтай хамгийн бага, харин Орхон аймагт хувилбарт сургалт зохион байгуулаагүй байна.

*Дүрслэл 18. Хувилбарт сургалтын хамран сургалтын хувь*




*Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик*

2.51. Зарим аймагт хувилбарт сургалт зохион байгуулсан тоо, хамрагдалтын мэдээг бодитой илэрхийлээгүй байна. Үүнд:

- *Өвөрхангай аймгийн төвийн цэцэрлэгүүд хувилбарт сургалт зохион байгуулаагүй байхад 2016 онд 323, 2017 онд 358, 2018 онд 237 хүүхэд хамруулсан гэж статистик мэдээндээ тусгасан, 2018 онд хувилбарт сургалтын хамран сургалтын хувь 23 хувь байхад 25.3 хувь гэж зөрүүтэй илэрхийлсэн;*
- *Дундговь аймгийн Луус суманд 2018 онд өдөр өнжүүлэхэд хамрагдсан 32 хүүхдийг хувилбарт сургалтад хамруулсан гэж статистик мэдээнд тайлагнасан.*

***Гэр цэцэрлэгийн хөрөнгө оруулалт хувилбарт сургалтад чиглээгүй, бодитой төлөвлөөгүй байна***

2.52. БСШУСЯ гэр цэцэрлэгийн хөрөнгө оруулалтыг "МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 3.2.2.2-т "улс, орон

[58] СӨБ-ын тухай хуулийн 4.1.12 "нүүдлийн бүлгийн сургалт гэж боловсролын стандартыг баримтлан гэр бүл, хүүхдэд үйлчлэх сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх сургалтын зохион байгуулалттай үйл ажиллагаа"

нутгийн төсөв, гадаад тусламжийн эх үүсвэрээр жил бүр 50 гэр цэцэрлэг нийлүүлэх, малчны нийт 1000 хүүхдийг хамруулах" гэсэн зорилтын хүрээнд хэрэгжүүлж байна.

2.53. БСШУСЯ-ны гэр цэцэрлэгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт тухайн орон нутгийн бага насны хүүхдийн тоо, СӨБ-ын үйлчилгээнд хамрагдаагүй хүүхдийн тоо зэрэг бодит хэрэгцээ, судалгаанд үндэслээгүй, тухайн онуудын төсвийн тухай хууль батлагдсанаас хойш орон нутгаас ирүүлсэн хүсэлтийн дагуу гэр нийлүүлсэн байна. Тухайлбал,

- *Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль батлагдсанаас хойш 10 сарын дараа буюу 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр Завхан аймгийн Баянхайрхан сумын Засаг дарга гэр цэцэрлэг шийдвэрлэж өгөх хүсэлт гаргасны дагуу БСШУСЯ тухайн оны 12 дугаар сарын 19-ний өдөр 5 ханатай, иж бүрэн тавилгатай гэр 2 ширхгийг хүлээлгэн өгсөн;*
- *2017-2018 онд нийт бэлтгэсэн гэр цэцэрлэгийн 30-50 хувийг Улаанбаатар хотын цэцэрлэгүүдэд хувилбарт сургалт бус үндсэн сургалтын үйл ажиллагаа явуулдаг цэцэрлэгт нийлүүлсэн. Улаанбаатар хотод хувилбарт сургалтын хамрагдалт 2018 онд 2016 онтой харьцуулахад 41 хувиар буурсан байна.*

### Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн өмнөх боловсрол эзэмших хүртээмжтэй орчин, нөхцөлийг бий болгоогүйгээс хамран сургалт буурсан байна

2.54. Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1[59], 43 дугаар зүйлийн 43.2.7[60], Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2[61], 9 дүгээр зүйлийн 9.9[62] заалтын хүрээнд тусгай болон ердийн цэцэрлэгт 2016 онд 1482, 2017 онд 1562, 2018 онд 1073 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдсан байна.

2.55. Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1[63], Дэд Бүтцийн сайдын 2003 оны 252 дугаар тушаалаар баталсан "Олон нийтийн барилгын зураг төсөл зохиох норм ба дүрэм"-ийн 2.1[64], Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 55 дугаар тогтоолоор баталсан "Сургуулийн өмнөх байгууллагын сургалтын орчны стандарт"-ын 2.2[65]-т тусгай цэцэрлэгийн барилгын төлөвлөлт, сургалтын орчны талаар тусгасан байна.

2.56. Ердийн цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай хэрэгцээнд нийцсэн аюулгүй орчин бүрдээгүй, нэг бүлэгт хамрагдах хүүхдийн тоо 2 дахин хэтэрсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах багш дутагдалтай байгаагаас хамран сургалт буурсан байна.

2.57. МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.5-д тусгасан "Байгууллагын цэцэрлэгийн хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх" зорилт биелээгүйгээс байгууллагын цэцэрлэг хэлбэрээр 2016-2018 онд ажиллаж байсан 10 цэцэрлэг улсын цэцэрлэгийн салбар бүлэг хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.

### Төрөөс хувийн цэцэрлэгийг онцлог, төлбөрийн хэмжээгээс нь хамааруулж ялгаатай бодлогоор дэмжих шаардлагатай байна

2.58. Нийслэлд 2018 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй хувийн цэцэрлэгийн 34 хувь нь Баянзүрх, 20 хувь нь Хан-Уул, 17 хувь нь Баянгол, 14 хувь нь Сонгинохайрхан, 7 хувь нь Сүхбаатар, 6 хувь нь Чингэлтэй, 1 хувь нь Налайх дүүрэгт байршилтай байна.

[59] Боловсролын тухай хууль 42.1.Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.
[60] Боловсролын тухай хууль 43.2.7.суралцагчийн онцгой авьяас, чадварыг нээн илрүүлж хөгжүүлэх, урамшуулан дэмжих, өнчин, амьжиргааны түвшин доогуур, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг сурах нөхцөл бололцоогоор төрөөс хангах;
[61] СӨБ-ын тухай хууль 4.1.2."тусгай цэцэрлэг" гэж хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтын байгууллагыг;
[62] СӨБ-ын тухай хууль 9.9.Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж болох бөгөөд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болно.
[63] Боловсролын тухай хууль 42.1 Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна
[64] Олон нийтийн барилгын зураг төсөл зохиох норм ба дүрэм 2.1 тусгай зориулалтын цэцэрлэгийн барилгад үндсэн өрөө тасалгаанаас гадна сонсгол муутай хүүхэд хичээллэх анги, хараа муутай хүүхэд хичээллэх тифлопедийн кабинет, тултираа хүүхэд хичээллэх хэл яриа хөгжүүлэх танхим төлөвлөнө
[65] Сургуулийн өмнөх байгууллагын сургалтын орчны стандарт"-ын 2.2 тусгай цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээ

2.59. Хувийн цэцэрлэгүүдийн онцлог, байршил, сургалтын төлбөр харилцан адилгүй боловч төрөөс хувьсах зардлыг зөвхөн хүүхдийн тоонд үндэслэн ижил олгож байна.

- *БГД-т 50.0-350.0 мянган төгрөг, БЗД-т 50.0-650.0 мянган төгрөг, Налайх дүүрэгт 110.0-180.0 мянган төгрөг, СБД-т 50.0-766.0 мянган төгрөг, СХД-т 20.0-600.0 мянган төгрөг, ЧД-т 40.0-350.0 мянган төгрөг, ХУД-т 40.0-1,350.0 мянган төгрөг буюу хамгийн өндөр төлбөртэй цэцэрлэгүүд ХУД-т байршилтай байна.*

2.60. Нэг зуун мянган төгрөгөөс доош төлбөртэй цэцэрлэгүүд ихэвчлэн БГД, БЗД, СХД дүүрэгт байршилтай бөгөөд гэр хороолол ихтэй, зорилтот бүлгийн айл өрхтэй дүүрэгт төлбөргүй хувийн цэцэрлэг ажиллаж, СӨБ-ын үйлчилгээ үзүүлж байгаа нь сайшаалтай байна.

- *Тухайлбал, 2018 онд СХД-т 5, ХУД-т 1 цэцэрлэг төлбөргүй үйл ажиллагаа явуулж байжээ.*

2.61. Бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй зарим хувийн цэцэрлэгийн хүсэлтийг үндэслэн НЗД-ын захирамжаар цэцэрлэгийн хүрэлцээ хангалтгүй байгаа дүүрэг, хороодын 3087-3147 хүүхдийг хувийн цэцэрлэгт хамруулж, хувьсах зардал, хоолны мөнгө олгосон нь зохион байгуулалтын оновчтой арга хэмжээ болжээ. Үүнд:

*Хүснэгт 3. Хувийн цэцэрлэгт нэмэлт элсэлтээр хамруулсан хүүхдийн судалгаа*

| № | Дүүрэг | 2016 он | | 2017 он | | 2018 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | цэцэрлэгийн тоо | элсэх хүүхдийн тоо | цэцэрлэгийн тоо | элсэх хүүхдийн тоо | цэцэрлэгийн тоо | элсэх хүүхдийн тоо |
| 1 | БГД | 24 | 691 | 29 | 582 | 29 | 582 |
| 2 | БЗД | 37 | 934 | 38 | 934 | 43 | 956 |
| 3 | СБД | 9 | 167 | 14 | 246 | 11 | 256 |
| 4 | СХД | 24 | 732 | 27 | 762 | 28 | 787 |
| 5 | ЧД | 14 | 370 | 16 | 370 | 12 | 283 |
| 6 | ХУД | 7 | 133 | 16 | 133 | 10 | 223 |
| 7 | Налайх | 2 | 60 | 3 | 60 | 2 | 60 |
| | **Нийт дүн** | **117** | **3087** | **143** | **3087** | **135** | **3147** |

2.62. Нийслэлд газрын хүрэлцээгүйгээс хувийн цэцэрлэгүүдийн дийлэнх нь тусдаа барилгагүй, орон сууцны 1 дүгээр давхарт стандартын шаардлага хангахгүй байранд үйл ажиллагаа явуулж байгаа нь “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандарт MNS 6558:2015”-д заасан гадна орчинд тусдаа тоглоомын талбай, ногоон байгууламжтай байх гэсэн шаардлагыг хангахад хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байна.

## *Сургуулийн өмнөх боловсролын чанарын үнэлгээ хийгдэхгүй байна*

2.63. БСШУС-ын 2013 оны А/327 дугаар тушаалаар баталсан “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого”-ын 4.1-т заасны[66] дагуу салбарын яам олон улсын СӨБ-ын сургалтын хүрээ, хөтөлбөрийн дагуу хүүхдэд эзэмшүүлдэг чадварт харьцуулсан судалгаа хийж, сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулжээ.

*Хүснэгт 4. Олон улсын СӨБ-ын хөтөлбөрийн судалгаа*

| № | Улсын нэр | Баримт бичгийн нэр | Судалгааны чиглэл |
|---|---|---|---|
| 1 | Сингапур | “Цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрийн хүрээ” 2012 он | Сургалын зорилго (конпетенцүүд=мэдлэг, чадвар, зан чанар)<br>Сургалтын зарчмууд<br>Сургалтын бүрэлдэхүүн хэсгүүд, тэдгээрийн зорилго/зорилт<br>Сургалтын бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн хүрээнд хийгдэх үйл ажиллагаа /багш, хүүхдийн гүйцэтгэх үйл ажиллагаа/<br>Сургалтын зохион байгуулалтын талаар өгсөн удирдамж, чиглэл<br>Хүүхдийн хөгжлийн үнэлгээний талаарх удирдамж, чиглэл |
| 2 | Япон | “Цэцэрлэгийн сургалт, хүмүүжлийн хөтөлбөр” 2008 он | |
| 3 | Финлянд | “Сургуулийн өмнөх боловсролын үндэсний цөм хөтөлбөр” 2010 он | |
| 4 | Канад | Канадын Брижини Колумбия мужийн “Бага насны хүүхдийн суралцахуйн хүрээ” 2008 он | |
| 5 | ОХУ | “Сургуулийн өмнөх боловсролын үндсэн сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр” 2012 он | |

*Эх сурвалж: БСШУСЯ-ны СӨББГ*

[66] 4.1. “СӨБ-ын сургалтын талаар баримтлах бодлого, стратеги, бага насны хүүхдийн суралцахуйн талаар дэлхийн улс орнуудын баримталж буй чиг хандлага, монгол хүүхдийн онцлогт баримжаалан сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалтын хөтөлбөрийг хөгжүүлнэ

2.64. УИХ-ын 2015 оны 12 дугаар тогтоолоор “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014-2024”, БСШУС-ын 2015 оны А/301 дүгээр тушаалаар хүүхдийн хөгжлийг ахицаар үнэлэх үнэлгээ бүхий “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр”-ийг баталж, 2015-2016 оны хичээлийн жилээс уг хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлжээ.

2.65. Уг хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн “Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар “*Боловсрол, сургалтын стандартыг өмчийн бүх хэлбэрийн сургалтын байгууллага дагаж мөрдөнө.*” гэсэн заалтыг “*Сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг өмчийн бүх хэлбэрийн боловсролын сургалтын байгууллага дагаж мөрдөнө*” гэж өөрчлөн найруулсан байна.

2.66. БСШУСС-ын 2018 оны А/446 дугаар тушаалаар “*Сургуулийн өмнөх боловсролын цөм хөтөлбөр, хөтөлбөрийн агуулга, хэрэгжилт*”-д үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталж, үнэлгээний дүнг 2018 оны 10 дугаар сард багтаан танилцуулахыг үүрэг болгосон болович ажлын хэсгийн тайлан аудитын хугацаанд баталгаажаагүй байлаа.

2.67. БСШУСС-ын 2019 оны А/494 дугаар тушаалаар хүүхдийн хөгжлийн үнэлгээ бүхий “Сургуулийн өмнөх боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд уг сайжруулсан хөтөлбөрт нийцүүлэн сургалтын хөтөлбөрөө шинэчилж 2019-2020 оны хичээлийн жилээс сургалтад хэрэгжүүлэхийг нийт цэцэрлэгт үүрэг болгожээ.

***Сургалтын хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийгээгүй, хүүхдийн хөгжлийн ахицын үнэлгээний журамгүйгээс Сургуулийн өмнөх боловсролын чанарыг үнэлж дүгнэх боломжгүй байна.***

2.68. Суралцагчийн болон боловсролын чанарт үнэлгээ хийх асуудлыг холбогдох хууль, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дараах байдлаар тусгажээ.

*Хүснэгт 5. Боловсролын үнэлгээний талаарх хууль, хөтөлбөрийн холбогдох заалтууд*

| | ***Хууль, хөтөлбөр*** | ***Хуулийн заалт*** |
|---|---|---|
| *1* | *Боловсролын тухай хууль* | *17 дугаар зүйл Боловсролын үнэлгээний байгууллага*<br>*17.1. Боловсролын үнэлгээний байгууллага бүх шатны боловсролын чанарт үнэлгээ, судалгаа хийх, дээд боловсролын хөтөлбөрт элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтыг үндэсний түвшинд хариуцан зохион байгуулах чиг үүрэг бүхий хуулийн этгээд мөн.* |
| | | *28 дугаар зүйл Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага*<br>*28.1.8. боловсролын хөтөлбөр, норм, нормативыг хэрхэн хэрэгжүүлж байгааг тогтоох зорилгоор боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн чанарт үнэлгээ хийх, дүгнэлт гаргах, хүүхдийн хөгжлийн ахиц дэвшлийг дэмжих, баталгаажуулах чиглэлээр мэргэжлийн удирдлагаар хангах;* |
| *2* | *Сургуулийн өмнөх боловсролын тухай* | *7.1 Хүүхдийн чадвар, чадамж, хөгжлийн ахицыг үнэлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.* |
| | | *7.2. Цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу үнэлж, дүгнэнэ.* |
| *3* | *МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр* | *3.2.9. Боловсролын түвшин, чиглэл тус бүрээр үнэлгээний систем, шалгуур, аргачлалын хянан сайжруулж үйлчилгээний чанар, үр дүнг эцэг ,эх, суралцагчдын оролцоотой үнэлэх боломжтой болгоно.* |

*Эх сурвалж: www.legalinfo.mn*

2.69. БСШУС-ын “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр батлах” тухай 2015 оны А/301 дүгээр тушаалд “*Цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, дүнг танилцуулж ажиллах”*-ыг хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгжид даалгасан болович хяналт, шинжилгээ хийгээгүй байна.

2.70. Сургалтын цөм хөтөлбөр, сайжруулсан хөтөлбөрт зааснаар сургалтын чиглэл бүрээр заасан тусгай чадварыг хүүхэд эзэмшсэнээр сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт хэрэгжих, тэдэнд ерөнхий чадварууд бий болох нөхцөл бүрддэг байна. Хүүхдийн эзэмших тусгай чадвар тус бүр дараах 3 түвшинтэй байна. Үүнд:

- *I түвшин - 3 хүртэлх нас;*
- *II түвшин - 3-4 нас;*
- *III түвшин - 6 хүртэлх настай хүүхэд.*

2.71. Хүүхдийн хөгжлийн үнэлгээ нь дараах циклийн дагуу тасралтгүй явагдах бөгөөд хичээлийн жилд 2 удаа 9-11 дүгээр сард гараaны үнэлгээ, хавар 4-6 дугаар сард хүүхдийн ахицын үнэлгээг хийдэг байна.

*Дүрслэл 19. Хүүхдийн ахицыг үнэлэх цикл*




*Эх сурвалж: Сайжруулсан сургалтын хөтөлбөр*

2.72. Сургалтын цөм хөтөлбөрөөр хүүхдийн ахицыг үнэлэх ажиглалтын хуудсаар I ба II, III түвшинд нийт 114 асуумжаар үнэлдэг байсан бол сайжруулсан сургалтын хөтөлбөрөөр хүүхдийн хөгжлийн үнэлгээний хуудсаар I, II, III түвшин тус бүрээр нийт 45 асуумжаар үнэлэх болсон байна. /*Дэлгэрэнгүйг Хавсралт 6-с үзнэ үү*/

2.73. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1[67]-д заасан "*Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн ахицын үнэлгээний журам*"-ын төслийг Боловсролын үнэлгээний төв 2018 онд боловсруулсан ч өнөөдрийг хүртэл уг журмыг батлаагүйгээс СӨБ-ын чанарт үнэлгээ хийгдээгүй байна.

2.74. Боловсролын үнэлгээний төв 2015 оноос эхлэн жил бүр сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн үзүүлэлт тогтоох зорилгоор аймаг, нийслэлийн төрийн болон хувийн цэцэрлэгийн нийт хүүхдийн 10 орчим хувийг хамруулан, хүүхдийн хөгжлийн үзүүлэлтийн мэдээллийг ажиглалтын хуудсаар онлайнаар цуглуулж, нэгтгэн дүгнэсэн[68] байна. Тухайлбал,

- *2016-2018 оны хугацаанд СӨБ-д хамрагдаж буй хүүхдүүдийн чадамж сайжирсан;*
- *Орон нутгийн хүүхдийн хөгжлийн амжилт Улаанбаатар хотын хүүхдийн амжилтаас өндөр;*
- *Хувийн цэцэрлэгийн хүүхдийн хөгжлийн амжилт төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн амжилтаас өндөр,*
- *Багшийн хүүхдийг үнэлэх чадвар сайжирсан;*
- *Нийт чадамжуудаас хөдөлгөөн, эрүүл мэндийн чадамж хамгийн бага үзүүлэлттэй, хэл ярианы чадамж хамгийн өндөр үзүүлэлттэй байна.*

2.75. Уг судалгаа нь бодит ажиглалтад суурилаагүй, зөвхөн ажиглалтын хуудас, багшийн үнэлгээг онлайнаар нэгтгэн тайлагнасан, мөн багш нарын хүүхдийн үнэлгээний талаарх ойлголт харилцан адилгүй байгаа зэргээс судалгааны үр дүн бодит бус байх эрсдэлтэй байна.

2.76. Боловролын үнэлгээний төвийн зүгээс аудитын түүвэрт хамрагдсан төрийн болон хувийн цэцэрлэгийн хүүхдийн 2018-2019 оны хичээлийн жилийн ахицын үнэлгээг улсын дундажтай харьцуулахад "*багш нар хүүхдийг ажиглах, үнэлэх, бүлгийн болон цэцэрлэгийн нэгтгэл хийх аргачлалд суралцаагүй нь хүүхдийн үнэлгээний хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна*" гэж дүгнэжээ.

2.77. Мөн СӨБ-ын багш бэлтгэдэг их, дээд сургуульд суралцагсдын судалж буй хичээлийг харьцуулж үзэхэд 2018 оны байдлаар МУБИС-ийн СӨБС, "Сэрүүлэг" их сургуулиас бусад

[67] СӨБ-ын тухай хууль 7.1 Хүүхдийн чадвар, чадамж, хөгжлийн ахицыг үнэлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
[68] Уг дүнг ХБНГУ-ын Баварын холбооны улсын Мюнхен дэх Бага насны хүүхдийн судалгааны институтийн Др.Нагел баталгаажуулсан байна.

их, дээд сургуульд хүүхдийн ажиглалт, ахицын үнэлгээний талаар хичээл огт заадаггүй байжээ.

2.78. Сургалтын сайжруулсан болон цөм хөтөлбөрийн дагуу СӨБ олгох үйл ажиллагаанд багш нарт сургалтын хэрэглэгдэхүүн дутмаг байгаа нь сургалтын чанарт нөлөөлөхөөр байна. Аудитын явцад багш ажилтнуудаас авсан санал асуулгад сургалтын хэрэглэгдэхүүн хангалтгүй үед 76.0 хувь нь хувиасаа төлж авдаг, 16.0 хувь нь эцэг эхээс гаргуулдаг гэсэн бол 8.0 хувь нь тухайн сэдвийг заадаггүй гэж хариулсан байна.

2.79. Цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрмийн 2.8-д *"Цэцэрлэг нь хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургах тохиолдолд хүүхдийн хөгжлийн бэрхшээлд тохирсон ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ"* гэж заасан боловч хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харьцах, хөгжүүлэх талаар салбарын яам сургалтын тусгайлсан жишиг хөтөлбөрийг боловсруулж, батлаагүй, улсын хэмжээнд хэрэгжилт хангалтгүй байна.

2.80. Цэцэрлэгийн анги танхимын хүрэлцээ муу, ачаалал их зэргээс шалтгаалан 2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар улсын хэмжээнд цэцэрлэгт хамрагдаж буй нийт хүүхдийн 2 орчим хувь нь холимог бүлэгт хичээллэж байна.

2.81. Сургалтын цөм хөтөлбөрт Цэцэрлэгийн удирдлага багш нар СӨБ-ын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хүүхдийн нас, сэтгэхүй, хөгжлийн онцлогт нийцүүлэх зарчим баримтлахаар заасан боловч цэцэрлэгүүд холимог бүлэгт хичээллэж буй хүүхдэд нас, онцлогт нь бүрэн тохирсон сургалтыг явуулахгүй байна.

2.82. Хувилбарт сургалтын үлгэрчилсэн хөтөлбөргүй, "СӨБ эзэмшүүлэх хувилбарт сургалт зохион байгуулах журам"-д хувилбарт сургалтад ашиглах сургалтын хөтөлбөрт орон нутгийн Боловсролын газар үнэлгээ хийж, сургалтад ашиглаж болох эсэх талаар зөвлөмж өгнө гэж зааснаас хувилбарт сургалт харилцан адилгүй хөтөлбөрөөр хэрэгждэг байна.

2.83. "СӨБ эзэмшүүлэх хувилбарт сургалтыг зохион байгуулах журам"-ын 4.4-д "*Жил бүр аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн эзэмшсэн мэдлэг, чадвар, дадлыг үнэлнэ*" гэж заасан боловч хэрхэн үнэлэх аргачлалгүйгээс хүүхдийн чадамж, ахицыг үнэлж дүгнэдэггүй байна.

2.84. БСШУС, НХХС, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 дугаар тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам"-д "*цэцэрлэгийн багш 7 хоногт ажлын 40 цагтай тэнцэх стандартыг хэрэгжүүлж, бусад ажлыг гүйцэтгэнэ*" гэж заасан хэдий ч багшийн ажлын ачаалал их, ажлын цаг ашиглалт зохистой хуваарилагдаж чадахгүй байна.

- *Аудитын хүрээнд нийт 574 цэцэрлэгийн 7484 багш, ажилтнуудаас авсан санал асуулгаар багшийн ажлын цагийн 58.6 хувийг хүүхэд бүрийг хөгжүүлэхэд, 30.4 хувийг статистик мэдээ, тайлан гаргахад, 10.9 хувийг бусад ажилд зарцуулдаг, эцэг эхчүүд цагийн хуваарийн дагуу хүүхдээ авдаггүй, сургалтын бэлтгэл хангах зэргээс илүү цагаар ажиллахад хүрдэг гэж хариулжээ.*

*Дүрслэл 20. Багшийн илүү цагийн судалгаа*




*Дүрслэл 21. Багшийн илүү цагийн шалтгаан*




*Эх сурвалж: УАГ-аас авсан багш ажилчдын санал асуулга*

## *Цэцэрлэгийн багш ажилтны нэгдсэн судалгаанд үндэслэн ажлын байрны эрэлт хэрэгцээ тухай бүр тодорхойлдоггүй, хүний нөөцийн нэгдсэн бодлого төлөвлөгөө боловсруулаагүй, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна*

*Дүрслэл 22. Улсын хэмжээний СӨБ байгууллагад ажиллагсдын судалгаа*




*Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик мэдээ*

2.85. СӨБ-ын байгууллагад 2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар нийт 27,214 багш, ажилчин ажиллаж байгаагийн 53.3 хувийг үндсэн болон туслах багш, 46.7 хувийг захиргаа, үйлчилгээний ажилчид эзэлж байна.

2.86. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9[69], Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэмд тухайн бүлгээс хамааруулан нэг бүлэгт ногдох хүүхдийн тоог 15-25 байхаар тусгажээ.

*Дүрслэл 23. Нэг багшид ногдох хүүхдийн тоог улсын хэмжээнд харьцуулсан судалгаа*




*Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик мэдээ*

2.87. Нэг багшид ногдох хүүхдийн тоо өмчийн хэлбэрээс хамааран харилцан адилгүй төрийн өмчийн цэцэрлэгийн хувьд үлгэрчилсэн дүрэмд зааснаас 29 орчим хувиар их байгаа нь багшийн ажлын ачааллыг нэмэгдүүлж, хүүхэд бүрийг ажиглах, хөгжүүлэх, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, өдрийн дэглэмийг мөрдөх, хүүхдийн хувийн хэрэг хөтлөх зэргээр хүүхдийн насан туршийн боловсролын суурь чадварыг бүрэн эзэмшүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

*Хүснэгт 6. Төрийн болон хувийн цэцэрлэгүүдийн 1 бүлэгт ногдох буй хүүхдийн тооны дундаж үзүүлэлт*

| № | Нэг багшид ногдох хүүхдийн тоо | 2015-2016 | 2016-2017 | 2017-2018 | 2018-2019 |
|---|---|---|---|---|---|
| 1 | Улсын цэцэрлэг | 35.5 | 35.9 | 35.6 | 35.5 |
| 2 | Хувийн цэцэрлэг | 22.3 | 23.2 | 23.3 | 24.6 |

*Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик, багш ажилчдын санал асуулга*

[69] СӨБ-ын тухай хууль 8 дугаар зүйлийн 8.9. цэцэрлэгийн нэг бүлэгт багш, туслах багш ажиллана. Бүлэгт хүүхдийн тооноос хамаарч ээлжийн багш ажиллаж болно

2.88. БСШУС-ын 2012 оны А/136 дугаар тушаалаар “Багшийн хөгжил” хөтөлбөр баталж, 2012-2016 оны хугацаанд хэрэгжүүлсэн байна. Уг тушаалаар хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан сайдын зөвлөлд танилцуулж байхыг ХШҮДАГ-т үүрэг болгосон боловч хяналт хийгээгүй байна.

2.89. Мөн Багшийн хөгжлийн дэмжих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д ” *Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг 5 жил тутамд батлах*” гэж заасан боловч уг хөтөлбөрийг шинэчилж батлаагүй байна.

***СӨБ-ын байгууллагад ажлын байранд суурилсан цалин хөлсний тогтолцоог нэвтрүүлснээр багш нар ажлын онцлогт тохирсон цалин урамшуулал авахаар болжээ***

2.90. МУЗГ-ын 2019 оны 24 дүгээр тогтоолоор Сургуулийн өмнөх болон бага дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээг, 25 дугаар тогтоолоор сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг тус тус баталснаар үндсэн багшийн дундаж цалин 2014 оноос 70 хувь, 2018 оноос 31.3 хувиар өссөн байна.

*Хүснэгт 7. Багш, ажилчдын цалингийн өсөлтийн судалгаа /мянган төгрөг/*

| № | Албан тушаал | МУЗГ-ын 2014 оны 332 дугаар тогтоол | МУЗГ-ын 2018 оны 264 дугаар тогтоол | Нэмсэн дүн | Өссөн хувь | МУЗГ-ын 2019 оны 25 дугаар тогтоол | МУЗГ-ын 2019 оны 24 дүгээр тогтоол | Нэмсэн дүн | Өссөн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Эрхлэгч | 550.4 | 641.1 | 90.7 | 16.5% | ТҮБД-5 | 844.5 | 203.4 | 31.7% |
| 2 | Аргазүйч | 458.8 | 594.4 | 135.6 | 29.6% | ТҮБД-3 | 713.5 | 119.1 | 20.0% |
| 3 | Үндсэн багш | 458.8 | 594.4 | 135.6 | 29.6% | ТҮБД-4 | 780.3 | 185.9 | 31.3% |
| 4 | Туслах багш | 398.1 | 461.5 | 63.4 | 15.9% | ТҮБД-1 | 558.4 | 96.9 | 21% |

*Эх сурвалж: БСШУСЯ-ны СХОГ / Цалинг албан тушаал тус бүрийн 3 дугаар шатлалаар жишээ болгон авсан болно/*

2.91. МУЗГ-ын 2019 оны 24 дүгээр тогтоолд цэцэрлэгийн арга зүйчийн цалин үндсэн багшийн цалингаас 66.8 мянга орчим төгрөгөөр бага батлагдсанаас олон жил ажилласан туршлагатай арга зүйч нар багшаар ажиллах, зарим цэцэрлэг арга зүйчгүй болох, ажлын туршлагагүй, шинээр сургууль төгссөн хүн арга зүйчээр томилогдон ажиллах, арга зүйч бүлгийн багшийг хавсран гүйцэтгэх зэрэг тохиолдол гарч байна.

- *Аудитын явцад орон нутгийн цэцэрлэгийн арга зүйч нар “Цэцэрлэгийн арга зүйч нь ажлын байрны тодорхойлолтод удирдах ажилтан гэж заасан боловч багшийн цалингаас тодорхой хэмжээгээр бага авдаг” гэсэн асуудлыг ихээр хөндөж байгаа боловч яамны бодлогын газрын зүгээс “үндсэн багш нь 35-50 хүүхэдтэй ажилладаг, ажлын ачаалал ихтэй, харин арга зүйч нь 10 орчим багштай ажилладаг тул ажлын ачаалал харьцангуй хөнгөн учраас цалин зөрүүтэй байгаа” гэсэн тайлбар өгч байна.*

2.92. Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т “*Багш, суралцагчид үзүүлэх хөнгөлөлт, нөхөх олговор, тэтгэлэг, тэтгэмж, шагнал урамшил нь өмчийн хэлбэр харгалзахгүй адил тэгш байна*” гэж заасан боловч нарийвчилсан эрх зүйн зохицуулалтгүйгээс хувийн цэцэрлэгийн багш, ажилтнуудад нэмэгдэл, урамшуулал, тэтгэмж, дэмжлэг олгохгүй байна.

2.93. БСШУС-ын 2013 оны А/293 дугаар тушаалаар баталсан “*Цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлж, дүгнэх журам*”-ын 5.6-д “*Багшид ур чадварын нэмэгдэл, улирлын мөнгөн урамшил олгох шийдвэрийг* ***сургуулийн захирал*** *гаргана*” гэж заасан нь нэр томьёоны хувьд нийцэхгүй байгаа тул шинэчлэх шаардлагатай байна.

2.94. СӨБ-ын байгууллагын ажилтан Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3-д орон сууц барих буюу худалдан авахад зориулж хөнгөлөлттэй зээл, тусламж авах нийгмийн баталгаагаар хангагдах эрхтэй ч уг заалт хэрэгждэггүй байна. Тухайлбал,

- *Орхон аймгийн БСУГ нь 2016 онд “Неман” ХХК-тай багш нарыг хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцтай болгох гэрээ байгуулж, тус зээлд 2 багш хамрагдсан;*
- *Өмнөговь аймагт 2016-2018 онд нийт 155.4 сая төгрөгийн орон сууцны болон сургалтын төлбөрийн дэмжлэгийг 34 багш ажилтанд олгосон байна.*

2.95. Боловсролын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7[70], Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3[71]-т заасны дагуу МУЗГ-ын 2014 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "*Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам*"-ын дагуу төрөөс дараах сургалтын тэтгэлгүүдийг олгосон байна.

*Хүснэгт 8 МУБИС-ын СӨБ-ын мэргэжлээр элсэн төгсөгчдөд төрөөс олгосон тэтгэлгийн судалгаа (сая төгрөг)*

| № | Тэтгэлгийн төрөл | 2013-2014 | 2014-2015 | 2015-2016 | 2016-2017 | 2017-2018 | 2018-2019 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | 70% тэтгэлэгт хамрагдалт | 35.6 | 86.06 | 105.54 | 148.9 | 109.75 | 87.3 |
| 2. | 100% тэтгэлэгт хамрагдалт | 3.35 | 2.9 | 5.4 | 7.4 | 3.9 | 0 |
| 3. | Дадлагын тэтгэлэгт хамрагдалт | 0 | 0 | 28.8 | 0 | 20.0 | 0 |
| **Нийт дүн** | | **38.95** | **88.96** | **139.74** | **156.3** | **133.65** | **87.3** |

*Эх сурвалж: БСШУСЯ-ны СӨББГ*

2.96. Мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээгүйгээс зарим цэцэрлэг тэтгэврийн насны багш ажиллуулах, бүлгийн багшгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал,

- *2018-2019 оны хичээлийн жилд ажиллаж буй нийт 7843 үндсэн багшийн 3.4 хувь, нийт 6673 туслах багшийн 1.2 хувийг тэтгэврийн насны буюу 55-с дээш насны ажилтан эзэлж байна;*
- *Говьсүмбэр аймгийн "Тунгаамал цэцэрлэг", Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн "Пороrогийн найзууд" зэрэг цэцэрлэгүүд бүлгийн багшгүй;*
- *Говьсүмбэр аймгийн Буян цэцэрлэг 4 бүлэгтэй болович 3 багштай байна.*

2.97. ШУБС, Сангийн сайдын 1995 оны 227/199 тоот тушаалаар ""Хүүхдийн цэцэрлэгийн захиргаа, үйлчилгээний ажилтны орон тооны үлгэрчилсэн норматив" баталсан бөгөөд БСШУСС, Сангийн сайдын 2018 оны А/817/287 тоот хамтарсан тушаалаар хүчингүй болгосон байна. Иймд одоогийн байдлаар СӨБ-ын байгууллагад хүчин чадал, бүлгийн тооноос хамаарч тухайн байгууллагад ажиллах боловсон хүчний орон тоог тогтоосон эрх зүйн актгүй байна.

2.98. СӨБ-ын байгууллагын барилга байгууламжид зориулалтын заал, танхим дутмагаас шалтгаалан дуу хөгжим, биеийн тамирын багш нарын орон тоо бага байгаагаас сургалтын хөтөлбөрийн дагуу хүүхдэд эзэмшүүлэх хөдөлгөөн, эрүүл мэндийн болон хөгжим, дүрслэх урлагийн чадамжийг бүрэн олгох нөхцөл бүрдэхгүй байна.

*Дүрслэл 24. Улсын хэмжээнд 2015-2019 оны хичээлийн жилд ажиллаж буй мэргэжлийн багш нарын судалгаа*




*Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик мэдээ*

2.99. Баян-Өлгий, Дорноговь, Завхан, Орхон, Говьсүмбэр аймгийн цэцэрлэгүүд, Хөвсгөл, Орхон аймаг 1 цэцэрлэгээс бусад цэцэрлэгт биеийн тамирын багшгүй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд 2017-2018 оны хичээлийн жилд хийсэн хүүхдийн ахицын үнэлгээгээр дээрх аймгуудын хүүхдийн хөдөлгөөн, эрүүл мэндийн чадамж бусад чадамжаасаа хамгийн бага үзүүлэлттэй гарсан нь биеийн тамирын багшийн хэрэгцээ шаардлага бодитой байгааг харуулж байна.

2.100. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т цэцэрлэгийн эрхлэгч "*багш, ажилтныг сонгон авч ажиллуулах, өөрчлөх, чөлөөлөх;*" эрхтэй

[70] Боловсролын тухай хууль 39.7.Орон нутгийг боловсон хүчнээр хангах, чухал хэрэгцээтэй мэргэжилтэн бэлтгэх, суралцагчийн авьяасыг дэмжих, орлого багатай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боловсрол эзэмшихэд зориулж сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж олгох бөгөөд тэдгээрийг олгох журмыг Засгийн газар батална.
[71] Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль 8.3 Багш мэргэжлээр дээд боловсрол олгох их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт 6 сарын хугацаатай дадлагажигч багшаар ажиллах агуулгыг багтаана. Дадлагажигч хөдөө орон нутагт ажиллавал тэтгэлэг олгож болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална

гэж заасснаас аймаг, нийслэлийн хэмжээнд үндсэн багшийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, нэгдсэн журмаар нээлттэй ажлын байрны талаар нийтэд мэдээлэх, түвшин тогтоох, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажил хийгддэггүй байна.

2.101. БСШУСЯ-ны зүгээс цэцэрлэгийн багш ажилтны нэгдсэн судалгаанд үндэслэн ажлын байрны эрэлт хэрэгцээг тухай бүр тодорхойлдоггүй, хүний нөөцийн нэгдсэн бодлого төлөвлөгөө боловсруулаагүй, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

***Зарим багш, эрхлэгч зохих шаардлага хангаагүй, үндсэн болон туслах багш бэлтгэж буй байгууллагуудын сургалтын чанар харилцан адилгүй байна***

2.102. НМХГ-аас 2019 онд хийсэн шалгалтад хамрагдсан 109 цэцэрлэгийн 1 цэцэрлэг мэргэжлийн бус эрхлэгчтэй, 58 цэцэрлэгийн 73 багш мэргэжлийн бус, 26 цэцэрлэгийн зарим туслах багш зохих сургалтад хамрагдаагүй, 50 цэцэрлэгт шаардлагатай хүний нөөц бүрэн бүрдээгүй зэрэг зөрчлийг илрүүлж, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлжээ.

2.103. Аудитад хамрагдсан зарим цэцэрлэгийн эрхлэгч зохих шаардлага хангаагүй, зарим цэцэрлэгт мэргэжлийн бус хүнийг эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон бөгөөд тэдгээр нь ажиллах явцдаа хөрвөх сургалтаар СӨБ-ын мэргэжил эзэмшсэн явдал гарсан нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1[72] дэх заалттай нийцэхгүй байна. Тухайлбал,

***Эрхлэгчийн үүрэг гүйцэтгэгчээр ажиллах хугацаандаа хөрвөх сургалтаар мэргэжил эзэмшсэн:***

- *Баян-Өлгий аймаг Алтай, Сагсай сумдын цэцэрлэг, Баянхонгор аймгийн 14, 15 дугаар цэцэрлэг, Бууцагаан сумын Баянбүрдний багийн цэцэрлэг*

***Зохих шаардлага хангаагүй:***

- *Баян-Өлгий аймгийн "Бүлдиршин" цэцэрлэг, Говь-Алтай аймгийн Шарга сумын цэцэрлэг, Дорноговь аймгийн 10 дугаар цэцэрлэг, "Болор-Эрдэнэ" цэцэрлэг, Чингэлтэй дүүргийн 220 дугаар цэцэрлэг, Сүхбаатар дүүргийн "Пороро найзууд", Баянгол дүүргийн "Шинэ жаргалант".*

> *Сайн жишиг*
>
> *Баянгол дүүргийн 95 дугаар цэцэрлэг 18 бүлэгтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үндсэн 18 багш мэргэжлийн зохих шаардлага бүрэн хангасан, 4 багш нь магистрын боловсролтой, 11 багш нь заах арга зэрэгтэй, бүх туслах багш зохих сургалтад бүрэн хамрагдсан, 1 нь СӨБ-ын багшийн бакалаврын боловсролтой байна.*

2.104. БШУС-ын 2007 оны 351 дүгээр тушаалаар баталсан "Ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт"-д эрхлэгч бакалавр, магистрын зэрэгтэй байх, аргазүйч магистраас доошгүй боловсролын зэрэгтэй байхаар заасан боловч 2018-2019 оны хичээлийн жилд нийт эрхлэгчийн 6.1 хувь, арга зүйчийн 63.6 хувь нь батлагдсан шалгуурт нийцээгүй байна.

2.105. БСШУСС-ын 2019 оны А/430 дугаар тушаалаар баталсан "Албан тушаалын үлгэрчилсэн тодорхойлолт"-д эрхлэгч, арга зүйч бакалаврын зэрэгтэй байх, цэцэрлэгийн эрхлэгч нь багш, арга зүйчээр 8 жилээс доошгүй хугацаанд ажилласан туршлагатай байхаар шинэчлэн баталсан боловч 2019-2020 оны хичээлийн жилд нийт эрхлэгчийн 21.2 хувь нь улсад 5 хүртэл жил ажилласан байна.

2.106. Боловсролын салбарын статистик мэдээнээс харахад 2019-2020 оны хичээлийн жилд боловсролын түвшин харилцан адилгүй, нийт эрхлэгчийн 6.5 хувь , арга зүйчийн 3.8 хувь, үндсэн багшийн 8.9 хувь нь бакалаврын /дипломын/ боловсролгүй байгаа нь өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн холбогдох шаардлагыг хангаагүй байна. Мөн аудитын явцад түүвэрт хамрагдсан цэцэрлэгүүдэд хуульд заасан мэргэжлийн шаардлага хангаагүй 11 арга зүйч, 221 үндсэн багш, 31 туслах багш ажиллаж байна.

[72] СӨБ-ын тухай хууль 10.1. Төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгийг сургуулийн өмнөх боловсролын багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллеж төгссөн, ажлын туршлагатай эрхлэгч удирдах бөгөөд түүнийг үүсгэн байгуулагч томилно

*Дүрслэл 25. СӨБ-ын байгууллагын эрхлэгч, аргазүйч, үндсэн туслах багшийн боловсролын зэргийн судалгаа /2018-2019 оны хичээлийн жил/*




*Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик мэдээ*

2.107. БСШУС-ын 2014 оны А/52 дугаар тушаалаар баталсан "СӨБ-ын байгууллагын багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах, аргазүйчид мэргэжлийн зэрэг олгох хасахад баримтлах шалгуур үзүүлэлт"-ийг мөрдөж байсан бөгөөд БСШУСС-ын 2019 оны А/117 тоот тушаалаар "Хүүхдийн цэцэрлэгийн багш, арга зүйч, эрхлэгчид мэргэжлийн зэрэг олгох, хасах журам"-ыг баталснаар Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д заасан багшлах эрхийг олгох нь тодорхой зохицуулалтгүй болсон байна.

***СӨБ-ын байгууллагын багш бэлтгэж буй их дээд сургуулийн чанарыг сайжруулах шаардлагатай байна***

2.108. Аудитын явцад авсан санал асуулгад оролцогчдын 37 хувь нь цэцэрлэгийн үндсэн багш бэлтгэж буй байдал үр дүнтэй, хэрэгцээ шаардлага хангасан гэж үзсэн бол 63 хувь нь сайжруулах шаардлагатай, үр дүн муутай гэж үзсэн байна.

2.109. Улсын хэмжээнд 2016-2019 оны хичээлийн жилд 28 орчим их дээд сургуульд СӨБ-ын багш мэргэжил олгож байгаа ч БСШУСЯ-ны СӨББГ нь уг мэргэжлээр төгсөгчдийн нэгдсэн судалгаа, мэдээлэлгүй байна. */СӨБ-ын багш бэлтгэж буй их, дээд сургуулиудын судалгааг Хавсралт 7-с үзнэ үү/*

2.110. Аудитын явцад хийсэн уулзалт ярилцлагаар дийлэнх цэцэрлэгийн удирдлага "*хувийн их, дээд сургууль төгсөгчдөөс илүүтэйгээр МУБИС-ын СӨБС-ын төгсөгчийг авч ажиллуулах хүсэлтэй*" байдаг гэж хариулсан нь цэцэрлэгийн багш бэлтгэж буй их дээд сургуулиудын сургалтын чанар харилцан адилгүйг харуулж байна.

2.111. СӨБ-ын багш мэргэжлээр сургалт явуулдаг их дээд сургуулиудын хичээлийг судалж үзэхэд БСШУС-ын 2014 оны А/285 дугаар тушаалаар баталсан "*Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлийн жагсаалт*"-аар батлагдсан дараах хичээлүүд тусгагдаагүй байна. */Дэлгэрэнгүйг Хавсралт 8-с үзнэ үү/* Үүнд:

- *Гурван эрдэнэ дээд сургууль - Монголын түүх, соёл, ёс заншил;*
- *Газарчин дээд сургууль - Монгол хэл, бичиг, найруулга зүй;*
- *Ховд Их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургууль, Газарчин дээд сургууль, Нийгэм сэтгэл судлалын дээд сургууль - Сэтгэлгээний түүх, соёл.*

***СӨБ-ын байгууллагад ажиллаж буй туслах багшийн мэргэжлийн индексийг хууль тогтоомжид нийцүүлэх, туслах багш бэлтгэж буй сургалтын байгууллагын чанарыг сайжруулах шаардлагатай байна***

2.112. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 2016 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 4.1.13-т "*Туслах багш гэж ... ажилтныг*" гэж заасан боловч

БСШУСС-ын 2016 оны А/150 дугаар тушаалаар баталсан "*Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагаар бэлтгэх мэргэжлийн чиглэл, индекс*"-т "*СӨБ-ын байгууллагын туслах ажилтан*" гэж заасан нь нэр томьёоны хувьд зөрүүтэй байна.

2.113. Цэцэрлэгийн туслах багшийг дээрх мэргэжлийн чиглэл, индексийн дагуу ХНХЯ-ны харьяа Мэргэжлийн сургалтын байгууллагад бэлтгэдэг бөгөөд 2017-2019 онд нийт 3598 туслах багш суралцаж төгссөн байна.

*Хүснэгт 9. СӨБ-ын туслах ажилтан индексээр төгсгөж буй сургалтын төв, төгсөгчийн судалгаа*

| *Он* | *Сургалтын төв* | *Төгсөгчийн тоо* |
|---|---|---|
| *2017 он* | *30* | *772* |
| *2018 он* | *36* | *1376* |
| *2019 он* | *33* | *1450* |
| ***Нийт дүн*** | ***99*** | ***3598*** |

*Эх сурвалж: ХНХЯ-ны МБСБХЗГ*

2.114. Аудитын хамарсан хугацаанд цэцэрлэгийн туслах ажилтан бэлтгэж буй сургалтын байгууллагад тухайн мэргэжилтэй холбоотой чанарын үнэлгээ хийгээгүй нь ХНХС, БСШУСС-ын 2018 оны А/257/А/582 дугаар хамтарсан тушаалаар баталсан "*Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам*"-ын 9.4[73]-д заасантай нийцэхгүй байна.

2.115. БСШУСС-ын 2019 оны А/705 дугаар тушаалаар Цэцэрлэгийн туслах багшийг бэлтгэх түр сургалт, боловсролын сургалтын байгууллагын албан бус нэршлээр үйл ажиллагаа явуулж, мэргэжлийн диплом олгож буй байгууллагыг шалган, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал, дүгнэлт боловсруулах БСШУСЯ, ХНХЯ, УБЕГ, МХЕГ, ЦЕГ-ын хамтарсан ажлын хэсгийг байгуулж санал дүгнэлтийг 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор танилцуулахыг үүрэг болгосон боловч ажлын хэсгийн дүгнэлт одоогоор эцэслэн гараагүй байлаа.

2.116. БСШУСЯ нь холбогдох нэгжүүдийг удирдлага зохион байгуулалт, арга зүйн чиглэлээр бүрэн хангаагүйгээс СӨБ-ын багш ажилтнууд ЭМС-ын А/145 дугаар тушаалаар баталсан "*Худалдаа үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам*"-д заасан хугацаанд[74] эрүүл мэндийн үзлэгт тогтмол бүрэн хамрагдаагүй байна.

2.117. Аудитын явцад дараах цэцэрлэгийн багш ажилтнууд эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт бүрэн хамрагдаагүй байсан нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8.8[75], 13 дугаар зүйлийн 13.1.5[76] дахь заалттай нийцэхгүй байна. Тухайлбал,

- *Архангай аймаг - Хангай, Хайрхан, Өлзийт, Хотонт сумын цэцэрлэг /бүрэн хамрагдаагүй/;*
- *Дархан-Уул аймаг - 5 дугаар цэцэрлэг, 9 дүгээр цэцэрлэг, Шарын гол сумын 14 дүгээр цэцэрлэг /бүрэн хамрагдаагүй/;*
- *Баянхонгор аймаг - Нийт 28 багш ажилтан хамрагдаагүй, Сэлэнгэ аймаг - Нийт 4 багш ажилтан хамрагдаагүй;*
- *Нийслэлийн хэмжээнд нийт 41 багш ажилтан хамрагдаагүй.*

2.118. Мөн аудитын явцад авсан санал асуулгын дүнгээс үзэхэд багш ажилтнууд эрүүл мэндийн үзлэгийн төлбөрийг орон нутгийн төсвөөс болон хувиасаа төлж байгаа нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь[77], 9 дүгээр зүйлийн 9.4 дэх[78] заалттай нийцэхгүй байна. Тухайлбал,

- *Орхон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгасан Багш дэд хөтөлбөрийн дагуу 2017 онд 410 багш ажилтныг, 2018 онд 106 багш ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, нийт 33.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан байна.*

---

[73] Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам 9.4 Мэргэжлийн сургалтын байгууллагыг 2 жилд 1 удаа мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн салбарын мэргэжлийн холбоодтой хамтран хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гаргана

[74] Худалдаа үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам 2.1.3. СӨБ-ын байгууллагын багш болон хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч нь хичээлийн жил эхлэхээс өмнө 30 хоногийн дотор эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдана

[75] СӨБ-ын тухай хууль 12.8.8. Багш эрүүл мэндийн шинжилгээ, үзлэгт тогтмол хамрагдах

[76] СӨБ-ын тухай хууль 13.1.5. Туслах багш эрүүл мэндийн шинжилгээ, үзлэгт хамрагдах

[77] Эрүүл мэндийн даатгалын тухай хууль 7.1.2. Даатгуулагч энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг энэ хуулийн дагуу тогтоосон хэмжээгээр эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх;

[78] Эрүүл мэндийн даатгалын тухай хууль 9.4. Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн тогтоосон товлолт хугацаанд хамруулан, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь санхүүжүүлэх бөгөөд даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах, магадлан итгэмжлэгдсэн спортын клубт идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээнд урамшуулал олгох журмыг нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Үндэсний зөвлөл батална.

*Дүрслэл 26. Багш ажилчдын эрүүл мэндийн үзлэгт хамрагдалтын байдал*




*Эх сурвалж: Эх сурвалж: УАГ-аас авсан багш ажилчдын санал асуулга*

*Дүрслэл 27. Багш ажилчдын эрүүл мэндийн үзлэгийн төлбөр төлдөг хэлбэр*




*Эх сурвалж: Эх сурвалж: УАГ-аас авсан багш ажилчдын санал асуулга*

2.119. Цаашид БСШУСЯ, ЭМЯ хамтран Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хүрээнд эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр цэцэрлэгийн багш, ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд холбогдох журамд заасан хугацаанд хамруулах ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах шаардлагатай байна.

2.120. Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2[79]-д заасны дагуу Багшийн мэргэжил дээшлүүлэх институт багшийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх дэмжих үйл ажиллагааг хариуцан зохион байгуулж 2016-2019 оны хичээлийн жилд нийт 3798 багш, ажилтныг үндсэн сургалтад хамруулжээ.

2.121. БСШУС-ын 2013 оны А/287 дугаар тушаалаар баталсан "*Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам*"-ын 4.1[80]-д эхний болон 5, 10 дахь жилдээ ажиллаж буй багш ажилтанд зориулсан үндсэн сургалтыг зохион байгуулахаар заасан нь Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.8[81] дахь заалттай нийцээгүйгээс 15 буюу түүнээс дээш жил ажиллаж буй үндсэн багш мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдахгүй байна.

2.122. Цэцэрлэгүүдэд Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1[82], 7.3[83] -д заасны дагуу багшийн хөгжлийн төвийг байгуулах хүсэл эрмэлзэл байдаг боловч санхүү хөрөнгийн нөөц хангалтгүй, өрөө, тасалгаа, тавилга, тоног төхөөрөмж дутагдалтай байдаг зэргээс уг заалт хэрэгжихгүй байна.

## *Төсвийн төлөвлөлт бодитой бус, тусгай зориулалтын шилжүүлэг, зардлын зарцуулалтад тавих хяналт сул, төсөв хэмнэх боломжийг алдаж байна*

2.123. Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативаар санхүүжих төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалттай холбогдсон харилцааг Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 40.3 дахь заалт, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь заалтын хүрээнд Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоолоор зохицуулж байна.

[79] Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль 5.2.Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг үндэсний түвшинд багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, байгууллагын түвшинд захирал, сургалтын менежер, эрхлэгч, арга зүйч, сонирхлын бүлгийн түвшинд хамтын удирдлагын нэгдэл, багш өөрөө хэрэгжүүлнэ.

[80] Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам 4.1. Эхний болон тав, арав дахь жилдээ ажиллаж буй багш, ажилтанд зориулсан үндсэн сургалтыг багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах чиг үүрэг бүхий сургалт, арга зүйн төв байгууллага, хоёр, гурав, дөрөв дэх жилдээ ажиллаж буй багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг орон нутгийн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

[81] Боловсролын тухай хууль 40.8. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн мэргэжлийг өмчийн хэлбэр үл харгалзан улсын төсвийн хөрөнгөөр 5 жил тутамд дээшлүүлнэ

[82] Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль 7.1. Бүх шатны боловсролын сургалтын байгууллага нь багшийн хөгжлийн төвтэй байна

[83] Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль 7.3. Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын нийт хувьсах зардлын хоёр хувь хүртэл хэмжээний зардлыг зарцуулна

*Хүснэгт 10. СӨБ эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээ*
*(мян.төгрөгөөр)*

| № | Байршил | Цалин | Ажил олгогчийн төлөх шимтгэл | Бусад хувьсах зардал | Нийт хувьсах зардал |
|---|---|---|---|---|---|
| 1 | Аймгийн төвөөс бусад сум | 874.1 | 96.2 | 27.9 | 998.2 |
| 2 | Аймгийн төв | 709.2 | 78.0 | 25.1 | 812.3 |
| 3 | Нийслэли | 707.3 | 77.8 | 22.8 | 807.8 |

2.124. БСШУСЯ нь аймаг, нийслэлээс ирүүлсэн СӨБ-ын тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн төслийг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлж, хянуулдаг бөгөөд 2016-2018 оны хувьд төсвийн саналыг батлагдсан төсөвтэй харьцуулахад дараах байдалтай байна.

*Дүрслэл 28. Төсвийн санал 2016-2018 он (сая төгрөгөөр)*




*Эх сурвалж: БСШУСЯ*

2.125. БСШУСЯ аймаг, нийслэлээс ирүүлсэн төсвийн төсөлд тусгасан дүнг нэгтгэхдээ 20-26.1 хувиар бууруулж, Сангийн яам салбарын яамны ирүүлсэн төслийг 0.9-4.1 хувиар нэмэгдүүлж УИХ-д өргөн барьж, батлуулжээ.

2.126. Аймаг, нийслэлийн 2016-2018 оны СӨБ-ын төсвийн саналаас үзэхэд зарим аймгийн төсвийн санал батлагдсан төсвөөс 1.4-2.1 дахин өндөр байгаа нь төлөвлөлт үндэслэл муутай байгааг харуулж байна. Тухайлбал,

- *Баян-өлгий аймаг 2017 онд 19.1 тэрбум төгрөгийн төсвийн санал хүргүүлсэн болович 9.06 тэрбум төгрөг батлагдсан;*
- *Архангай аймаг 2018 онд 13.0 тэрбум төгрөгийн төсвийн санал хүргүүлсэн болович 8.74 тэрбум төгрөг батлагдсан.*

*Хүснэгт 11. 2016-2018 оны Орон нутгийн Боловсролын байгууллагын төсвийн санал /21 аймаг, нийслэл/ (сая төгрөгөөр)*

| | | 2016 | | | 2017 | | | 2018 | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Байгууллагын санал | Яамны санал | Батлагдсан төсөв | Байгууллагын санал | Яамны санал | Батлагдсан төсөв | Байгууллагын санал | Яамны санал | Батлагдсан төсөв |
| 1 | Архангай | 9.7 | 7.7 | 7.91 | 9.39 | 8.26 | 8.12 | 13.03 | 8.57 | 8.74 |
| 2 | Баян-Өлгий | 19.1 | 9.4 | 9.06 | 10.04 | 9.42 | 9.40 | 10.85 | 9.63 | 9.80 |
| 3 | Баянхонгор | 9.4 | 8.2 | 8.26 | 10.23 | 8.80 | 8.86 | 11.64 | 9.33 | 9.49 |
| 4 | Булган | 6.4 | 6.0 | 6.05 | 6.49 | 6.11 | 6.19 | 6.88 | 6.66 | 6.81 |
| 5 | Говь-Алтай | 7.3 | 6.0 | 6.12 | 7.57 | 5.92 | 6.34 | 7.50 | 6.55 | 6.49 |
| 6 | Дорноговь | 9.7 | 6.6 | 6.81 | 9.97 | 7.01 | 7.20 | 10.31 | 7.40 | 7.60 |
| 7 | Дорнод | 9.5 | 8.0 | 8.44 | 10.77 | 8.50 | 8.45 | 9.55 | 8.72 | 8.88 |
| 8 | Дундговь | 5.4 | 4.8 | 4.65 | 5.30 | 4.84 | 5.01 | 5.36 | 5.06 | 5.18 |
| 9 | Завхан | 14.0 | 7.7 | 7.74 | 10.80 | 8.00 | 8.07 | 10.76 | 8.42 | 8.61 |
| 10 | Өвөрхангай | 9.7 | 8.4 | 8.65 | 9.47 | 8.89 | 8.99 | 10.17 | 9.35 | 9.54 |
| 11 | Өмнөговь | 10.0 | 6.9 | 7.06 | 9.53 | 7.02 | 7.07 | 8.23 | 7.33 | 7.51 |
| 12 | Сүхбаатар | 7.7 | 6.5 | 7.07 | 9.37 | 7.33 | 7.44 | 9.76 | 7.71 | 7.87 |
| 13 | Сэлэнгэ | 12.9 | 10.6 | 11.18 | 14.12 | 11.87 | 11.86 | 15.58 | 11.82 | 12.08 |
| 14 | Төв | 10.0 | 8.7 | 8.77 | 10.71 | 9.21 | 9.20 | 10.15 | 9.19 | 9.42 |
| 15 | Увс | 8.4 | 6.8 | 6.92 | 8.78 | 7.01 | 7.13 | 10.71 | 7.39 | 7.54 |
| 16 | Ховд | 9.3 | 7.6 | 7.70 | 9.13 | 8.09 | 8.22 | 10.11 | 8.54 | 8.74 |
| 17 | Хөвсгөл | 15.2 | 11.3 | 11.19 | 15.31 | 11.43 | 11.75 | 15.31 | 11.55 | 12.34 |
| 18 | Хэнтий | 8.9 | 8.2 | 8.54 | 8.83 | 8.16 | 8.72 | 9.63 | 8.68 | 8.87 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | Дархан-уул | 11.2 | 9.6 | 9.58 | 12.20 | 9.86 | 9.88 | 12.89 | 10.17 | 10.30 |
| 20 | Орхон | 14.4 | 11.1 | 11.04 | 15.52 | 11.56 | 11.57 | 14.28 | 12.08 | 12.24 |
| 21 | Говь сүмбэр | 2.4 | 2.2 | 1.80 | 2.61 | 1.86 | 1.85 | 2.71 | 2.02 | 1.99 |
| 22 | Улаанбаатар | 142.4 | 103.6 | 103.75 | 149.28 | 107.40 | 113.00 | 205.54 | 122.34 | 131.20 |

*Эх сурвалж: БСШУСЯ-ны төсвийн санал*

2.127. Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тогтоохдоо цэцэрлэгийн хүчин чадал, багтаамжийг харгалзах итгэлцүүргүйгээс олон хүүхэдтэй цэцэрлэгт төсөв бодит гүйцэтгэлээс илүү төлөвлөгдөх, цөөн хүүхэдтэй цэцэрлэгт төсөв хүрэлцэхгүй байх, бусад зардлаас зарцуулах, өр үүсэх эрсдэлийг бий болгож байна.

2.128. МУЗГ-ын 2016 оны 242 дугаар тогтоолоор СӨБ эзэмшүүлэхэд 1 суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг батлахдаа бусад хувьсах зардлыг нийслэлд 22.800, аймагт 25.100, суманд 27.900 төгрөгөөр тус тус баталсан /*бичиг хэрэг, ном хэвлэл, дотоод албан томилолт зэрэг 10 нэр төрлийн зардал*/ боловч уг зардлыг хэрхэн хуваарилах талаар зохицуулалт, аргачлал байхгүй байна. Тухайлбал

- *Дорноговь аймгийн Сайншанд 9 дүгээр цэцэрлэг, Сайхандулаан сумын цэцэрлэгт нормативаар тооцсон бараа үйлчилгээний бусад хувьсах зардал нэг дахин дутуу батлагдсан;*
- *Дорнод аймгийн хэмжээнд “бусад хувьсах зардал”-аас сургалтын үзүүлэн болон тоглоом, бусад хэрэглэгдэхүүнийг худалдан авч болох боломжит зардлууд нь хүрэлцээгүй, зардлын төлөвлөлт нь нарийвчилсан тооцоо судалгаанд үндэслэгдээгүй;*
- *Орхон аймгийн хэмжээнд ном, гарын авлага, сургалтын үзүүлэн болон тоглоом, бусад хэрэглэгдэхүүний төсвийг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж ирсэн;*
- *Хөвсгөл аймгийн хэмжээнд БСШУСЯ-аас ирүүлсэн төсвийн төсөл бэлтгэх аргачлалд тоглоом, бусад хэрэглэгдэхүүний тооцоолол хийх маягт байхгүйгээс нягтлан бодогч уг тооцооллын санал ирүүлдэггүй.*

2.129. НБГ нийт санхүүжих хүүхдийн тоог тооцохдоо МУЗГ-ын 2016 оны 242 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 3.4-т заасан аргачлалын дагуу[84] тооцож иржээ. Тухайлбал,

*Хүснэгт 12.Нийслэлийн хувийн цэцэрлэгүүдийн санхүүжих хүүхдийн тоо /2018 он/*

| № | Дүүрэг | Байгууллага | Хүчин чадал | 2016-2017 оны хичээлийн жилийн гүйцэтгэл /хүүхдийн тоо/ | 2017-2018 оны хичээлийн жилийн гүйцэтгэл /хүүхдийн тоо/ | Санхүүжих хүүхэд |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Баянгол | 112 | 13.666 | 17.256 | 18.307 | 19.333 |
| 2 | Баянзүрх | 201 | 17.422 | 21.620 | 22.816 | 25.519 |
| 3 | Сүхбаатар | 69 | 8.806 | 9.803 | 10.327 | 10.284 |
| 4 | Сонгинохайрхан | 117 | 14.923 | 18.347 | 20.580 | 23.613 |
| 5 | Чингэлтэй | 60 | 7.959 | 10.580 | 12.974 | 13.156 |
| 6 | Хан-уул | 125 | 13.711 | 15.581 | 17.643 | 20.191 |
| 7 | Налайх | 16 | 1.529 | 2.153 | 2.461 | 2.782 |
| 8 | Багануур | 10 | 1.890 | 2.422 | 2.540 | 2.699 |
| 9 | Багахангай | 2 | 275 | 264 | 374 | 402 |
| | Нийт | 712 | 80.181 | 98.026 | 108.022 | 117.979 |

*Эх сурвалж: Нийслэлийн төрийн аудитын газраас ирүүлсэн тайлан*

2.130. Хувийн цэцэрлэгт төсвөөс хувьсах зардлын санхүүжилтийг тухайн боловсролын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, төсвийн төсөлд өгсөн саналыг үндэслэн олгоно гэж заасны дагуу нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн цэцэрлэгийн 1 хүүхдэд ногдох зардлын хэмжээг тооцож саналаа хүргүүлдэг ч тодорхой хэмжээгээр буурч батлагдаж байна.

2.131. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2[85]-д заасан “*сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд шаардагдах ном, гарын авлага, сургалтын үзүүлэн зохиох, хэвлүүлэх, түгээх ...*”-тэй холбоотой ажлыг зохицуулах журамгүй, хоолны зардал, нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг шинэчлээгүйгээс БСШУСЯ санхүүжих дундаж хүүхдийн тооноос 85 хувиар тооцож байгаа нь төсвийн төлөвлөлт бодит бус байгааг харуулж байна.

[84] Өмнөх хоёр хичээлийн жилийн статистик тоог тухайн хичээлийн жилийн хичээллэсэн сар тус бүрээр үржүүлж, нийлбэрийг өмнөх 2 жилийн нийт хичээллэсэн сарын тоонд хуваан гаргадаг байна.
[85] СӨБ-ын тухай хууль 6.2 СӨБ эзэмшүүлэхэд шаардагдах ном, гарын авлага, сургалтын үзүүлэн зохиох, хэвлүүлэх, түгээх ажлыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу зохион байгуулна

**Салбарын яам, аймаг, НБГ-ын зүгээс тусгай зориулалтын шилжүүлэг, зардлын зарцуулалтад тавих хяналт сул, төсөв хэмнэх боломжийг алдаж байна**

2.132. БСШУСЯ нь 2016-2018 онд Монгол Улсын төсвийн нийт зарлагын 17.3-20.3 хувь буюу 1,236.4-1,455.3 тэрбум төгрөгийг зарцуулсан бөгөөд үүнээс 67.2-76.3 хувийг соёл, нийтийн биеийн тамир, ерөнхий боловсрол, СӨБ-ын тусгай зориулалтын шилжүүлэг эзэлж байна.

*Хүснэгт 13. Нийт урсгал зардалд тусгай зориулалтын шилжүүлгийн эзлэх дүн (сая төгрөг)*

| № | Зардлын дүн | 2016 он | | 2017 он | | 2018 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 7,448.2 | 7,151.6 | 7,420.6 | 7,139.6 | 7,710,8 | 7,181.9 |
| 2 | БСШУСЯ | 1,338.6 | 1,253.3 | 1,322.6 | 1,236.4 | 1,632.4 | 1,455.3 |
| 3 | Тусгай зориулалтын шилжүүлгийн дүн | 886.4 | 876.4 | 945.6 | 943.5 | 988.9 | 978.7 |
| 4 | Үүнээс СӨБ | 268.3 | 265.2 | 284.3 | 283.8 | 311.3 | 307.9 |

*Эх сурвалж: Сангийн яам*

2.133. СӨБ-ын тусгай зориулалтын шилжүүлэгт 265,158.1-307,979.9 сая төгрөг зарцуулсан бөгөөд нэг аймаг дунджаар 2.9 хувь буюу 8,134.8 сая төгрөг, нийслэлд 38.8-41.8 хувь буюу 102,782.6-128,841.2 сая төгрөг зарцуулж нийт 582.8-3,287.5 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ. */Дэлгэрэнгүйг Хавсралт 9-с үзнэ үү/*

*Хүснэгт 14. СӨБ-ын тусгай зориулалтын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төгрөгөөр)*

| № | Аймаг, нийслэл | 2016 он | | | 2017 он | | | 2018 он | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэмнэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэмнэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэмнэлт |
| 1 | Аймгууд | 164,542.8 | 162,402.9 | 2,139.9 | 171,339.2 | 170,956.2 | 383.0 | 180,068.2 | 179,138.9 | 929.3 |
| 2 | Улаанбаатар | 103,753.3 | 102,782.4 | 970.9 | 112,995.9 | 112,796.2 | 199.7 | 131,199.6 | 128,841.3 | 2,358.3 |
| | Нийт | 268,296.1 | 265,185.1 | 3,111.0 | 284,335.1 | 283,752.3 | 582.8 | 311,267.4 | 307,979.9 | 3,287.5 |

*Эх сурвалж: Сангийн яам*

*Дүрслэл 29. Зардлын гүйцэтгэл /тэрбум төгрөг/*




*Эх сурвалж: Сангийн яам*

2.134. БСШУСС нь аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан МУЗГ-ын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний биелэлтийг зөвхөн жилийн эцэст үнэлж, дүгнэсэн нь Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5[86]-д заасантай нийцээгүй байна.

2.135. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит цэцэрлэгийн нийт зардлын 67 орчим хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, НДШ, 18 орчим хувийг цэцэрлэгийн хоол хүнс, 10 орчим хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 5 орчим хувийг бусад зардал эзэлж байна. */Дэлгэрэнгүй үзүүлэлтийг хавсралт 10-с үзнэ үү/*

2.136. БСШУСЯ, Сангийн яам нь Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.4[87], Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3[88] дахь заалтын дагуу төрийн өмчийн

[86] Төсвийн тухай хуулийн 39.5.Энэ хуулийн 39.1, 39.2-т заасан гэрээний биелэлтийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч хагас, бүтэн жилээр дүгнэж, дотоод аудит хийнэ.
[87] Боловсролын тухай хууль 28.1.4.бүх шатны боловсролын стандарт, норм, нормативыг Төсвийн тухай хуульд нийцүүлэн боловсруулах;
[88] Төсвийн тухай хууль 11.1.3.төсвийн зарлагын норм, норматив болон төсвийн байгууллагын бүтцийн болон орон тооны жишиг, хязгаарыг тогтоох;

цэцэрлэгийн захиргааны багшаас бусад удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг нормативыг шинэчлэн батлаагүй, бүлгийн тоонд суурилсан албан бус аргачлалын дагуу тооцоолж байгаагаас багш болон бусад ажилтны орон тооны харьцаа зохистой түвшинд байгаа эсэхийг хянах шалгуур үзүүлэлтгүй, орон нутагт дараах хүндрэлтэй байдлыг үүсгэж байна.

- *Ховд аймгийн цэцэрлэгүүдэд үйлчилгээний бусад ажилтан цагаан хэрэглэл угаагч, ОО-үйлчлэгч, цахилгаанчин, сантехникч зэрэг орон тоо бүрэн ажиллаагүйгээс цэцэрлэгийн туслах багшид ноогдох ачаалал их, туслах багш ариун цэврийн өрөө цэвэрлэж, аяга тавгаа угаадаг боловч хүүхэдтэй харьцдаг, нь эрүүл ахуйн шаардлагад нийцдэггүй, цахилгааны гэмтэл, сантехникийн гэмтлийг засах төсөв хүрэлцдэггүйгээс орчны аюулгүй байдал алдагдах эрсдэлтэй;*
- *Дундговь аймгийн Сайнцагаан сумын 8 цэцэрлэг, Эрдэнэдалай, Өндөршил сумын цэцэрлэгүүд гэрээгээр эмч ажиллуулсан, бусад сумдын цэцэрлэгүүд эмчгүй байгаа нь хүүхдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэх, хүүхдийн өсөлт, эрүүл мэндийн судалгаа хийх боломжийг алдагдуулж байна.*

2.137. МУЗГ-ын 2012 оны 106 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 1650 төгрөг, 24 цагаар ажилладаг цэцэрлэг, сувиллын болон тусгай цэцэрлэгт 2400 төгрөгөөр тус тус тогтоохдоо улсын төсвөөс санхүүжүүлэх хувь, хэмжээг тогтоогоогүй нь Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2[89], Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1[90], 15.5[91] дэх заалттай нийцэхгүй байна.

2.138. Үүнээс шалтгаалан хүүхдийн хоолны зардлын эцэг эх, асран хамгаалагчийн хариуцах хувь хэмжээ тодорхойгүй болж хоолны зардлыг улсын төсвөөс бүрэн хариуцаж байгаа нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4[92]-д заасантай нийцэхгүй төдийгүй төсөв хэмнэх боломжийг алдагдуулж байна.

- *НБГ-аас 2017 онд Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.8[93] заалтын дагуу улсын цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын 40 хувийг эцэг эхчүүдээс /8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2775 төгрөг, 24 цагаар ажилладаг цэцэрлэг, сувиллын болон тусгай цэцэрлэгт 8325 төгрөг байх/ нийт 19,775.4 сая төгрөг гаргуулахаар тооцон санал боловсруулан БСШУСЯ-нд хүргүүлсэн ч хэрэгжээгүй байна.*

2.139. Сангийн яамнаас ирүүлсэн СӨБ-ын тусгай зориулалт шилжүүлгийн 2016-2018 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд улсын төсвөөс цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд 44.7-47.3 тэрбум төгрөг зарцуулсан байна.

*Хүснэгт 15. Хоолны зардлын зарцуулалт 2016-2018 он (тэрбум төгрөг)*

| № | Хоол, хүнсний зардал | 2016 он | | | 2017 он | | | 2018 он | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төлөв-лөгөө | Гүйцэт-гэл | хувь | Төлөв-лөгөө | Гүйцэт-гэл | хувь | Төлөв-лөгөө | Гүйцэт-гэл | хувь |
| 1 | Улаанбаатар | 18,155.1 | 17,945.7 | 98.8 | 19,482.3 | 19,450.9 | 99.8 | 20,168.2 | 19,915.4 | 98.7 |
| 2 | Бусад аймгууд | 27,426.8 | 26,738.8 | 97.5 | 26,777.9 | 26,686.3 | 99.7 | 27,575.9 | 27,342.0 | 99.2 |
| | Улсын дүн | 45,581.9 | 44,684.5 | 98.0 | 46,260.2 | 46,137.3 | 99.7 | 47,744.1 | 47,257.4 | 99.0 |

*Эх сурвалж: Сангийн яам*

2.140. Аудитын явцад хийсэн ажиглалт, уулзалт ярилцлага, журналын бүртгэл, багш ажилтнуудаас авсан санал асуулгын дүнгээс үзэхэд цэцэрлэгийн хүүхдийн ирц дунджаар 80 орчим хувьтай, улирлын давтамжтай хэлбэлздэг бөгөөд БСШУСЯ, аймаг, НБГ нь хүүхдийн ирцийн нэгдсэн бүртгэл, мэдээлэл хөтөлдөггүй байна.

2.141. Гэвч 2016-2018 онд хоол, хүнсний зардал төлөвлөсөн зардлын 97.5-99.2 хувийг зарцуулсан нь төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах замаар зарцуулагдаагүй үлдэгдлийг байгууллага хооронд болон зардал хооронд шилжүүлэн зарцуулах тохиолдол нийтлэг

[89] Боловсролын тухай хууль 40.2.Төрийн өмчит ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрын нийт зардал, тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны зардал, цэцэрлэгийн байршлыг харгалзан хүүхдийн хоолны зардлын тодорхой хувь, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ашгийн болон ашгийн төлөө бус цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан болон албан бус сургалтад хамрагдаж байгаа нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.
[90] СӨБ-ын тухай хууль 15.1.Төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын тодорхой хувь, ном, гарын авлага болон хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн тоглоомоор хангах зардал, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр нэг хүүхдэд ногдох нормативт зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.
[91] СӨБ-ын тухай хууль 15.5.Төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын улсын төсвөөс санхүүжүүлэх хувь, хэмжээг Засгийн газар тогтооно.
[92] СӨБ-ын тухай хуулийн 15.4 Төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын тодорхой хувийг эцэг, эх, асран хамгаалагчаас, Нийгмийн халамжийн тухай хуулийн 20.2-т заасан хүүхдийн хоолны зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ
[93] 14.2.8. хүүхдийнхээ хоолны зардлын тодорхой хувийг хариуцах.

байгааг харуулж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7[94], 45 дугаар зүйлийн 45.2[95], 45.2.1[96], МУЗГ-ын 2012 оны 106 дугаар тогтоолын 4 дэх заалттай[97] нийцэхгүй байна. Тухайлбал,

- *Говь-сүмбэр аймаг - 2016-2018 онд хоолны зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 61.4 сая төгрөгөөс 34.4 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн бөгөөд "БСШУСС-ын 2018 оны 1а/10475, 1а/12858 дугаар албан бичгээр төсөвт зохицуулалт хийж хөтөлбөр хооронд шилжүүлэх, хүүхдийн цэцэрлэгийн хоолны хэмнэлтийг ажилтны бодит орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллах талаар чиглэл хүргүүлсний дагуу 27.0 сая төгрөгийг цалин, бичиг хэрэг, шуудан холбоо, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, мэдээлэл технологийн үйлчилгээ, урсгал засвар, хог хаягдал устгах, ариутгалын зардал зэрэг өр үүссэн зардлуудад шилжүүлэн зарцуулсан,*
- *Булган аймаг - хоолны зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл нийт 268.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан бага, үнэтэй түргэн элэгдэх зүйл, нормын хувцас зөөлөн эдлэл, түлш халаалт, тээвэр шатахуун, урсгал зардал, бараа ажил үйлчилгээний бусад зардал, бусдаар хийж гүйцэтгүүлэх ажлын хөлс, эм, бичиг хэргийн зардалд шилжүүлэн зарцуулсан,*
- *Өвөрхангай - УИХ-ын 2017 оны 67 дугаар тогтоолын дагуу 2017 онд төрийн албан хаагчид 300.0 мянган төгрөгийн урамшуулал олгохоор шийдвэрлэсний дагуу хоолны зардлын зарцуулагдаагүй үлдэгдлээс 195.0 сая төгрөг олгосон. Мөн аймгийн Засаг даргын 2018 оны а/592 дугаар захирамжаар хоолны зардлын зарцуулагдаагүй үлдэгдлээс 80.6 сая төгрөгийг урсгал засварт зарцуулсан,*
- *Дорноговь аймаг: 2016-2018 онд нийт хоол хүнсний зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 298.6 сая төгрөгийг бусад зардал, цэцэрлэгүүдэд хуваарилсан байна.*

2.142. Орон нутгийн цэцэрлэгийн хүнсний худалдан авалтыг аймаг, сумын ЗДТГ хариуцан нэгдсэн журмаар зохион байгуулдаг бөгөөд нийт хоолны зардлын 41.5 орчим хувийг зарцуулж байгаа нийслэлийн цэцэрлэгүүдийн хүнс хангамжийг "Асгат", "Хүнс хангамж", "Багачууд хүнс", "Өсвөр үе" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газрууд[98] хариуцан ажиллаж байна.

2.143. Аудитын хүрээнд орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагуудын зүгээс цэцэрлэгийн хүнсний худалдан авалт хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэхийг шалгаж дараах зөрчлүүдийг илрүүлж, албан шаардлага өгсөн байна. Тухайлбал,

- *Говь-Алтай - Тайлант онд зарлавал зохих худалдан авах ажиллагааг хугацаанд нь зохион байгуулаагүй өмнөх жилийн гэрээг үргэлжлүүлсэн, худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулсан болович материалын нэр төрлийг буруу сонгосноор 332.5 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн, гэрээ, үнийн саналд тусгасан үнээс 4.6 сая төгрөгийн өндөр үнээр худалдан авалт хийсэн;*
- *Дундговь аймаг Сайнцагаан сумын цэцэрлэгүүдийн "Хүүхдийн хоолны материал нийлүүлэх" ажлын тендерийн үнийн санал ирүүлэх урилгыг 3 болон түүнээс дээш этгээдэд мэдэгдсэн албан бичиг, баримт байхгүй, нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонинд зарлан мэдээлээгүй, үнэлгээний хорооны дүгнэлтэд гарын үсэг зурж баталгаажуулаагүй, үнэлгээний хорооны дүгнэлт, захиалагчийн үнийн саналыг архивын нэгж болгон хадгалаагүй, гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг баталгаажуулж архивлаагүй;*
- *Булган аймгийн Орхон сумын Өсөх-Ирээдүй, Булган сумын 1,2,3,4,6,7 дугаар цэцэрлэгүүд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэгжүүлээгүй шууд гэрээ байгуулан хүүхдийн хоолны материалыг худалдан авсан;*
- *Дархан-Уул аймаг: зах зээлийн үнэ болон гэрээний үнээс 1.6 сая төгрөгөөр илүү дүнгээр бараа материал бэлтгэсэн.*

2.144. Нийслэлийн хүнс хангамжийн байгууллагууд нь үйлдвэрлэгч, борлуулагчдын хүнсний бүтээгдэхүүнийг өөрсдийн үйл ажиллагааны зардал, ашиг шингээсэн үнээр цэцэрлэгүүдэд нийлүүлж, 2016-2018 онд нийт 16,436.3-18,506.7 сая төгрөгийн борлуулалтын орлоготой, 1,334.0-1,637.4 сая төгрөгийн үйл ажиллагааны зардалтай ажилласан байна. */Дэлгэрэнгүйг Хавсралт 11-с үзнэ үү/*

[94] Төсвийн тухай хууль 7.7 Энэ хуулийн 43 дугаар зүйлд заасНаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

[95] Төсвийн тухай хууль 45.2 Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ

[96] Төсвийн тухай хууль 45.2.1 нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ

[97] МУЗГ-ын 2012 оны 106 дугаар тогтоол 4. Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байхыг БШУС, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай

[98] Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 15 дугаар зүйлийн 2.Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ.

*Хүснэгт 16. Хүнс нийлүүлэгч компаниудын үйл ажиллагааны үзүүлэлт (сая төгрөг)*

| № | Үзүүлэлт | 2016 он | | 2017 он | | 2018 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Борлуулалтын орлого | 15,884.4 | 16,436.3 | 16,783.5 | 17,991.0 | 18,065.3 | 18,506.7 |
| 2 | Үүнээс хонь, үхрийн мах | - | 7,849.4 | - | 8,169.4 | - | 8,452.2 |
| 3 | Борлуулалтын өртөг | 15,475.5 | 11,532.6 | 16,303.4 | 16,525.6 | 17,335.1 | 16,706.5 |
| 4 | Үйл ажиллагааны зардал | 1,358.1 | 1,334.0 | 1,611.0 | 1,470.0 | 1,955.7 | 1,637.4 |
| 5 | Тайлант үеийн цэвэр ашиг | 96.4 | 140.5 | 154.5 | 350.5 | 245.4 | 110.5 |
| 5 | Ногдол ашиг | - | 46.5 | - | 279.6 | - | 60.3 |

*Эх сурвалж "Асгат", "Хүнс хангамж", "Өсвөр үе", "Багачууд хүнс" ААТОНӨҮГ*

2.145. Уг байгууллагууд нь төрийн өмчийн цэцэрлэгийг хичээлийн жилийн турш нэгдсэн байдлаар эрүүл, баталгаат хүнсний бүтээгдэхүүнээр тасралтгүй хангадаг ч 2016-2018 онд нийт 601.5 сая төгрөгийн ашигтай ажиллаж нийслэлийн төсөвт 386.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь цэцэрлэгүүдэд хүнсний материал зах зээлийн үнээр нийлүүлэгдэхгүй байх нэг шалтгаан болсон байна.

2.146. Мөн "Асгат" ОНӨААТҮГ нь 2019 оны 7 дугаар сараас НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэн[99] бөгөөд 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн НӨАТ шингэсэн, зах зээлийн үнээс өндөр үнээр харьяа цэцэрлэгүүдэд хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэхээр байна.

*Дүрслэл 30. Зарим нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт /төгрөг/*




| | Үхрийн мах | Хонины мах | Цагаан будаа | Элсэн чихэр |
|---|---|---|---|---|
| 2016 | 6,758 | 5,459 | 2,539 | 1,991 |
| 2017 | 7,390 | 6,239 | 2,649 | 2,527 |
| 2018 | 8,020 | 6,728 | 2,830 | 2,607 |

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

2.147. Аудитын хамарсан хугацаанд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнэ 6.6-13.7 хувиар өссөн байхад хүүхдийн хоолны зардлын хэмжээг тухай бүр шинэчлээгүйгээс хүүхдэд шаардлагатай хоол тэжээлийн илчлэг, шимт бодисыг батлагдсан нормативын[100] дагуу бүрэн өгч чадахгүй байх, цэцэрлэгийн хүнсний зарцуулалт бодитой бус байх, батлагдсан нормативаас хэтрүүлэн зарцуулах зөрчил үүсэхэд хүргэж байна. Тухайлбал;

- *Сүхбаатар аймгийн Баруун-урт сумын 2,3,5,7,9,10 дугаар цэцэрлэг, Асгат, Баяндэлгэр, Мөнххаан, Түвшинширээ, Уулбаян зэрэг сумдын цэцэрлэг хүүхдийн ирцийн бүртгэлийг архивлаж хадгаламжийн нэгж болгоогүй, ирцийн бүртгэлийг хаяж үрэгдүүлсэн, хувилбарт сургалтын ирцийн бүртгэлийг дутуу бүртгэснээс нийт 109.2 сая төгрөгийн зарцуулалт анхан шатны баримтаар хангалттай нотлогдохгүй байдал үүссэн;*
- *Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 1, 2, 3, 4, 6, 14 дүгээр цэцэрлэгүүд нэг хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 4.2 сая төгрөгийн хэтрүүлж зарцуулсан;*
- *Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 8 дугаар цэцэрлэг хоолны зардлыг 7.3 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан;*
- *Сүхбаатар аймаг - Хоолны зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрийн ирцийн бүртгэлтэй тулган шалгахад хоолны зардал, материалд 10.8 сая төгрөг илүү олгож зарцуулсан;*
- *Говь-Алтай аймаг - Хоолны норматив зардлыг 7.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн.*

2.148. Мөн цэцэрлэгүүд хүүхдийн хоолны цэсийг ихэвчлэн долоо хоногоор тооцож боловсруулдаг ч нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг 1 өдрөөр тооцохоор зааснаас хоолны цэс бүрэн мөрдөгдөхгүй, хүүхэд авбал зохих илчлэг, шимт бодисыг бүрэн авч чадахгүй, хүнсний зарцуулалтыг зөрүүтэй тайлагнах зэрэг эрсдэлтэй нөхцөл байдал үүсэхээр байгаа тул уг зардлыг долоо хоногийн дунджаар тооцож тогтоох нь зохистой байна.

[99] "Асгат" ОНӨААТҮГ нь 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдөр НӨАТ төлөгчийн 0056989 дугаар бүхий гэрчилгээ авсан
[100] ЭМС-ын 2014 оны 4 дүгээр сарын 113 дугаар "Монгол хүүхдийн хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээг батлах тухай" тушаалаар батласан

*Дүрслэл 31. Цэцэрлэгийн хоолны чихэрлэг зүйлсийн дундаж хэрэглээ, илчлэгийн хэмжээ, /гр, ккал/*







*Эх сурвалж: МХЕГ, НЭМҮТ-ийн 2018 онд цэцэрлэгийн хүүхдийн хоолны чанар, аюулгүй байдалд хяналт үнэлгээ хийсэн дүн*

2.149. Аудитын түүвэрт хамрагдсан цэцэрлэгүүдийн хоолны цэс, хүнсний зарцуулалтын тайлан, НЭМҮТ-ээс 2018 онд хийсэн судалгаанаас үзэхэд төрийн өмчийн цэцэрлэгийн хувьд хүүхэд авбал зохих илчлэгийг бүрэн авч чаддаггүй, гурил будаа төмснөөс үндсэн илчлэгээ авдаг, элсэн чихэр, өөх тосны хэрэглээ өндөр, ногооны эзлэх хувь хэмжээ бага, хувийн цэцэрлэгийн хүнсний зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

2.150. Цэцэрлэгийн багш ажилтнуудад хоолны зардал олгодоггүй бөгөөд аудитын явцад хийсэн ажиглалт, санал асуулгын дүнгээс үзэхэд цэцэрлэгт тухайн өдрийн хүүхдийн ирцийн дүнгээр хоол бэлтгэдэг, багш ажилтнууд сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаа явагдаж байхад хүүхдийг хяналтгүй үлдээх, гарч хооллох цаг боломж хомс байдгаас цэцэрлэгт бэлтгэж буй хоолноос хооллох явдал нийтлэг байна.

2.151. Иймд багш, ажилтнуудад хоолны хөнгөлөлт олгохоос илүүтэйгээр цэцэрлэгийн хоолны зардлыг тооцоолж төлөвлөхдөө багш, ажилтнуудын тоог оруулж тооцдог болох асуудлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн журамлаж зохицуулах нь зохистой байна.

2.152. Улсын төсвөөс 2016-2018 онд хувийн цэцэрлэгт суралцаж буй хүүхдийн хувьсах зардал, нэмэлт элсэлтийн зардалд нийт 65.3 тэрбум төгрөг олгосон байна.

*Хүснэгт 17. Хувийн цэцэрлэгт олгосон хувьсах зардлын санхүүжилт*

| № | Аймаг, нийслэл | 2016 он | 2017 он | 2018 он | Нийт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Улаанбаатар | 13,849.2 | 17,763.6 | 22,676.9 | 54,289.6 |
| 2 | Дархан-Уул | 853.6 | 787.7 | 852.2 | 2,493.5 |
| 3 | Дорнод | 422.2 | 385.9 | 548.9 | 1,357.0 |
| 4 | Ховд | 404.5 | 413.3 | 471.8 | 1,289.6 |
| 5 | Хөвсгөл | 364.5 | 374.9 | 378.1 | 1,117.4 |
| 6 | Дорноговь | 294.8 | 302.9 | 305.5 | 903.3 |
| 7 | Төв | 158.6 | 160.5 | 394.9 | 714.0 |
| 8 | Сэлэнгэ | 159.3 | 246.7 | 229.3 | 635.3 |
| 9 | Говь-сүмбэр | 107.7 | 112.2 | 158.0 | 377.9 |
| 10 | Хэнтий | 86.2 | 101.5 | 119.7 | 307.4 |
| 11 | Өвөрхангай | - | - | 48.7 | 48.7 |
| | Нийт | 16,700.6 | 20,649.2 | 26,184.0 | 63,533.7 |

*Эх сурвалж: Сангийн яам*

2.153. Аймаг, нийслэлийн боловсролын газрууд “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативаар санхүүжүүлэх аргачлал”-ын 3.12 дахь

заалт[101]-ыг бүрэн хэрэгжүүлээгүй, төрийн болон хувийн цэцэрлэгүүдэд олгож байгаа санхүүжилтэд тавих хяналт сул байна. Тухайлбал,

***Говь-сүмбэр аймаг**:*

- *Аймгийн СТСХ-ийн төсвийн мэргэжилтэн "Цэцэрлэгүүдийн санхүүжилт сар бүр зөвхөн батлагдсан төсвийн хуваарийн дагуу зориулалт тус бүрээр хийгддэг учраас СТСХ-ээс дээрх тооцоолол, хяналтыг хийдэггүй, БСУГ нь сургууль, цэцэрлэгүүдээр төлөвлөгөөт хяналт, шалгалтыг хийж ажилладаг" гэсэн тайлбар өгсөн байна.*

***Хөвсгөл аймаг***

- *БСУГ, сумын төрийн сан сар бүр санхүүжих хүүхдийн тоонд хяналт тавиагүй, хагас бүтэн жилээр санхүүжилтийн зөрүү тооцоогүйгээс 2016 онд 10.8 сая төгрөг, 2017 онд 7.3 сая төгрөг дутуу, 2018 онд 41.6 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон байна.*

***Баян-Өлгий аймаг***

- *Аймгийн Төрийн сан болон БСУГ-аас хувийн өмчийн цэцэрлэгүүдийн хүүхдийн тоо, хүүхэд/өдрийн гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажиллаагүй, аудитад энэ талаар ямар нэгэн баримт, материал ирүүлж чадаагүй болно.*

***Дорнод аймаг***

- *БСУГ нь дээрх аргачлалын заалтын дагуу сар бүр хүүхэд өдрийн гүйцэтгэлийг хянахгүй, зөвхөн сарын гүйцэтгэлийн мэдээг хянаж хүлээн авсан байна.*

***Орхон аймаг:***

- *Хувийн цэцэрлэгийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлдэггүйгээс 5 цэцэрлэгт олгосон санхүүжилтээс 253.9 сая төгрөгийг нийгмийн даатгалын тайланд зөрүүтэй тайлагнасан, Анхан шатны баримтгүйгээр 8.6 сая төгрөгийг зарцуулсан,*

***Нийслэл:***

- *Нийслэл дэх Төрийн аудитын байгууллагаас 2014 онд "Төрийн сангийн тогтолцооны 2013 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн" сэдэвт аудитаар түүвэрт хамрагдсан 77 төрийн бус хэвшлийн цэцэрлэгийн 51.9 хувьд хүүхэд өдрийн гүйцэтгэлээс 377.3 сая төгрөг илүү олгосон зөрчлийг илрүүлж албан шаардлага өгч байжээ.*

  *Гэвч 2018 онд хийсэн "Төрийн сангийн тогтолцооны 2017 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн"-д хийсэн аудитаар уг зөрчил бүрэн арилаагүй, түүвэрт хамрагдсан 127 цэцэрлэгийн 73.2 хувьд 209.3 сая төгрөгийг хүүхэд өдрийн гүйцэтгэлээс илүү олгосон байна.*

2.154. Мөн нийслэл, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хувийн цэцэрлэгт 2 нас хүрээгүй хүүхэд хамруулж, хувьсах зардал олгож байгаа нь СӨБ эзэмшүүлэх зорилготой нийцэхгүй, хүүхэд асрах, хамгаалах шинжтэй байна.

2.155. БСШУСЯ-ны СХОГ-ын зүгээс хувийн цэцэрлэгүүдэд улсын төсвөөс олгож байгаа хувьсах зардал бодит дэмжлэг болох эсэх талаар тооцоо судалгаа хийгээгүй бөгөөд цаашид байршил, хүчин чадал, төлбөрийн хэмжээнд уялдуулан санхүүжилтийн дүнг тооцох итгэлцүүр ашиглах замаар төсвийг хэмнэх боломжтой байна.

2.156. Мөн салбарын яамны зүгээс СӨБ-ын тусгай зориулалтын шилжүүлгийн зарцуулалт, гүйцэтгэлд бүрэн хяналт тавьдаггүй байна. Аудитын хүрээнд орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагууд түүвэрт хамрагдсан төрийн өмчийн цэцэрлэгүүд батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу арвилан хэмнэлттэй зарцуулж байгаа эсэхийг шалгаж дараах зөрчлүүдийг илрүүлж төлбөрийн акт, албан шаардлага өгсөн байна. Үүнд:

***Цалин, нэмэгдэл, үр дүнгийн урамшуулалтай холбоотой:***

- *Сэлэнгэ аймгийн Мандал сумын 1, 2, 3, 4 дугаар цэцэрлэг Түнхэл тосгоны 6 дугаар цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч нар сахилгын шийтгэлтэй ажилтнуудад холбогдох хууль, тогтоомжийг зөрчин цалин, үр дүнгийн урамшуулал зэрэгт нийт 37.9 сая төгрөг илүү олгосон;*
- *Сэлэнгэ аймгийн Баянгол сумын цэцэрлэг нь улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгосон боловч жилийн эцэст нийт 8.7 сая төгрөгийн үр дүнгийн гэрээний урамшуулал олгосон, тус цэцэрлэг нь эмчид хөдөө орон нутагт ажилласны нэмэгдэл цалинд 0.5 сая төгрөг олгосон;*
- *Дархан-уул аймаг - Эрхлэгч болон ажиллагсдад ур чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал, мэргэжлийн зэргийн нэмэгдэл зэрэгт 9.9 сая төгрөгийг тушаал шийдвэргүйгээр илүү олгосны 62.8 хувийг удирдах албан тушаалтан эзэлж байна;*
- *Завхан аймаг 2018 онд Аймгийн засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, аудитын албанаас 34 цэцэрлэгийн 2016, 2017 онуудын үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар нийт 41.4 сая төгрөгийн зөрчил илрүүлэн төлбөрийн акт тогтоосноос цэцэрлэгийн эрхлэгч нар холбогдох эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй үр дүнгийн урамшуулал авсан, сахилгын шийтгэлтэй албан хаагчид нэг удаагийн тэтгэмж олгосон зэрэг зөрчил 70 орчим хувийг эзэлж байна.*

[101] Сургалтын нормативт зардлын санхүүжилтийг аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс сар бүр хүүхэд өдрөөр хянаж, төсвийн санхүүжилтийн сар, улирлын хуваарьт батлагдсаны дагуу сар тутам олгоно

***Бусад үйл ажиллагаатай холбоотой:***

- *Завхан аймгийн нийт цэцэрлэгүүд 2018 оны жилийн эцэст 176.7 сая төгрөгийн хоол хүнсний материалын үлдэгдэл нөөц их хэмжээгээр бэлтгэсэн;*
- *Баян-Өлгий аймгийн СӨБ-ын байгууллагуудын 42 хувь нь буюу 16 цэцэрлэг 2016 онд 18.4 сая төгрөгийн, 2017 онд 60.9 сая төгрөгийн, 2018 онд 45.5 сая төгрөгийн өр төлбөр үүсгэсэн;*
- *Говь-Алтай аймаг: анхан шатны баримтын бүрдүүлбэр хангалтгүй, хүнсний материал зөрүүтэй бүртгэгдсэн, цалин амралтын мөнгө давхардуулан олгосон, гадны байгууллагын ажилтныг шагнасан, цалин, цалингийн нэмэгдлийг зөрүүтэй тооцоолж олгосон, агуулахын үлдэгдэл зөрүүтэй зэрэг нийт 23.3 сая төгрөгийн зөрчил гаргасан;*
- *Сэлэнгэ аймаг Мандал сумын Түнхэл тосгоны 6 дугаар цэцэрлэг нь 2017 онд хүүхдийн хоолны нормативд зардлаас цэцэрлэгийн 50 жилийн ойн хүлээн авалтад 11.8 сая төгрөгийн үхрийн мах болон бусад хүнсний материал зарцуулсан боловч нярвын тайланг хуурамчаар үйлдэж, үлдэгдлээр тайлагнаж байгаад 2018 оны 10 дугаар сард зарлагаар бүртгэсэн;*
- *Говь-Алтай аймаг: Хүнсний материалын үлдэгдлийг 5.3 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн, хөрөнгө оруулалтаар ирсэн 1.9 сая төгрөгийн компьютер, хандив тусламжаар бий болсон 1.3 сая төгрөгийг данс бүртгэлд тусгаагүй;*
- *Архангай аймгийн Өлзийт сумын хүүхдийн цэцэрлэг, Эрдэнэбулган сумын 11 дүгээр цэцэрлэгийн нярав 2.1 сая төгрөгийн хүнсний материал дутаасан.*

2.157. Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хуульд заасны дагуу орон нутаг дахь Төрийн аудитын байгууллагууд төрийн өмчийн цэцэрлэгийн жил бүрийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж, нийт 30,360.2 сая төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлж тухай бүр холбогдох арга хэмжээг авч ажиллажээ.

2.158. Гэвч алдаа, зөрчлийн нийт зардалд эзлэх хувь 2016-2018 онд буураагүй төдийгүй 2.7-5.3 хувь болж нэмэгдсэн байгаа тул салбарын яам, орон нутгийн удирдлагын зүгээс батлагдсан төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэхтэй холбоотой дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал,

*Хүснэгт 18. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл (сая төгрөгөөр)*

| № | Он | НББ, тайлагнал тай холбоотой | Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой | Хууль, тогтоомж ийн хэрэгжилт тэй | Дотоод хяналт, хариуцлага тай холбоотой | Худалдан авалттай холбоотой | Зориулалт бус зарцуулалт-тай холбоотой | Бусад | Нийт | Нийт зардалд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2016 он | 4,440.1 | 303.2 | 1,118.3 | 177.9 | 241.7 | 52.9 | 200.3 | 6,534.4 | 2.7 |
| 2 | 2017 он | 3,970.1 | 171.4 | 4,619.5 | 225.9 | 15.8 | 113.4 | 266.7 | 9,382.7 | 3.7 |
| 3 | 2018 он | 12,888.4 | 142.8 | 814.4 | 335.7 | 101.0 | 39.9 | 120.9 | 14,443.1 | 5.3 |
| | Нийт | 21,298.6 | 617.4 | 6,552.2 | 739.4 | 358.5 | 206.2 | 587.9 | 30,360.2 | |

*Эх сурвалж: Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллага*

## *Сургуулийн өмнөх боловсрол олгох үйлчилгээнд тавьж буй хяналт үр нөлөөгүй байна.*

2.159. Цэцэрлэгийн удирдлага, эрхлэгч нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2[102]-т, МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу боловсролын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, биелэлтийг дүгнэх чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой ч удирдлагын болон дотоод хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байна. Тухайлбал,

- *Нийслэлийн БЗД-ийн “Маргад хотхоны үрс”, “Наран Эрдэнэ-Идү” СХД-ийн “Тэнгэрлэг хүүхдүүд”, “Бүтээлч багачууд” цэцэрлэгийн эрхлэгч дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй;*
- *Сүхбаатар аймаг - Төрийн өмчийн цэцэрлэгт дотоод хяналтын нэгжийг тухайн цэцэрлэг дээр 3-5 албан тушаалтан хавсран гүйцэтгэдэг, уг албан тушаалтанд хяналт шалгалт хэрхэн хийх талаар зохих мэдлэг, чадварыг эзэмшүүлээгүй;*
- *Говь-Алтай аймаг 19 цэцэрлэгийн удирдлагын санхүүгийн хяналт үр нөлөөгүй, 2 цэцэрлэгт дотоод хяналтын ажилтныг тушаалаар томилоогүй;*
- *Баян-өлгий аймаг: 9 цэцэрлэгийн дотоод хяналтын нэгж төлөвлөсөн ажлуудаа дутуу хэрэгжүүлсэн, дотоод хяналтын тайлан, дүнг хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл, биелэлтийг тооцсон баримт материалыг бүрэн гүйцэт хөтөлж, баримтжуулаагүй, хэрэгжилт хангалтгүй;*

[102] 11.2.1.боловсролын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, биелэлтийг дүгнэх, тайлагнах;

- *Говь-Сүмбэр: Хувийн 5 цэцэрлэг дотоод хяналтын ажилтныг томилоогүй, хяналтыг зохион байгуулаагүй, 5 цэцэрлэгийн дотоод хяналтын хэрэгжилтийг тооцоогүй, үр дүнгүй;*
- *Дархан-уул: 3, 5 дугаар цэцэрлэг дотоод хяналтын чиглэлээр төлөвлөсөн ажлаа бүрэн хэрэгжүүлээгүй, 9 дүгээр цэцэрлэг дотоод хяналтын үүрэг даалгавраа эргэж хянаагүйгээс өмнөх хяналтаар илэрсэн зөрчил дахин давтагдсан;*
- *Баянхонгор: Шинэжинст, Жинст сумын цэцэрлэг дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, Баянбүрд багийн бага цэцэрлэг, Баян-овоо, Богд, Галуут сумын цэцэрлэгүүд дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэх журам, төлөвлөгөө тайлан байхгүй, цэцэрлэгийн удирдлагын хяналт хангалтгүй байна.*

2.160. Цэцэрлэгийн зөвлөл нь Боловсролын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4.1[103], 35.4.2[104], 35.4.3[105], 35.4.4[106], 35.4.5[107], 35.4.6[108], 35.4.8[109], 35.4.9[110], 35.4.10[111], 35.4.11-т[112] заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой ч аймаг, орон нутгийн зарим цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжоогүй, үйл ажиллагаагаа тайлагнаагүй байна.

2.161. Аудитын явцад төрийн өмчийн 420 цэцэрлэгийн 30523 эцэг эхчүүдээс авсан санал асуулгаар *"Танай хүүхдийн цэцэрлэгт цэцэрлэгийн зөвлөл ажилладаг уу" гэсэн асуултад 35.3 хувь мэдэхгүй, "Цэцэрлэгийн зөвлөлөөс тавьж буй хяналт эцэг эхчүүдэд ил тод нээлттэй байдаг уу"* гэсэн асуултад 36.6 хувь "*мэдэхгүй"* гэж хариулсан нь цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагаа ил тод бус, хяналт муу байгааг харуулж байна.Тухайлбал,

- *Улаанбаатар: Төрийн төрийн өмчийн 15 цэцэрлэг нь дүүргийн Засаг дарга төрийг төлөөлөх гишүүдийг томилоогүйгээс, хувийн 7 цэцэрлэг цэцэрлэгийн зөвлөлгүйгээс тухайн цэцэрлэгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам батлах, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, дэг журам, дотоод зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох, үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх, сургалтын чанар, хүүхэд төлөвшүүлэх, хамгаалах, хөгжүүлэх ажлын үр дүн, түвшнийг сайжруулах талаар цэцэрлэгийн удирдлага болон үүсгэн байгуулагчид санал тавих, эрхлэгчийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, дэмжлэг үзүүлэх ажлыг хийгээгүй;*
- *Хэнтий: "Хэрлэн-6", "Хэрлэн-7", "Хэрлэн-8" дугаар цэцэрлэг, Баянхутаг сумын цэцэрлэг, "Жүржхэн" цэцэрлэгийн зөвлөл нь 2016-2018 онд хяналт шалгалтын ажил хийгээгүй;*
- *Сүхбаатар: Төрийн өмчийн 24 цэцэрлэгээс 22 цэцэрлэг нь цэцэрлэгийн зөвлөл байгуулаагүй;*
- *Баянхонгор: Баянлиг, Баянцагаан, Бууцагаан сумын, 6, 9, 5 дугаар цэцэрлэгт цэцэрлэгийн зөвлөл үйл ажиллагаа явуулсан эсэх нь тодорхойгүй, чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй;*
- *Орхон: Цэцэрлэгийн зөвлөл нь төлөвлөгөө,тайлан хэлэлцдэг ч хяналтаа хэрэгжүүлдэггүй;*
- *Дархан-уул: Сумын 1, 3, 5, 9, 16 дугаар, Шарын гол сумын 19 дүгээр цэцэрлэгийн зөвлөл чиг үүргээ хэрэгжүүлээгүй;*
- *Увс: Улаангом сумын бүх цэцэрлэгт цэцэрлэгийн зөвлөл үйл ажиллагаа хэрхэн явуулсан, хяналт шалгалт хийсэн эсэхийг нотлох баримтгүй;*
- *Дорнод: Төрийн өмчийн цэцэрлэгүүдийн цэцэрлэгийн зөвлөл нь цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлсэн тухай ажлын баримт материал хангалтгүй;*
- *Баян-Өлгий: 10 цэцэрлэг цэцэрлэгийн зөвлөлийн дүрмийг боловсруулаагүй, хяналтын ажлаа тайлагнаагүй, 6 цэцэрлэг зөвлөлийн хийх ажлын төлөвлөгөө батлаагүй, хяналт хангалтгүй;*
- *Говь-сүмбэр: аймгийн 1,2,3,6 дугаар цэцэрлэгт цэцэрлэгийн зөвлөл хяналт хэрэгжүүлсэн эсэх нь тодорхойгүй, "цэцэрлэгийн зөвлөлөөс тавьж буй хяналт эцэг эхчүүдэд ил тод нээлттэй байдаг уу" гэсэн эцэг эхчүүдээс авсан санал асуулгад 59.3 хувь нь мэдэхгүй гэж хариулсан;*
- *Сэлэнгэ: Шаамар сумын 2, Сүхбаатар сумын 2, 4, Баянгол сумын "Бүжинхэн" цэцэрлэгүүд цэцэрлэгийн зөвлөлгүй, 9 цэцэрлэгийн зөвлөл нь төлөвлөгөө, дүрмээ батлаагүй, үйл ажиллагаа явуулсныг нотлох хурлын тэмдэглэл, ажлын тайлан баримт материал үйлдээгүй, хяналт хангалтгүй байна.*

2.162. Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, СӨБ олгох, үйлчилгээнд эцэг эх асран хамгаалагч нар Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2[113], 14.1.4[114]-т заасан цэцэрлэгийн сургалтын орчин, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал, сургалтын чанартай холбогдсон санал хүсэлт, гомдол гаргах, хяналт тавих, СӨБ-ын

---

[103] сургууль, цэцэрлэгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, дүрэм, журам батлах, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;
[104] сургууль, цэцэрлэгийн дэг журам, дотоод зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох;
[105] сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх;
[106] сургалтын чанар, хүүхэд төлөвшүүлэх, хамгаалах, хөгжүүлэх ажлын үр дүн, түвшнийг сайжруулах талаар сургууль, цэцэрлэгийн удирдлага болон үүсгэн байгуулагчид санал тавих
[107] захирал, эрхлэгчийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, дэмжлэг үзүүлэх;
[108] багш, сурагч, ажилтны эрх ашгийг хамгаалах;
[109] сургалтын төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу тогтоох.
[110] сургууль, цэцэрлэгийн хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд санал өгөх, зайлшгүй нөхцөл байдлын улмаас хүүхдээ 6 наснаас нь сургуульд элсүүлэх боломжгүй талаар малчин эцэг, эхийн гаргасан хүсэлтийг үндэслэж шийдвэрлэх;
[111] сургууль, цэцэрлэгийн батлагдсан төсөв, сангийн зарцуулалтад хяналт тавих, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлттэй танилцах, мэдээлэх;
[112] сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагааны тайланг гаргаж, хамт олны хуралд тайлагнах.
[113] СӨБ-ын тухай хууль 14.1.Эцэг, эх, асран хамгаалагч дараах эрхтэй:
14.1.2 Цэцэрлэгийн сургалтын орчин, хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал, сургалтын чанартай холбогдсон санал хүсэлт, гомдол гаргах, хяналт тавих"
[114] СӨБ-ын тухай хууль 14.1.4 Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ, багшийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар хяналт тавьж, санал гаргах"

үйлчилгээ, багшийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар хяналт тавих чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.163. Аудитын явцад 574 цэцэрлэгийн 7484 багш, ажилчдаас "Эцэг, эхчүүд цэцэрлэгээс зохион байгуулсан арга хэмжээ, сургалтын үйл ажиллагаанд тогтмол оролцдог уу" гэсэн санал асуулгад огт оролцдоггүй гэж 39.2 хувь хариулсан нь эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс цэцэрлэгийн үйл ажиллагаанд тавих хяналт, үүрэг оролцоо хангалтгүйг харуулж байна. Тухайлбал,

- *Сүхбаатар аймаг: төрийн өмчийн цэцэрлэг, бүлгийн багш нар эцэг, эхтэй хамтран ажиллах талаар жил бүр төлөвлөгөө гаргасан ч хэрхэн хамтарч ажилласан, ямар сургалт зөвлөгөө өгсөн нь тодорхойгүй, төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаагүй цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эхээс хяналт тавьдаггүй;*
- *Булган аймаг: Цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эх оролцдог хэдий ч үр нөлөөтэй хяналтыг хэрэгжүүлдэггүй;*
- *Баян-өлгий аймаг: Өлгий сумын 3, 5, 7, 8, 9 дүгээр цэцэрлэг, Сагсай, Толбо, Алтанцөгц, Цэнгэл сумын 1 дүгээр цэцэрлэг эцэг, эхтэй хамтран ажиллах төлөвлөгөөнд эцэг, эхийн зүгээс цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт хийх заалт тусгаагүй, хүүхдийн хоол хүнсний чанар байдал, сургалтын үйл ажиллагаанд хяналт хийж байгаагүй;*
- *Дархан-уул аймаг: төрийн болон хувийн хэвшлийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс тавих хяналт, үүрэг оролцоо хангалтгүй;*
- *Сэлэнгэ аймаг: төрийн өмчийн цэцэрлэгийн эцэг эхчүүдээс "Та хүүхдийнхээ цэцэрлэгийн үйл ажиллагаанд хэрхэн хяналт тавьдаг бэ? гэсэн санал асуулгад 62.2 хувь нь хяналт тавьдаггүй гэж хариулсан эцэг эхийн зүгээс цэцэрлэгийн үйл ажиллагаанд тавих хяналт, үүрэг оролцоо хангалтгүй байна.*

***Яамны хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын нэгжийн үндсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй, СӨБ-ын талаар баримтлах бодлогын хэрэгжилт, үр дүнг үнэлж дүгнэх ажлыг төлөвлөж хэрэгжүүлээгүй, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтын үр нөлөө хангалтгүй байна***

2.164. Боловсролын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д "Боловсролын хяналтыг хяналт-шинжилгээ, тандалт, судалгаа хийх хэлбэрээр хэрэгжүүлнэ." 28 дугаар зүйлийн 28.1.2[115], Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6[116]-д зааснаар салбарын яамны бодлогын хэрэгжилт, үр дүнг үнэлж дүгнэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх эрх, үүргийг тодорхой заасан байна.

2.165. Мөн МУЗГ-ын 2017 оны 267 дугаар тогтоолоор баталсан "Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-т тус яамны хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын нэгжийн үндсэн үүрэг, чиг үүргийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- *Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилт болон яамны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, боловсролын хяналтыг хяналт-шинжилгээ, тандалт, судалгааны хэлбэрээр хэрэгжүүлж салбарын бодлогыг дүнтэй болгох, салбарын болон яамны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.*

2.166. БСШУСЯ-ны ХШҮДАГ-ын даргын 2016-2018 оны үр дүнгийн гэрээ[117], тус газрын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө[118]-нд чиг үүргээр тодорхойлсон СӨББГ-аас авч хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаанд тандалт судалгаа хийх, СӨБ олгох үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомж, бодлогын хэрэгжилт, МУЗГ болон яамнаас хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх ажлыг төлөвлөөгүй байна.

2.167. Мөн СӨБ олгох үйлчилгээний чанар хүртээмж, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих бодлого боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, холбогдох харилцааг зохицуулах чиглэлээр үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд яамны удирдлагад дэмжлэг үзүүлэхүйц аливаа ажлыг төлөвлөж тусгаагүй байна.

[115] 28.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
28.1.2.боловсролын салбарын хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэл, төлөвлөгөө, үзэл баримтлал, үндсэн чиглэл, дүрэм, журам, хөтөлбөр, төсөл, заавар, аргачлалыг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тооцох;

[116] 8.6.Төрийн захиргааны төв байгууллага төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайлан тус бүрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

[117] ХШҮДАГ-ын даргын ТНБД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгчтэй 2017, 2018 онд байгуулсан үр дүнгийн гэрээ

[118] БСШУСС ТНБД-ын түр орлон гүйцэтгэгч баталсан 2016-2018 оны тус газрын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө

2.168. ХШҮДАГ-ын 2017-2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан зарим арга хэмжээг огт хэрэгжээгүй, хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй, тайлагнаагүй, нэгжийн үндсэн чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд:

- *Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх /2017 оны 2 дугаар сард/*
- *Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод хяналт шинжилгээ үнэлгээ хийх /2017 оны 06 сар/*
- *Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, салбарын захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнах /2017 оны 12 сар/*
- *Салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайлагнах /2018 оны 2-3 сар, 6 сар/*
- *Салбарын хэмжээнд мөрдөж буй эрх зүйн баримт бичигт хяналт-шинжилгээ хийж, холбогдох санал,дүгнэлт зөвлөмж боловсруулж, сайд, ТНБД-г мэдээллээр хангасан байх. /2018 оны 8-10 сар/*
- *СӨБ-ын хувилбарт болон үндсэн сургалтын өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийж, дүгнэлт гаргана /2018 оны 3 сар/*
- *БСШУСС-ын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд, хяналт шинжилгээ үнэлгээ хийх /2018 оны 23 сар,6 сар/*

2.169. БСШУСЯ нь Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого хэрэгжиж эхэлснээс хойш 4 жилийн хугацаанд 1 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ЗГХЭГ-т 2019 онд хүргүүлсэн нь уг бодлогын баримт бичгийн 7.5[119], Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6[120]-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

***Хөтөлбөрийн биелэлтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийхдээ биелэлт арга хэмжээний хүрэх түвшин үр дүнтэй нь уялдуулан бодитой үнэлж, дүгнээгүйгээр тайлагнасан, үр дүнг тооцоогүй байна.***

2.170. Яамны ХШҮДАГ-аас 2016-2018 онд МУЗГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим санд оруулсан МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн[121] биелэлт, хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээг хийхдээ бодитой үнэлж, дүгнэлгүйгээр тайлагнасан байна. /*Дэлгэрэнгүйг Хавсралт 12-с үзнэ үү*/ Тухайлбал,

- *МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөний 3.2.2-т "Хүүхэд бүр цэцэрлэгт" хөтөлбөрийг хэрэгжүүлж хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгоно" зорилтыг хэрэгжүүлэхээр 5 арга хэмжээнд нийт 66,277.0 сая төгрөгийг улсын, орон нутгийн, гадаад тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч хүрэх түвшин үр дүнгийн үзүүлэлтийг бүрэн хангаагүй, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаагүй байхад хэрэгжилтийг 100 хувиар үнэлж тайлагнасан байна. Үүнд:*
  - ➢ *Арга хэмжээ-1: Цэцэрлэг барих төр, орон нутгийн болон олон улсын тусламжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг 2017 онд цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийн тоог 7 хувиар буурах гэсэн зорилгоо хангасан эсэхийг тайлагнаагүй, 2018 онд хүрэх түвшинийг 29 хувиар бууруулахаар заасан ч 2016-2020 онд цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийн тоо 27 хувиар буурсан гэж тайлагнасан, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаагүй байхад 2017, 2018 онд хэрэгжилтийг 100 хувиар үнэлсэн;*
  - ➢ *Арга хэмжээ-2: Хөдөө орон нутагт малчдын хүүхдэд зориулсан гэр цэцэрлэгийн тоог өсгөх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг 2018 онд нийт 28 гэр нийлүүлсэн гэж тайлагнасан ч хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаагүй, жил бүр 50 гэр цэцэрлэг нийлүүлэх, малчны нийт 1000 хүүхдийг хамруулах гэсэн зорилгыг хангаагүй байхад хэрэгжилтийг 100 хувиар үнэлсэн;*
  - ➢ *Арга хэмжээ-3: Хувийн хэвшлийн болон байгууллагын цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх /Жил бүр хувийн цэцэрлэгийг 60-аар, байгууллагын цэцэрлэгийг 10-аар нэмэгдүүлэх/ арга хэмжээг 2017 онд хувийн цэцэрлэг, байгууллагын цэцэрлэгийн тоо хэдээр нэмэгдүүлсэн нь тодорхой бус, 2018 онд зорилтод түвшинд хүрээгүй, 2017-2018 онд хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаагүй, тухайн онуудын хүрэх түвшинийг бүрэн хангаагүй байхад хэрэгжилтийг 100 хувиар үнэлсэн;*
  - ➢ *Арга хэмжээ-4: Төрийн өмчийн цэцэрлэгт хүүхдийн хоолны зардлыг төрөөс болон эцэг эх, асран хамгаалагчаас хариуцах хувь, хэмжээг тогтоон хэрэгжүүлэх /2018-2020 он тус бүрд нийт хоолны зардлын 53 хувийг улсын төсвөөс, 47 хувийг эцэг эх, асран хамгаалагч нь хариуцдаг болох/ арга хэмжээ хэрэгжээгүй, хүрэх түвшинийг хангаагүй байхад хэрэгжилтийг 100 хувиар үнэлсэн.*

2.171. БСШУС-ын 2003 оны 321 дүгээр тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх тоон болон чанарын шалгуур үзүүлэлт", БСШУСС-ын 2013 оны А/315 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэлийн Боловсролын газрын үлгэрчилсэн журам"-ын 2.4-т "...Боловсролын

[119] Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хоёр жил тутамд МУЗГ, УИХ-д тайлагнаж, боловсролын чанарын үр дүнд тогтмол үнэлэлт, дүгнэлт өгч байна

[120] Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль 8.6.Төрийн захиргааны төв байгууллага төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, тайлан тус бүрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

[121] УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолын 1-т "МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг баталж, хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулж байх" заасан

байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих,...” чиг үүргийн дагуу зарим аймгийн БСУГ цэцэрлэгийн үйл ажиллагааны чанар, үр дүнг үнэлээгүй, хяналт-шинжилгээ хийгээгүй байна. Тухайлбал,

- *Нийслэл, дүүргийн боловсролын газар, хэлтсийн хяналтаар хувийн цэцэрлэгт мэргэжлийн бус багш ажиллуулсан, ирцийн бүртгэлийг дутуу хөтөлсөн, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр нь шаардлага хангаагүй, аюулгүй байдлын орц, гарцгүй, хүүхдийн ариун цэврийн өрөөг стандартын дагуу зохион байгуулаагүй, камержуулалт дутуу зэрэг нийтлэг зөрчлийг илрүүлсэн ч хүний нөөцийн хүрэлцээ, ажлын ачааллаас нь шалтгаалж хяналт шалгалтад бүх цэцэрлэгийг бүрэн хамруулдаггүйгээс зөрчил арилаагүй, жил бүр давтагддаг;*
- *Хэнтий: боловсролын газрын хяналт сул, аймгийн цэцэрлэгүүдэд хяналт-шинжилгээ хийгээгүй, үнэлгээ өгөөгүй 2017,2018 онд багшлах эрх нь дууссан багш нар цэцэрлэгүүдэд ажилласан, багшид тавигдах шаардлага хангахгүй;*
- *Говь-сүмбэр:2016-2017 онд цэцэрлэгүүдэд хийсэн хяналт шалгалтын тайлан, 2018 онд төрийн өмчийн 6 цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн тайлан, зөвлөмжийг цэцэрлэгүүдэд хүргүүлээгүй, хэрэгжилтийг тооцож ажиллаагүй, хувийн цэцэрлэгүүдэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийгээгүй;*
- *Сэлэнгэ: Цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьсан тайлан, дүгнэлтийг холбогдох цэцэрлэгүүдэд хүргүүлээгүй;*
- *Сүхбаатар:Цэцэрлэгүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч байгаа ч зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй;*
- *Дундговь:2016-2018 онд СӨБ хариуцсан мэргэжилтэн тогтвор суурьшилтай ажиллаагүйгээс СӨБ олгох бодлого, цөм хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллаагүй;*
- *Өмнөговь: СӨБ олгох, үйлчилгээ үзүүлж буй байгууллагад хяналт хэрэгжүүлээгүй.*

### *СӨБ олгох, үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавьж буй мэргэжлийн байгууллагын хяналт сул байна*

2.172. МХЕГ-ын 2019 оны 06/3203 дугаар албан бичигт “...СӨБ-ын чиглэлээр улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллагад 2016 онд 95 цэцэрлэг, 2017 онд 320, 2018 онд 331, цэцэрлэгт хяналт, шалгалтыг явуулж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн ...” гэж дурдсан нь нийт цэцэрлэгийн 2016 онд 7.0 хувь, 2017 онд 22.6 хувь, 2018 онд 23.1 хувийг эзэлж байгаа нь хяналт шалгалтын хамрах хүрээ хангалтгүй байгааг харуулж байна.

*Хүснэгт 19. Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт, шалгалтын хамарсан хүрээ*

| Огноо | Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэгийн тоо | Хяналт шалгалтын чиглэл | Эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэм | | | | Боловсролын хяналт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хамраг-далт | Эрсдэлийн үнэлгээ | | | хамраг далт | эрсдэлийн үнэлгээ | | |
| | | | | бага | дунд | их | | бага | дунд | их |
| 2016 он | 1354 | Хяналт шалгалт | 95 | 51 | 36 | 7 | | | | |
| | | Зөвлөн туслах үйлчилгээ | 0 | | | | | | | |
| 2017 он | 1416 | Хяналт шалгалт | 211 | 142 | 144 | 34 | 277 | 104 | 131 | 42 |
| | | Зөвлөн туслах үйлчилгээ | 109 | | | | | | | |
| 2018 он | 1435 | Хяналт шалгалт | 180 | 128 | 172 | 31 | | | | |
| | | Зөвлөн туслах үйлчилгээ | 151 | | | | | | | |

*Эх сурвалж: Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны 06/3203 тоот албан бичигт дурдсан тоо дүн*

2.173. Мэргэжлийн хяналтын байгууллагын 2016-2018 оны хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан 331-415 цэцэрлэгүүдэд дараах нийтлэг зөрчил, дутагдал илэрсэн байна. Үүнд:

*Хүснэгт 20. Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт, шалгалтын зөрчлийн агуулга*

| № | Нийтлэг илэрч байгаа зөрчил, дутагдлын нэр | 2016-2017он | 2018 онд |
|---|---|---|---|
| | | Зөрчлийн хувь | |
| | Нийт хяналт, шалгалт, төвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан цэцэрлэгийн тоо | 415 | 331 |
| 1 | Нэг хүүхдэд ногдох талбай нь эрүүл ахуйн нормоос 1.5-2.2 дахин их | 66.6 | |
| 2 | Нэг суултуурт ногдох хүүхдийн тоо их | 61.5 | |
| 3 | Эдэлбэр газрын хөрсөнд шинжилгээ хийлгэж баталгаажилт гаргуулаагүй | 61.0 | |
| 4 | Эдэлбэр газар хүрэлцээгүй | 52.0 | 29.0 |
| 5 | Төрийн өмчийн цэцэрлэгийн 1 багшид ногдох хүүхдийн тоо 2.6 дахин их байгаа | 55.9 | 58.0 |
| 6 | Нэг угаалтуурт ногдох хүүхдийн тоо эрүүл ахуйн нормоос их | 50.0 | |
| 7 | СӨБ-ын чиглэлийн мэргэжил эзэмшээгүй, мэргэжлийн бус багштай | 48.4 | |
| 8 | Хүнсний түүхий эд,бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтлөөгүй | 41.0 | |
| 9 | Эмчийн өрөө шаардлагатай тоног төхөөрөмжгүй | 36.0 | |
| 10 | Дотоод хяналт шалгалтаар илэрсэн арга хэмжээг арилгахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлдэггүй | 36.0 | |
| 11 | Зориулалтын бус байртай | | 28.0 |
| 12 | Сургалтын зориулалтын гадна тоглоомын талбай, тоног төхөөрөмж дутагдалтай, аюулгүй байдлыг хангахгүй | 33.3 | 61.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 13 | *Хөгжмийн заал, кабинетгүй, биеийн тамирын хичээлийн зориулалтын заалгүй* | | *67.0* |
| 14 | *Цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагын урьдчилан хяналт шалгалтад хамрагдаж дүгнэлт гаргуулаагүй* | *28.0* | |
| 15 | *Угаагуур,суултуур,ариун цэврийн байгууламж стандартад нийцэхгүй* | *25.0* | |
| 16 | *Багш ажилчид эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд заасан хугацаанд бүрэн хамрагдаагүй* | *24.2* | |

2.174. Мөн аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа цэцэрлэгт холбогдох хууль тогтоомж, “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандарт MNS 6558:2015”, уг стандартыг хэрэгжүүлэх зөвлөмж -ийн хэрэгжилтэд хийсэн шалгалтаар илэрсэн дараах нийтлэг зөрчлүүд бүрэн арилаагүй, давтан гарсаар байна. Тухайлбал,

- *Зориулалтын байргүй, барилга байгууламж нь суулт өгсөн, шугам хоолойн хэвийн ажиллагаа алдагдсан;*
- *Цэцэрлэгийн орчны стандарт хангалтгүй, биеийн тамирын болон тоглоомын талбай стандартын шаардлага хангахгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд зориулсан налуу замгүй,*
- *Биеийн тамир, хөгжмийн заал, танхимгүй, бүлэг бүр тоглох болон унтлагын өрөөгүй, бүлгийн өрөө нь агаарын солилцоо хангалттай явагдах нөхцөлийг бүрдүүлээгүй*
- *Хүүхдийн хоол нь хоол хүнсээр авбал зохих илчлэг, шимт бодисын хэмжээг хангаж буй эсэхийг тооцож үнэлэлт дүгнэлт өгөөгүй,*
- *Хоол үйлдвэрлэлийн хэсгийн өрөө тасалгаа нь хүрэлцээгүй, эрүүл ахуйн шаардлага хангаагүй, түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнийг зохих хэмд хадгалж, хяналт тавьдаггүй,*
- *Мэргэжлийн эмчгүй, халдвар хамгааллын шаардлага хангасан тусгаарлах өрөөгүй, 1 хүүхдэд ногдох талбайн стандартын шаардлага хангаагүй,*
- *Багшийн үзүүлэн, ангийн тоглоом наадгайн хүрэлцээ хангамжийн талаар судалгаа дүгнэлт хийж ажиллаагүй, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн тоглоом, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсэг бусад хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн хангалтгүй,*
- *Цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулах норм, нормативаас хэтэрсэн,*
- *2 нас хүрээгүй хүүхдийг цэцэрлэгт хамруулсан, хамран сургах хүүхдийн тоо хамралтын хувь, анги дүүргэлтийн урьдчилсан төлөв байдлыг гаргаагүй, хамран сургах тойргийн бус хүүхдийг цэцэрлэгт хамруулсан,*
- *Мэргэжлийн болон багшлах эрхтэй багшаар бүрэн хангагдаагүй, багш, ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх ажлыг зохион байгуулаагүй,*
- *Сургалтын чанар хүүхэд төлөвшүүлэх ажлын үр дүнг хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй,*
- *Галын аюулгүй байдлыг хангасан холбогдох байгууллагын дүгнэлтгүй зэрэг зөрчил дутагдал нийтлэг илэрчээ.*

***Мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, хэрэгжих боломжгүй, зөрчил дутагдал дахин давтагдаж байгаа нь хяналтын үр нөлөөг бууруулж байна***

2.175. Аймаг, орон нутгийн МХГ, боловсролын хэлтсээс хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага, зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн ч төсөв санхүү хангалтгүй, хугацаа шаардлагатай, албан тушаалтны ажлын хариуцлагагүй зэргээс зарим зөвлөмж бүрэн хэрэгжээгүй нь хяналтын үр нөлөөг бууруулж байна. Тухайлбал,

- *Ховд: МХГ-аас 11 албан шаардлага, 1 акт үйлдэж, 32 зөвлөмж өгч, Алтай, Манхан, Зэрэг сумдын цэцэрлэгийн барилгад их засвар хийхгүйгээр барилгыг ашиглах боломжгүй, Жаргалант сумын 1, 10 дугаар цэцэрлэгийн барилгыг шинээр барьж байгуулах, Жаргалант сумын 1, 2, 3, 6, 10 дугаар цэцэрлэгүүдэд их засвар шаардлагатай гэсэн дүгнэлтийг гаргасан ч төсөвт хөрөнгө тусгаагүйгээс шинээр барих, их засварын ажлыг хийгээгүй, үйл ажиллагаа явуулахыг хориглосон барилгад цэцэрлэг ажиллаж байгаа нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд хүмүүжих эрхийг зөрчсөн.*
- *Баян-өлгий: МХГ-аас 15 албан шаардлага, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ажилдаа хариуцлагагүй хандсан 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг аймгийн Засаг даргад хүргүүлж, 2 цэцэрлэгт үйл ажиллагааг түр зогсоох арга хэмжээ авсан;*
- *Завхан: МХГ-ын хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд тухайн асуудлыг шийдвэрлэх санхүүгийн нөөц боломцоогүй;*
- *Өмнөговь:Нэг бүлэгт ногдох хүүхдийн тоо буураагүй, мэргэжлийн багш боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй;*
- *Улаанбаатар: МХГ, боловсролын хэлтсийн хяналт шалгалтаар цэцэрлэгүүд мэргэжлийн багшаар бүрэн хангагдаагүй, хүүхдийн тоо барилгын хүчин чадлаас их, агаарын чийгшил нь стандарт нормоос бага, цэцэрлэг хөгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөө боловсруулаагүй, СӨБ-д хамрагдаж чадаагүй хамран сургах тойргийн хүүхдэд хувилбарт сургалт зохион байгуулаагүй, гадна орчин шаардлага хангаагүй зэрэг зөрчлийг арилгах зөвлөмж нь албан тушаалтны ажлын хариуцлагагүй байдал, төсөв хөрөнгө, цаг хугацаа шаардлагатайгаас бүрэн хэрэгжээгүй, зөрчил дутагдал бүрэн арилахгүй байна.*

## Холбогдох байгууллагын санал:

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-24-80, Факс: (976-11) 32-31-58
E-mail: info@mecss.gov.mn, http:www.mecss.gov.mn

2019. 12. 30 № 1а/11397

танай ____________ -ны № ______________ -т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С.БҮРЭНБАТ
ТАНАА

Танай 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 02/2085 тоот албан бичгийн хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Холбогдох нотлох баримтын хуулбарыг хавсаргав.

Хавсралт ...47... хуудастай

Ё.БААТАРБИЛЭГ

061902633

байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих,...” чиг үүргийн дагуу зарим аймгийн БСУГ цэцэрлэгийн үйл ажиллагааны чанар, үр дүнг үнэлээгүй, хяналт-шинжилгээ хийгээгүй байна. Тухайлбал,

- *Нийслэл, дүүргийн боловсролын газар, хэлтсийн хяналтаар хувийн цэцэрлэгт мэргэжлийн бус багш ажиллуулсан, ирцийн бүртгэлийг дутуу хөтөлсөн, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр нь шаардлага хангаагүй, аюулгүй байдлын орц, гарцгүй, хүүхдийн ариун цэврийн өрөөг стандартын дагуу зохион байгуулаагүй, камержуулалт дутуу зэрэг нийтлэг зөрчлийг илрүүлсэн ч хүний нөөцийн хүрэлцээ, ажлын ачааллаас нь шалтгаалж хяналт шалгалтад бүх цэцэрлэгийг бүрэн хамруулдаггүйгээс зөрчил арилаагүй, жил бүр давтагддаг;*
- *Хэнтий: боловсролын газрын хяналт сул, аймгийн цэцэрлэгүүдэд хяналт-шинжилгээ хийгээгүй, үнэлгээ өгөөгүй 2017,2018 онд багшлах эрх нь дууссан багш нар цэцэрлэгүүдэд ажилласан, багшид тавигдах шаардлага хангахгүй;*
- *Говь-сүмбэр:2016-2017 онд цэцэрлэгүүдэд хийсэн хяналт шалгалтын тайлан, 2018 онд төрийн өмчийн 6 цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийсэн тайлан, зөвлөмжийг цэцэрлэгүүдэд хүргүүлээгүй, хэрэгжилтийг тооцож ажиллаагүй, хувийн цэцэрлэгүүдэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийгээгүй;*
- *Сэлэнгэ: Цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьсан тайлан, дүгнэлтийг холбогдох цэцэрлэгүүдэд хүргүүлээгүй;*
- *Сүхбаатар:Цэцэрлэгүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч байгаа ч зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй;*
- *Дундговь:2016-2018 онд СӨБ хариуцсан мэргэжилтэн тогтвор суурьшилтай ажиллаагүйгээс СӨБ олгох бодлого, цөм хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллаагүй;*
- *Өмнөговь: СӨБ олгох, үйлчилгээ үзүүлж буй байгууллагад хяналт хэрэгжүүлээгүй.*

### *СӨБ олгох, үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавьж буй мэргэжлийн байгууллагын хяналт сул байна*

2.172. МХЕГ-ын 2019 оны 06/3203 дугаар албан бичигт “...СӨБ-ын чиглэлээр улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллагад 2016 онд 95 цэцэрлэг, 2017 онд 320, 2018 онд 331, цэцэрлэгт хяналт, шалгалтыг явуулж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн ...” гэж дурдсан нь нийт цэцэрлэгийн 2016 онд 7.0 хувь, 2017 онд 22.6 хувь, 2018 онд 23.1 хувийг эзэлж байгаа нь хяналт шалгалтын хамрах хүрээ хангалтгүй байгааг харуулж байна.

*Хүснэгт 19. Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт, шалгалтын хамарсан хүрээ*

| Огноо | Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэгийн тоо | Хяналт шалгалтын чиглэл | Эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэм | | | | Боловсролын хяналт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хамраг-далт | Эрсдэлийн үнэлгээ | | | хамраг далт | эрсдэлийн үнэлгээ | | |
| | | | | бага | дунд | их | | бага | дунд | их |
| 2016 он | 1354 | Хяналт шалгалт | 95 | 51 | 36 | 7 | | | | |
| | | Зөвлөн туслах үйлчилгээ | 0 | | | | | | | |
| 2017 он | 1416 | Хяналт шалгалт | 211 | 142 | 144 | 34 | 277 | 104 | 131 | 42 |
| | | Зөвлөн туслах үйлчилгээ | 109 | | | | | | | |
| 2018 он | 1435 | Хяналт шалгалт | 180 | 128 | 172 | 31 | | | | |
| | | Зөвлөн туслах үйлчилгээ | 151 | | | | | | | |

*Эх сурвалж: Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны 06/3203 тоот албан бичигт дурдсан тоо дүн*

2.173. Мэргэжлийн хяналтын байгууллагын 2016-2018 оны хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан 331-415 цэцэрлэгүүдэд дараах нийтлэг зөрчил, дутагдал илэрсэн байна. Үүнд:

*Хүснэгт 20. Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт, шалгалтын зөрчлийн агуулга*

| № | Нийтлэг илэрч байгаа зөрчил, дутагдлын нэр | 2016-2017он | 2018 онд |
|---|---|---|---|
| | | Зөрчлийн хувь | |
| | Нийт хяналт, шалгалт, төвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан цэцэрлэгийн тоо | 415 | 331 |
| 1 | Нэг хүүхдэд ногдох талбай нь эрүүл ахуйн нормоос 1.5-2.2 дахин их | 66.6 | |
| 2 | Нэг суултуурт ногдох хүүхдийн тоо их | 61.5 | |
| 3 | Эдэлбэр газрын хөрсөнд шинжилгээ хийлгэж баталгаажилт гаргуулаагүй | 61.0 | |
| 4 | Эдэлбэр газар хүрэлцээгүй | 52.0 | 29.0 |
| 5 | Төрийн өмчийн цэцэрлэгийн 1 багшид ногдох хүүхдийн тоо 2.6 дахин их байгаа | 55.9 | 58.0 |
| 6 | Нэг угаалтуурт ногдох хүүхдийн тоо эрүүл ахуйн нормоос их | 50.0 | |
| 7 | СӨБ-ын чиглэлийн мэргэжил эзэмшээгүй, мэргэжлийн бус багштай | 48.4 | |
| 8 | Хүнсний түүхий эд,бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтлөөгүй | 41.0 | |
| 9 | Эмчийн өрөө шаардлагатай тоног төхөөрөмжгүй | 36.0 | |
| 10 | Дотоод хяналт шалгалтаар илэрсэн арга хэмжээг арилгахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлдэггүй | 36.0 | |
| 11 | Зориулалтын бус байртай | | 28.0 |
| 12 | Сургалтын зориулалтын гадна тоглоомын талбай, тоног төхөөрөмж дутагдалтай, аюулгүй байдлыг хангахгүй | 33.3 | 61.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 13 | Хөгжмийн заал, кабинетгүй, биеийн тамирын хичээлийн зориулалтын заалгүй | | 67.0 |
| 14 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагын урьдчилан хяналт шалгалтад хамрагдаж дүгнэлт гаргуулаагүй | 28.0 | |
| 15 | Угаагуур,суултуур,ариун цэврийн байгууламж стандартад нийцэхгүй | 25.0 | |
| 16 | Багш ажилчид эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд заасан хугацаанд бүрэн хамрагдаагүй | 24.2 | |

2.174. Мөн аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа цэцэрлэгт холбогдох хууль тогтоомж, “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандарт MNS 6558:2015”, уг стандартыг хэрэгжүүлэх зөвлөмж -ийн хэрэгжилтэд хийсэн шалгалтаар илэрсэн дараах нийтлэг зөрчлүүд бүрэн арилаагүй, давтан гарсаар байна. Тухайлбал,

- *Зориулалтын байргүй, барилга байгууламж нь суулт өгсөн, шугам хоолойн хэвийн ажиллагаа алдагдсан;*
- *Цэцэрлэгийн орчны стандарт хангалтгүй, биеийн тамирын болон тоглоомын талбай стандартын шаардлага хангахгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдэд зориулсан налуу замгүй,*
- *Биеийн тамир, хөгжмийн заал, танхимгүй, бүлэг бүр тоглох болон унтлагын өрөөгүй, бүлгийн өрөө нь агаарын солилцоо хангалттай явагдах нөхцөлийг бүрдүүлээгүй*
- *Хүүхдийн хоол нь хоол хүнсээр авбал зохих илчлэг, шимт бодисын хэмжээг хангаж буй эсэхийг тооцож үнэлэлт дүгнэлт өгөөгүй,*
- *Хоол үйлдвэрлэлийн хэсгийн өрөө тасалгаа нь хүрэлцээгүй, эрүүл ахуйн шаардлага хангаагүй, түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнийг зохих хэмд хадгалж, хяналт тавьдаггүй,*
- *Мэргэжлийн эмчгүй, халдвар хамгааллын шаардлага хангасан тусгаарлах өрөөгүй, 1 хүүхдэд ногдох талбайн стандартын шаардлага хангаагүй,*
- *Багшийн үзүүлэн, ангийн тоглоом наадгайн хүрэлцээ хангамжийн талаар судалгаа дүгнэлт хийж ажиллаагүй, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн тоглоом, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсэг бусад хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн хангалтгүй,*
- *Цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо сургалтын хэвийн үйл ажиллагаа явуулах норм, нормативаас хэтэрсэн,*
- *2 нас хүрээгүй хүүхдийг цэцэрлэгт хамруулсан, хамран сургах хүүхдийн тоо хамралтын хувь, анги дүүргэлтийн урьдчилсан төлөв байдлыг гаргаагүй, хамран сургах тойргийн бус хүүхдийг цэцэрлэгт хамруулсан,*
- *Мэргэжлийн болон багшлах эрхтэй багшаар бүрэн хангагдаагүй, багш, ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх ажлыг зохион байгуулаагүй,*
- *Сургалтын чанар хүүхэд төлөвшүүлэх ажлын үр дүнг хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй,*
- *Галын аюулгүй байдлыг хангасан холбогдох байгууллагын дүгнэлтгүй зэрэг зөрчил дутагдал нийтлэг илэрчээ.*

***Мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, хэрэгжих боломжгүй, зөрчил дутагдал дахин давтагдаж байгаа нь хяналтын үр нөлөөг бууруулж байна***

2.175. Аймаг, орон нутгийн МХГ, боловсролын хэлтсээс хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага, зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн ч төсөв санхүү хангалтгүй, хугацаа шаардлагатай, албан тушаалтны ажлын хариуцлагагүй зэргээс зарим зөвлөмж бүрэн хэрэгжээгүй нь хяналтын үр нөлөөг бууруулж байна. Тухайлбал,

- *Ховд: МХГ-аас 11 албан шаардлага, 1 акт үйлдэж, 32 зөвлөмж өгч, Алтай, Манхан, Зэрэг сумдын цэцэрлэгийн барилгад их засвар хийхгүйгээр барилгыг ашиглах боломжгүй, Жаргалант сумын 1, 10 дугаар цэцэрлэгийн барилгыг шинээр барьж байгуулах, Жаргалант сумын 1, 2, 3, 6, 10 дугаар цэцэрлэгүүдэд их засвар шаардлагатай гэсэн дүгнэлтийг гаргасан ч төсөвт хөрөнгө тусгаагүйгээс шинээр барих, их засварын ажлыг хийгээгүй, үйл ажиллагаа явуулахыг хориглосон барилгад цэцэрлэг ажиллаж байгаа нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд хүмүүжих эрхийг зөрчсөн.*
- *Баян-өлгий: МХГ-аас 15 албан шаардлага, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ажилдаа хариуцлагагүй хандсан 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг аймгийн Засаг даргад хүргүүлж, 2 цэцэрлэгт үйл ажиллагааг түр зогсоох арга хэмжээ авсан;*
- *Завхан: МХГ-ын хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд тухайн асуудлыг шийдвэрлэх санхүүгийн нөөц бололцоогүй;*
- *Өмнөговь:Нэг бүлэгт ногдох хүүхдийн тоо буураагүй, мэргэжлийн багш боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй;*
- *Улаанбаатар: МХГ, боловсролын хэлтсийн хяналт шалгалтаар цэцэрлэгүүд мэргэжлийн багшаар бүрэн хангагдаагүй, хүүхдийн тоо барилгын хүчин чадлаас их, агаарын чийгшил нь стандарт нормоос бага, цэцэрлэг хөгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөө боловсруулаагүй, СӨБ-д хамрагдаж чадаагүй хамран сургах тойргийн хүүхдэд хувилбарт сургалт зохион байгуулаагүй, гадна орчин шаардлага хангаагүй зэрэг зөрчлийг арилгах зөвлөмж нь албан тушаалтны ажлын хариуцлагагүй байдал, төсөв хөрөнгө, цаг хугацаа шаардлагатайгаас бүрэн хэрэгжээгүй, зөрчил дутагдал бүрэн арилахгүй байна.*

## Холбогдох байгууллагын санал:

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-24-80, Факс: (976-11) 32-31-58
E-mail: info@mecss.gov.mn, http:www.mecss.gov.mn

2019. 12. 30 № 1а/11397

танай ____________-ны №____________-т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С.БҮРЭНБАТ ТАНАА

Танай 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 02/2085 тоот албан бичгийн хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Холбогдох нотлох баримтын хуулбарыг хавсаргав.

Хавсралт ...47... хуудастай

Ё.БААТАРБИЛЭГ

061902633

Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2019 оны 12 дугаар сарын 30.-ны өдрийн [illegible] албан тоотын хавсралт

**_“Төрөөс сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа өнөөгийн байдал, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд өгөх санал_**

“Хуульд заасан дүрэм, журам, стандарт, норм нормативыг боловсруулаагүй, хуульд нийцүүлэн зарим норм, норматив, дүрэм, журмыг шинэчлэн тогтоогоогүй байна.” гэсэн тайлангийн төслийн дүгнэлтийг дараах үндэслэлээр зөвшөөрөх боломжгүй байна.

Нэг. Дүрэм

**(I) Тусгай, гэр болон сувиллын цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм**

*ҮАГ-ын тайлбар 1-г үзнэ үү*

2015 онд батлагдсан Стандарт, хэмжил зүйн газрын “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандарт”-ын 7 дугаар хэсэгт “Гэр цэцэрлэгт тавигдах шаардлага”-д “Цэцэрлэг нь гэрт сургалтын үйл ажиллагаа зохион байгуулж болно” гэж тусгасан. Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 4.1.15-т зааснаар “Гэр цэцэрлэг” нь сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх бөгөөд хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байгаа орчин нь монгол гэр юм. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/118 дугаар тушаалаар батлагдсан “Цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-ийг баримтлан гэр цэцэрлэг нь үйл ажиллагаагаа зохион байгуулах ёстой бөгөөд гэр цэцэрлэгт тусгайлан дүрэм гаргах шаардлагагүй болно.

*Нотлох баримт: “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандартын 7.2, “Цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”*

**(II) Асрамжийн болон халамжийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм**

*ҮАГ-ын тайлбар 2-г үзнэ үү*

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1а/9887 дугаар албан тоот бичгээр Хүүхдийн сувиллын цэцэрлэгийн харьяаллыг Эрүүл мэндийн яаманд шилжүүлсэн. Асрамжийн болон халамжийн цэцэрлэг нь хүүхдийг ар гэрийн боломж, амьдралын нөхцөлөөр нь ялгаварлан тусгаарлаж, хүүхдийн эрх зөрчиж байгаа тул Боловсролын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд сувиллын цэцэрлэгийн хэв шинжийг хасахаар төлөвлөж байна. Одоо үйл ажиллагаа явуулж буй дээрх хэв шинжийн цэцэрлэгүүд нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/118 дугаар тушаалаар батлагдсан “Цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-ийн дагуу ажиллаж байна.

*Нотлох баримт: БСШУС-ын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 1а/9887 дугаар албан бичиг*

**(III) Цэцэрлэг, түүний орчны эрүүл ахуй, ариун цэврийн дүрэм**

*ҮАГ-ын тайлбар 3-г үзнэ үү*

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2015 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн хамтарсан А/253/251/173 дугаар тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага”-ыг баталсан бөгөөд шаардлагад

1. Унд, ахуйн усан хангамжид тавигдах шаардлага,
2. Ариун цэврийн байгууламжид тавигдах шаардлага
3. Гар угаагуур болон шүршүүрт тавигдах шаардлага
4. Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийн засвар үйлчилгээнд тавигдах шаардлага

5. Эрүүл ахуйн боловсрол, зан үйлийн өөрчлөлтөд тавигдах шаардлага
6. Гал тогоо болон хоол хүнс боловсруулахад тавигдах шаардлага
7. Хатуу хог хаягдал, бохир усыг зайлуулах менежментэд тавигдах шаардлагыг тодорхойлж хэрэгжүүлж байна.

Цэцэрлэг, түүний барилга байгууламжид тавих эрүүл ахуйн шаардлага, усны чанар, аюулгүй байдал, Сургалт хүмүүжлийн эрүүл ахуйн шаардлага, дүрэмт хувцас, тоглоом, хичээлийн хэрэглэлд тавих эрүүл ахуйн шаардлага,цэцэрлэгийн хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад тавигдах шаардлагыг тус тус багтаасан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын Сургалт хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага" Стандарт хэмжил зүйн газрын (MNS 6799:2019) стандартаар батлуулсан.

*Нотлох баримт: БСШУ-ны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2015 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн хамтарсан А/253/251/173 дугаар тушаалаар "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага", "" (MNS 6799:2019)*

(IY) **Багшийн ёс зүйн хорооны дүрэм.**

*ҮАГ-ын тайлбар 4-г үзнэ үү*

"Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм", "Ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам"-ыг БСШУС-ын сайдын 2018 оны А/243 дугаар тушаалаар батлан мөрдөж байна.

*Нотлох баримт: Дүрэм, журам батлах тухай БСШУС-ын сайдын 2018 оны А/243 дугаар тушаал, түүний хавсралтууд*

Хоёр. Журам

**(I) Цэцэрлэгийн багшид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалан нэмэгдэл цалин олгох журам**

*ҮАГ-ын тайлбар 5-г үзнэ үү*

Тус яамнаас 2019 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 1а/7613 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдад хандан Засгийн газрын 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад нэмэлт оруулах тухай саналыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж өгөхийг хүсч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид үндсэн цалингийн 10 хувьтай тэнцэх нэмэгдэл хөлс олгох тухай Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг хүргүүлсэн болно.

Цалин, нэмэгдэл хөлс олгох асуудал Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн сайдын бүрэн эрхэд хамаарах тул энэ асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж батлах ёстой. Засгийн газрын тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж олгох хувь хэмжээг тогтоосны дараа тус яам нэмэгдэл хөлс олгох журмыг боловсруулж батлуулна.

*Нотлох баримт: 2019 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 1а/7613 тоот албан бичиг*

**(II) Багшид ажлын гүйцэтгэлд үндэслэн суурилсан урамшууллыг олгох журам**

*ҮАГ-ын тайлбар 6-г үзнэ үү*

Цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багшийн ажлыг үнэлэх дүгнэх журмын төсөл боловсруулах ажлын хэсгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/764 дүгээр тушаалаар байгуулж, боловсруулах ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж байна. Тушаалд заасан 2020 оны 1 дүгээр сард журмын төслийг Сайдад танилцуулна.

*Нотлох баримт: Ажлын хэсэг байгуулах тухай БСШУС-ын сайдын тушаал*

*ҮАГ-ын тайлбар 7-г үзнэ үү*

**(III) Цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг үнэлэх журам**

Цэцэрлэгийн үйл ажиллагааг үнэлэх журам, шалгуур үзүүлэлтийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/803 дугаар тушаалаар баталсан.

*Нотлох баримт: БСШУС-ын сайдын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/803 дугаар тушаалын хуулбар*

Хоёр. Стандарт

**(I) Цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний эрүүл аюулгүй байдлыг хангахад чиглэсэн стандарт**

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2015 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн хамтарсан А/253/251/173 дугаар тушаалаар "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага"-ын Зургаадугаар бүлэгт "Гал тогоо болон хоол хүнс боловсруулахад тавигдах шаардлага"-ыг тусган оруулсан.

*ҮАГ-ын тайлбар 8-г үзнэ үү*

Эрүүл мэндийн яамтай хамтран Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны сургалт хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага (MNS 6799:2019)-ыг боловсруулж батлуулсан.

Түүнчлэн Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандарт (MNS 6558:2015)-ын 5.6-д Хүүхдийн цэцэрлэгийн гал тогоонд тавих шаардлагыг баталсан.

*Нотлох баримт: БСШУ-ны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2015 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн хамтарсан А/253/251/173 дугаар тушаалаар "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага", Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандарт (MNS 6558:2015), Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрны сургалт хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага (MNS 6799:2019)*

**(II) Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрны орчны эрүүл ахуйн шаардлага**

*ҮАГ-ын тайлбар 9-г үзнэ үү*

Эрүүл мэндийн яамтай хамтран Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрны орчны эрүүл ахуйн шаардлага (MNS 6799:2019)-ыг 2019 онд батлуулсан.

*Нотлох баримт: Цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, түүний дотуур байрны орчны эрүүл ахуйн шаардлага (MNS 6799:2019)*

Норм, норматив

**(I) Цэцэрлэгийн суралцагчийн эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлын норм, норматив**

*ҮАГ-ын тайлбар 10-г үзнэ үү*

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2015 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн хамтарсан А/253/251/173 дугаар тушаалаар "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага"-ыг батлан, хэрэгжүүлэх зөвлөмж, Үндэсний сургалт, Үндэсний судалгаа, загвар байгуулах ажлыг тус яамнаас хариуцан амжилттай зохион байгуулж байна.

*Нотлох баримт: Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага" БСШУ-ны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2015 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн хамтарсан А/253/251/173 дугаар тушаал*

Тусгай цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм (1), Хүүхдийн чадвар, чадамж, хөгжлийн ахицыг үнэлэх журам (2), СӨБ эзэмшүүлэхэд шаардагдах ном, гарын авлага, сургалтын үзүүлэн зохиох, хэвлүүлэх, түгээх журам (3), Цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний хангамж,

үйлчилгээ үзүүлэх журам (4)-ыг 2020 онд боловсруулан батлахаар төлөвлөгөөнд тусгаад байна.

Тусгай цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм (1), Хүүхдийн чадвар, чадамж, хөгжлийн ахицыг үнэлэх журам (2), СӨБ эзэмшүүлэхэд шаардагдах ном, гарын авлага, сургалтын үзүүлэн зохиох, хэвлүүлэх, түгээх журам (3), Цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам (4)-ыг 2020 онд боловсруулан батлахаар төлөвлөгөөнд тусгаад байна.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ

**Саналд өгсөн тайлбар**:

БСШУСЯ-аас ирүүлсэн 10 санал бүхий нийт 47 хуудас баримт материал ирүүлснийг аудитын баг нягтлан үзэж 2 саналыг хүлээн авч тайланд зохих найруулгын өөрчлөлт оруулсан бөгөөд 8 саналыг хүлээн авах боломжгүй тул дараах тайлбарыг өгч байна.

| *Саналд өгөх тайлбар* | |
|---|---|
| *ҮАГ-ын тайлбар 1* | *Саналыг хянан үзэж тайлангийн 9 хуудасны 4 дэх мөрийн өгүүлбэрийг ...Тусгай болон сувиллын цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм... гэж найруулгын өөрчлөлт оруулаа.* |
| *ҮАГ-ын тайлбар 2* | *Аудитын хамрах хугацаа 2016-2018 оны үйл ажиллагааг хамруулсан бөгөөд нотлох баримт нь 2019.11.14-ны өдрийн, холбогдох дүрэм батлагдаагүй тул саналыг хүлээн авах боломжгүй байгаа тул хэвээр үлдээв.* |
| *ҮАГ-ын тайлбар 3* | *БСШУС, ЭМСС, СС-ын хамтарсан 2015 оны А/253/251/173 дугаар тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль ,дотуур байрын ус,ариун цэвэр,эрүүл ахуйд тавигдах норм, шаардлаа" нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6-т "...эрүүл ахуй, ариун цэврийн дүрмийг батална..." гэсэн заалттай нийцэхгүй байх тул саналыг хүлээн авах боломжгүй байх тул тайланд найруулгын өөрчлөлт оруулаагүй болно.* |
| *ҮАГ-ын тайлбар 4* | *БСШУСС-ын 2018 оны А/243 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам" нь Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 13.1-т "Багшийн ёс зүйн хорооны дүрмийг...батална" гэсэн заалттай нийцэхгүй байх тул саналыг хүлээн авах боломжгүй байгаа тул хэвээр үлдээв.* |
| *ҮАГ-ын тайлбар 5* | *Аудитын хамрах хугацаа 2016-2018 оны үйл ажиллагааг хамруулсан бөгөөд нотлох баримт нь 2019.08.27-ны өдрийн, холбогдох журам батлагдаагүй тул саналыг хүлээн авах боломжгүй байх тул тайланд найруулгын өөрчлөлт оруулаагүй болно.* |
| *ҮАГ-ын тайлбар 6* | *Аудитын хамрах хугацаа 2016-2018 оны үйл ажиллагааг хамруулсан бөгөөд нотлох баримт нь 2019.11.29-ны өдрийн, холбогдох журам батлагдаагүй тул саналыг хүлээн авах боломжгүй байгаа тул хэвээр үлдээв.* |
| *ҮАГ-ын тайлбар 7* | *Аудитын хамрах хугацаа 2016-2018 оны үйл ажиллагааг хамруулсан бөгөөд нотлох баримт нь 2019.12.17-ны өдрийнх тул тайлангийн 9 дүгээр хуудасны 13 дэх мөрийн өгүүлбэрт өөрчлөлт оруулаагүй болно.* |
| *ҮАГ-ын тайлбар 8* | *БСШУС, ЭМСС, СС-ын хамтарсан 2015 оны А/253/251/173 дугаар тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль,дотуур байрын ус,ариун цэвэр,эрүүл ахуйд тавигдах норм,шаардлаа" нь Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-т "...Цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний эрүүл, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн стандарт, норм, нормативыг батална..." гэсэн заалттай нийцэхгүй байх тул саналыг хүлээн авах боломжгүй.* |
| *ҮАГ-ын тайлбар 9* | *Аудитын хамрах хугацаа 2016-2018 оны үйл ажиллагааг хамруулсан бөгөөд нотлох баримт нь 2019.12.13-ны өдрийнх тул тайлангийн 9 дүгээр хуудасны 23 дэх мөрийн өгүүлбэрт өөрчлөлт оруулаагүй болно.* |
| *ҮАГ-ын тайлбар 10* | *БСШУС, ЭМСС, Сангийн сайдын хамтарсан 2015 оны А/253/251/173 дугаар тушаалаар баталсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль,дотуур байрын ус,ариун цэвэр,эрүүл ахуйд тавигдах норм,шаардлаа"-ыг баталсан нь Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-т "*...Цэцэрлэг, ... хүүхдийн хоол, хүнсний эрүүл, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн норм, нормативыг батална..." *гэсэн заалттай нийцэж байх тул саналыг хүлээн авч тайлангийн 9 хуудасны 26 дэх мөрийн өгүүлбэрийг хаслаа.* |

## ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Сургуулийн өмнөх боловсрол олгох, үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулж буй хуулийн заалтууд харилцан уялдаагүй[122], салбарын яамны хүний нөөцийн тогтворгүй байдлаас шаардлагатай дүрэм, журам, стандартын 58.3 хувийг боловсруулаагүй[123] байна.

2. Цэцэрлэгийн барилга байгууламжийн дунд хугацааны төлөвлөлтгүй[124], барилгын норм ба дүрэмд шинээр барих орон сууцны хороолол, хотхоныг цэцэрлэгийн барилгын хамт төлөвлөж барих зохицуулалтгүйгээс хүүхдийн хамрагдалт хүчин чадлаас 2 дахин хэтэрч багшийн ачаалал, хүүхдийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, эрүүл мэндэд нөлөөлж байна.

3. Сургалтын цөм хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийгээгүй, цөм хөтөлбөрт тусгасан үндсэн чадвараар[125] хүүхдийн ахицын нэгдсэн үнэлгээ хийхгүй байгаагаас салбарын яамны хэрэгжүүлж буй арга хэмжээ нь СӨБ-ын бодлого, зорилтоо хангаж үр нөлөө үзүүлж буй эсэх, төсвийн хөрөнгийн зарцуулалт нь үр ашигтай байгаа эсэхийг тооцож, дүгнэх боломж бүрдээгүй байна.

4. Салбарын яам ажлын байрны эрэлт хэрэгцээнд үндэслэсэн хүний нөөцийн нэгдсэн бодлого төлөвлөгөө боловсруулж, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ аваагүйгээс мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ хангалтгүй, багш бэлтгэж буй байгууллагуудын сургалтын чанарт үр нөлөөтэй хяналт хэрэгжүүлээгүйгээс багшийн ур чадвар харилцан адилгүй байна,

5. Засгийн газар хүүхдийн хоолны зардлыг 2012 оноос, нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 2016 оноос хойш шинэчлээгүй, төсвийн санхүүжилтийг цэцэрлэгийн онцлог, хүчин чадал, төлбөрийн хэмжээ, хүүхдийн ирцтэй уялдуулаагүйгээс төсвийг үр өгөөжтэй төлөвлөх боломжгүй, хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулах, үр ашгийг тооцохгүй байх нөхцөлийг бий болгож байна.

6. Салбарын яамны зүгээс сургуулийн өмнөх боловсрол олгох бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын болон урсгал зардлын зарцуулалтад, аймаг нийслэлийн ИТХ-ын зүгээс хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд тавих хяналт сул, мэргэжлийн байгууллагын хяналт үр нөлөөгүй байгаа зэргээс зөрчлүүд дахин давтагдсаар байна.

[122] Тайлангийн 6 дугаар хуудас
[123] Тайлангийн 9 дүгээр хуудас
[124] Тайлангийн 18 дугаар хуудас
[125] Үндсэн чадварууд: Хөдөлгөөн - эрүүл мэнд, Зан чанар - харилцаа, Хэл яриа, Байгаль - нийгмийн орчин, Математикийн энгийн төсөөлөл, Хөгжим - дүрслэх урлаг

## ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

**Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдад /Ё.Баатарбилэг/:**

- Хүний нөөцийн нэгдсэн бодлого төлөвлөгөө боловсруулж, мэргэшсэн, чадварлаг боловсон хүчний тогтвортой байдлыг хангах, Сургуулийн өмнөх боловсрол олгох, үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулах дүрэм, журам, стандарт, норм норматив, дунд хугацааны бодлого, төлөвлөлтийг боловсруулж, мөрдүүлэх,

- Аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах гэрээнд цэцэрлэгийн барилгын эзэмшил, ашиглалтын эдэлбэр газрыг нөөцөд бүртгүүлэх, газар олголтын ажлын үр дүнг тусгах асуудлыг судалж, шийдвэрлэх;

**Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд /Ё.Баатарбилэг/, Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/ нарт:**

- Хүүхдийн хоолны зардал, нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг инфляц, үнийн өсөлт, цэцэрлэгийн онцлог, хүчин чадал, байршил, төлбөрийн хэмжээтэй уялдуулан тооцож жил бүр шинэчлэн сайжруулах санал боловсруулж, шийдвэрлүүлэх,

- Төсвийн хөрөнгийн үр өгөөжийг тооцож болохуйц үнэлгээний системийг боловсруулан хэрэгжүүлж, түүнд тавих хяналтыг сайжруулж, үр дүнг тооцох,

**Барилга, хот байгуулалтын сайдад /Х.Баделхан/ :**

- Барилгын норм ба дүрэмд шинээр барих орон сууцны хотхон, хороололд цэцэрлэгийн барилгыг хамт төлөвлөх зохицуулалт тусгах, орон сууцны барилгад 10 хүртэлх хүүхдийн багтаамжтай цэцэрлэг барих норм ба дүрмийг өнөөгийн нөхцөлд нийцүүлэн шинэчлэх,

**Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд /Р.Дагва/:**

- Хот байгуулалтын тухай хууль, Боловсролын тухай хуульд заасны дагуу хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, барилга байгууламжийн газар олголтод тавих хяналтыг сайжруулж, хэрэгжилтийг хангуулах, шинээр барих цэцэрлэгийн барилгын эзэмшил, ашиглалтын эдэлбэр газрыг нөөцөд авах шийдвэр гаргаж ажиллах,

**БСШУСЯ-ны холбогдох газар, нэгжийн удирдлагад:**

- Аудитын тайлантай нарийвчлан танилцаж, газар, нэгж, албан тушаалын чиг үүргийн дагуу өөрт олгогдсон эрхийн хүрээнд аудитын дүнд тусгасан асуудлыг шийдвэрлэх ажлыг хариуцаж зохион байгуулах.

# ХАВСРАЛТУУД:

***Хавсралт 1***

"Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого" Сургуулийн өмнөх боловсролын тухай хуультай нийцэж байгаа талаарх судалгаа

| № | үзүүлэлт | Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд | Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого | "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлогод тусгагдаагүй,орхигдуулсан зүйл |
|---|---|---|---|---|
| 1 | Сургуулийн өмнөх боловсролын зорилго | "Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино | Зорилго тодорхойлоогүй | Зорилго тодорхойлоогүй |
| 2 | Сургуулийн өмнөх боловсролын агуулга, стандарт | 5.1.1.бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болгох; | Хөдөлгөөн, эрүүл мэнд | Ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал, хэвшилтэй болгох; |
| 3 | | 5.1.2.хэл яриа, сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх, хүрээлэн байгаа орчин, юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох; | Хэл яриа, харилцаа. Байгаль, нийгмийн орчны талаарх мэдлэг төсөөлөл, Математикийн энгийн төсөөлөл, | |
| 4 | | 5.1.3.хүүхдийн гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэн дүрслэн зурах, урлан бүтээх, дуулж хөгжимдөх, бүжиглэх чадвар эзэмшихэд туслах; | Урлал, уран сайхан | |
| 5 | | 5.1.4.хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгаж, мэдээлэх чадвартай болох, ардын ёс заншлыг танин мэдэхэд нь туслах. | | Хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгаж, мэдээлэх чадвартай болох, ардын ёс заншлыг танин мэдэхэд |

*Эх сурвалж: Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого"*

***Хавсралт 2***

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024/, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2016, 2017, 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан зорилт, арга хэмжээний нийцэл, холбоог харьцуулсан судалгаа

| ***Тогтоол, шийдвэр*** | ***УИХ-ЫН 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 12 дугаар тогтоол*** | ***УИХ-ын 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоол*** | ***УИХ-ын 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоол*** | ***УИХ-ын 2015 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 52 дугаар тогтоол*** | ***УИХ-ын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 70 дугаар тогтоол*** | ***УИХ-ын 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 42 дугаар тогтоол*** | *Бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Тухайн жилийн Монгол Улсын Эдийн засаг,нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан арга хэмжээний нийцэл, уялдаа хангагдсан эсэх* |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***Баримт бичгийн нэр*** | *Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого* | *Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030* | *“Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр* | *Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай* | *Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай* | *Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай* | |
| ***Хэрэгжүүлэх хугацаа*** | *2014-2024 он* | *I үе шат (2016-2020): СӨБ-ын тогтолцооны төрөл хэлбэрийг өргөтгөж, хүртээмж, чанарыг сайжруулан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 70 хувийг хамруулах нөхцөл бүрдүүлэх.* | *2016-2020 он* | *2016 он* | *2017 он* | *2018 он* | |
| ***Стратеги зорилт, арга хэмжээ*** | *Гурав. Боловсролын хөгжлийн стратеги, удирдлага, зохион байгуулалт*<br><br>*3.2.Сургуулийн өмнөх боловсролыг “хүүхдийг сургах, сургуульд бэлтгэх” гэсэн зорилгоос илүүтэйгээр хүний хөгжлийн үндэс, өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжих, насан туршийн боловсролын суурь үе хэмээн хөгжүүлнэ.* | *2.2.3.Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн.*<br><br>***Зорилт 1:*** *Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшүүлнэ.* | *3.2.2.“Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлж хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгоно.* | *15.10. Хүүхдийн хөгжил, төлөвшлийг хангах зорилгоор “Зөв Монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх*<br><br>*Лабораторийн тоног төхөөрөмжөөр хангагдах сургуулийн тоо -125*<br><br>*-Улсын төсөв-1.0 тэрбум/төг*<br>*-Гадаад эх үүсвэр- 4.0 тэрбум*<br><br>*Хариуцах байгууллага-БСШУЯ* | *11.1. “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувийг нэмэгдүүлэх*<br><br>*Хамран сургалтын бохир жин, хувиар-79,2*<br><br>*Ашиглалтад оруулах цэцэрлэгийн тоо-12*<br><br>*Улсын төсөв-4.1 тэрбум/төг* | *10.1.Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх*<br>*Хамран сургалтын бохир жин, хувиар-82.0*<br>*Гадаад эх үүсвэр-12.3 тэрбум/төг*<br>*Хариуцах байгууллага-БСШУСЯ*<br>*10.6. Хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах зорилгоор 2018 оноос тодорхой мөнгө хуваарилах, гурван ээлжээр хичээллэж буй Ерөнхий боловсролын сургуулийн тоог бууруулахад шаардагдах хөрөнгийн асуудлыг судалгаанд үндэслэн үе шаттай шийдвэрлэх*<br>*Хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх ажлын явц, хувиар-100*<br>*Хариуцах байгууллага-БСШУСЯ*<br>*10.12.Сургууль, цэцэрлэгийн 80 хувиас дээш гүйцэтгэлтэй дутуу барилгын санхүүжилтийг* | *Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын 3.2-т “...хүний хөгжлийн үндэс, өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжих, насан туршийн боловсролын суурь үе хэмээн хөгжүүлнэ...”,*<br><br>*Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д тусгасан зорилт 1-т ...****монгол хэл, “сэтгэлгээний үндсийг эзэмшүүлнэ****...” талаарх зорилтыг* |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | *Хариуцах байгууллага-БСШУСЯ* | *шийдвэрлэж, ашиглалтад оруулах<br>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар-100<br>Хариуцах байгууллага-БСШУСЯ* | *хангахуйц арга хэмжээ тусгагдаагүй* |
| | | | *3.2.3.Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид шилжүүлнэ.* | *Цэцэрлэгийн ачааллыг бууруулах арга хэмжээ тусгагдаагүй* | *Цэцэрлэгийн ачааллыг бууруулах арга хэмжээ тусгагдаагүй* | *Цэцэрлэгийн ачааллыг бууруулах арга хэмжээ тусгагдаагүй* | *СӨБ олгох, үйлчилгээ үзүүлэх хүрээнд 2016-2018 онд Цэцэрлэгийн ачааллыг бууруулах арга хэмжээ тусгагдаагүй* |
| | *3.8.Боловсролын байгууллагад өмчийн хэлбэр харгалзахгүй адил тэгш шаардлага тавьж, хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлнэ.* | | *3.2.5.“Байгууллагын цэцэрлэг”-ийн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, татварын бодлогоор дэмжинэ.* | | *Шинээр байгуулах байгууллагын цэцэрлэгийн тоо-10<br>Гадаад эх үүсвэр-4.4 тэрбум/төг<br>Хариуцах байгууллага-“БСШУСЯ”* | *Арга хэмжээ тусгагдаагүй* | |
| | | | *3.2.7.Цэцэрлэг, сургуулийн орчин гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагчтай болгоно.* | *Арга хэмжээ тусгагдаагүй* | *Арга хэмжээ тусгагдаагүй* | *Арга хэмжээ тусгагдаагүй* | |
| | *3.18.Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ, дотоод мониторингийн тогтолцоог хөгжүүлнэ.* | | *3.2.9. Боловсролын түвшин, чиглэл тус бүрээр үнэлгээний систем, шалгуур, аргачлалыг хянан сайжруулж үйлчилгээний чанар, үр дүнг эцэг, эх, суралцагчдын оролцоотой үнэлэх боломжтой болгоно.* | *Арга хэмжээ тусгагдаагүй* | *Арга хэмжээ тусгагдаагүй* | *Арга хэмжээ тусгагдаагүй* | |
| | | | *3.2.15.Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд хүүхдийг хүнлэг, эх оронч, үндэсний ухамсар, бахархалтай иргэн болж төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, хүмүүжил олгох агуулгыг тусган хэрэгжүүлнэ.* | *Арга хэмжээ тусгагдаагүй* | *Арга хэмжээ тусгагдаагүй* | *Арга хэмжээ тусгагдаагүй* | |

*Эх сурвалж: Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024/, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 оны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2016 онд, 2017 онд,2018 онд  хөгжүүлэх үндсэн чиглэл*

## *Хавсралт 3*

Сургуулийн өмнөх, бага боловсролын хэлтсийн 2016, 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд СӨБ-ын чиглэлээр авч хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний судалгаа

| ***Үйл ажиллагааны төлөвлөгөөний огноо*** | ***Яамны төлөв лөгөөний дугаар*** | ***Ажил үйлчил гээний дугаар*** | ***Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ*** | ***СӨБ-ын бодлогын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй нийцэж, стратегийн зорилт, гол зорилтыг хангаж байгаа эсэх*** | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | *тэргүүлэх чиглэл* | *стратегийн зорилт* | *гол зорилт* |
| | | | | *Сургуулийн өмнөх боловсролын сургалтын чанарыг дээшлүүлэх,өрсөлдөх чадвартай хүний нөөц бэлтгэх, багш бэлтгэх тогтолцоог хөгжүүлэх* | *Боловсролын хөгжлийн бодлогын шинжилгээ хийх, хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар ханах* | *Сургуулийн өмнөх боловсролын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бодлогын шинжилгээ хийх, хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах,сургалтын агуулга,арга зүй, үнэлгээ,сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсронгуй болгох,салбарын удирдлага,зохион байгуулалтыг сайжруулж, хүний нөөцийг хөгжүүлэх, бодлогын хэрэгжилтийг хангахад зөвлөгөө,бүх талын дэмжлэг үзүүлэх, бодлогын удирдамжаар хангах.* |
| ***2016 он*** | *2.4.1.7* | *4* | *Сонсгол, хэл ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан дохионы хэлний зурагт гарын авлага, цахим DVD, ном, үзүүлэн тараах материалыг боловсруулж, хэвлүүлэх ажлыг зохион байгуулах.* | *сургалтын чанарыг дээшлүүлэх* | *хангаагүй* | *сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсронгуй болгох* |
| | *2.4.1.7* | *5* | *Цэцэрлэг, ЕБС, дотуур байранд хүүхдийн сурч хөгжих, аюулгүй орчныг бүрдүүлэх, улмаар газар хөдлөлт, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр "Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн цогц байдал" сэдэвт үндэсний чуулган зохион байгуулж, бодлогын зөвлөмж гаргана* | *сургалтын чанарыг дээшлүүлэх* | *бодлогын удирдамжаар ханах* | *бодлогын хэрэгжилтийг хангахад зөвлөгөө* |
| | *2.4.6.1* | *10* | *Нийслэлийн хэмжээнд цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтийг төрийн захиргааны болон арга зүйн удирдлагаар хангаж ажиллах /хувийн хэвшил,байгууллагын цэцэрлэг, өргөтгөл, бусад/* | *сургалтын чанарыг дээшлүүлэх* | *бодлогын удирдамжаар ханах* | *бодлогын хэрэгжилтийг хангахад зөвлөгөө,* |
| ***2017 он*** | *1.2* | *2* | *Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулна.* | *сургалтын чанарыг дээшлүүлэх* | *хууль тогтоомжийн төсөл,* | *хууль тогтоомжийн төсөл,* |
| | *4.6* | *3* | *Төрийн өмчийн цэцэрлэгт хүүхдийн хоолны зардлыг төрөөс болон эцэг эх, асран хамгаалагчаас хариуцах хувь хэмжээг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, батлуулна.* | *сургалтын чанарыг дээшлүүлэх* | *хууль тогтоомжийн төсөл, бодлогын удирдамжаар ханах* | *хууль тогтоомжийн төсөл, бодлогын хэрэгжилтийг хангахад зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх, бодлогын удирдамжаар хангах.* |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 11.16 | 8 | “Цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулна | | бодлогын удирдамжаар ханах | бодлогын удирдамжаар хангах. |
| | 11.17 | 9 | “Цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулна | | бодлогын удирдамжаар ханах | бодлогын удирдамжаар хангах. |
| | 15.24 | 14 | Бага, дунд боловсролын суралцагчийн үнэлгээний журмыг шинэчлэн боловсруулна | нийцээгүй | СӨБ олгох стратеги зорилттой нийцээгүй | СӨБ олгох гол зорилтыг хангаагүй |
| | 17.26 | 16 | Боловсролын стандарт, сургалтын цөм хөтөлбөр, сурах бичигт үнэлгээ, дүгнэлт хийж, шинэчлэх бодлого, чиглэлийг тодорхойлон, төлөвлөгөөг батлуулна /Монгол хэл, түүх, эрүүл мэнд, биеийн тамир, эх орноо хайрлах, хүрээлэн байгаа орчноо хамгаалах/ | Сургуулийн өмнөх боловсролын сургалтын чанарыг дээшлүүлэх, | бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар ханах | бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах,сургалтын агуулга,арга зүй, үнэлгээ, бодлогын удирдамжаар хангах. |
| | 44.58 | 18 | “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны ерөнхий шаардлага”-ын хэрэгжилтийг хангах чиглэлээр боловсролын удирдах ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | өрсөлдөх чадвартай хүний нөөц бэлтгэх, багш бэлтгэх тогтолцоог хөгжүүлэх | бодлогын удирдамжаар ханах | салбарын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулж, хүний нөөцийг хөгжүүлэх, бодлогын хэрэгжилтийг хангахад зөвлөгөө |
| | 46.61 | 21 | “Сургуулийн өмнөх боловсролын чанар” бодлогын форум зохион байгуулна. | Сургуулийн өмнөх боловсролын сургалтын чанарыг дээшлүүлэх, | бодлогын удирдамжаар ханах | сургалтын агуулга,арга зүй, үнэлгээ,сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсронгуй болгох, |
| | 49.65 | 25 | Бага боловсролын түвшинд сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа хийнэ. | нийцээгүй | СӨБ олгох стратеги зорилттой нийцээгүй | СӨБ олгох гол зорилтыг хангаагүй |

Эх сурвалж: Сургуулийн өмнөх, бага боловсролын хэлтсийн 2016 он, 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө

**_Хавсралт 4_**

БСШУСЯ-ны сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтнүүдийн судалгаа /2016-2018 он/

| | *2016 он /VIII сараас хойш/* | | *2017 он* | | *2018 он* | |
|---|---|---|---|---|---|---|
| | *Сургуулийн өмнөх, бага боловсролын хэлтэс* | | *Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар* | | *Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар* | |
| *1* | *Хэлтсийн дарга /үүрэг гүйцэтгэгч/* | *Ж.Мягмар* | *Газрын дарга /үүрэг гүйцэтгэгч/* | *С.Болормаа* | *Газрын даргын /үүрэг гүйцэтгэгч/* | *Г.Дуламжав* |
| *2* | *Хүүхдийн хоол, хүнсний хангамжийн бодлого, төлөвлөлт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн /түр/* | *Б.Дуламханд* | *Сургуулийн өмнөх боловсролын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн* | *Л.Отгонсүрэн* | *Сургуулийн өмнөх боловсролын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн* | *Л.Отгонсүрэн* |
| *3* | *Сургуулийн өмнөх болон бага боловсролын агуулга, стандарт, хөтөлбөр, үнэлгээний бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн* | *Ч.Ганцэцэг* | *Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, хүний нөөц, чанарын үнэлгээний бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн* | *Г.Амирда* | *Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, хүний нөөц, чанарын үнэлгээний бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн* | *Г.Амирда /Ө.Ганболд/* |
| *4* | *Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар* | | *Сургуулийн өмнөх боловсролын агуулга, стандарт, хөтөлбөрийн бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн* | *Н.Оюунбат* | *Сургуулийн өмнөх боловсролын агуулга, стандарт, хөтөлбөрийн бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн* | *Н.Оюунбат* |
| | *Сургуулийн өмнөх боловсролын агуулга, стандарт, хөтөлбөрийн бодлогын хэрэгжилт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн /түр/* | *Ц.Цэндмаа* | | | | |
| *5* | *Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар* | | *Хүүхдийн хөгжил, төлөвшил, хамгааллын бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн /түр/* | *У.Сэлэнгэ* | *Хүүхдийн хөгжил, төлөвшил, хамгааллын бодлого, хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн* | *С.Болормаа* |
| | *Сургуулийн өмнөх, бага боловсролын чанарын үнэлгээ, суралцагчийн эрх, хөгжил, төлөвшил, хамгааллын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн* | *Ш. Сарантуяа* | | | | |
| *6* | | | *Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмж, хэрэглэгдэхүүн, орчны аюулгүй байдлын бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн* | *Ө. Ганболд* | | |

*Эх сурвалж: БСШУСЯ*

### Хавсралт 5

Улсын төсвийн хөрөнгөөр 2016-2018 онд хэрэгжихээр төлөвлөгдсөн боловч хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ /сая төгрөг/

| № | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Эхлэх | Дуусах | Төсөвт өртөг | Санхүүжих дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас олгосон буцалтгүй тусламжийн монголын талын хөрөнгө /1 цэцэрлэг, 21 сургууль/ | 2016 | 2017 | 1,000.0 | 200.0 |
| 2 | Сургууль, цэцэрлэг /Улаанбаатар, Сонгинохайрхан/ | 2012 | 2016 | 1,380.0 | 140.5 |
| 3 | Цэцэрлэгийн барилга, 100 ор /Сэлэнгэ, Мандал сум/ | 2012 | 2018 | 771.2 | 93.0 |
| 4 | Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих 240 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 13 дугаар цэцэрлэг/ | 2018 | 2019 | 2,500.0 | 800.0 |
| 5 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 240 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 66 дугаар цэцэрлэг/ | 2018 | 2019 | 2,500.0 | 800.0 |
| 6 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 240 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 125 дугаар цэцэрлэг/ | 2018 | 2019 | 2,500.0 | 800.0 |
| 7 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 11 дүгээр хороо/ | 2018 | 2019 | 1,500.0 | 700.0 |
| 8 | Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих 280 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 10 дугаар хороо/ | 2018 | 2019 | 1,500.0 | 700.0 |
| 9 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 23 дугаар хороо/ | 2018 | 2019 | 1,500.0 | 700.0 |
| 10 | Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 21 дүгээр хороо/ | 2018 | 2019 | 2,200.0 | 1,000.0 |
| 11 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 4 дүгээр цэцэрлэг/ | 2018 | 2019 | 1,800.0 | 900.0 |
| 12 | Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Бугат сум/ | 2018 | 2019 | 600.0 | 300.0 |
| 13 | Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо, Гандангийн дэнж/ | 2018 | 2019 | 2,000.0 | 1,000.0 |
| 14 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 14 дүгээр хороо/ | 2018 | 2019 | 1,500.0 | 1,000.0 |
| 15 | Цэцэрлэгийн барилга худалдан авах, 150 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо/ | 2018 | 2018 | 1,285.0 | - |
| 16 | Цэцэрлэгийн барилга, 200 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 16 дугаар хороо/ | 2018 | 2019 | 1,500.0 | 750.0 |
| | **НИЙТ ДҮН** | | | **26,036.2** | **9,883.5** |

*Эх сурвалж: Сангийн яам*

### Хавсралт 6

Хөтөлбөрийн хүүхдийн ахиц, хөгжлийн үнэлгээний харьцуулалт

| | Чадвар | Цөм хөтөлбөрийн хүүхдийн ахицыг үнэлэх ажиглалтын хуудас | | Сайжруулсан хөтөлбөрийн хүүхдийн хөгжлийн үнэлгээний хуудас | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | I түвшин | II, III Түвшин | I түвшин | II Түвшин | III түвшин |
| **1** | **Нийгэмшихүйн чадвар** | **8** | **23** | **12** | **12** | **12** |
| | Зан чанар | | 9 | | | |
| | Сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх, удирдах | | 5 | | | |
| | Бусадтай харилцах | | 9 | | | |
| **2** | **Оюун ухааны чадвар** | **9** | **-** | **-** | **-** | **-** |
| **3** | **Хөдөлгөөн эрүүл мэнд** | **12** | **28** | **9** | **9** | **9** |
| | Биеийн хөдөлгөөнөө удирдах | 12 | 13 | | | |
| | Гар хурууны хөдөлгөөнөө зохицуулах | | 7 | | | |
| | Эрүүл мэндээ хамгаалах | | 8 | | | |
| **4** | **Хэл яриа** | **-** | **19** | **7** | **7** | **7** |
| | Сонсох, ойлгох | | 6 | | | |
| | Ярих | | 7 | | | |
| | Унших, бичих бэлтгэх | | 6 | | | |
| **5** | **Байгаль, нийгмийн орчин** | **-** | **10** | **4** | **4** | **4** |
| | Орчноо шинжлэн судлах | | 5 | | | |
| | Орчинтойгоо харьцах | | 5 | | | |
| **6** | **Математикийн энгийн төсөөлөл** | **-** | **14** | **5** | **5** | **5** |
| | Тоолох | | 6 | | | |
| | Хэмжих | | 8 | | | |
| **7** | **Хөгжим, дүрслэх урлаг** | **-** | **20** | **8** | **8** | **8** |
| | Зурах | | 6 | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | *Урлах* | | *6* | | | |
| | *Дуулах хөгжимдөх* | | *5* | | | |
| | *Бүжиглэх, жүжиглэх* | | *3* | | | |
| | ***Нийт*** | ***28*** | ***114*** | ***45*** | ***45*** | ***45*** |

*Эх сурвалж: Сургалтын цөм хөтөлбөр, сайжруулсан сургалтын хөтөлбөр*

**Хавсралт 7**

2017-2019 онд төгссөн СӨБ-ын багш нарын дипломын хавсралт дах судалсан хичээлийн харьцуулалт

*/кредит цаг/*

| | ***Хичээлийн нэр*** | ***МУБИС СӨБС /2018/*** | ***ХИС-ын БӨ аймаг дахь салбар /2017/*** | ***Сэрүүлэг ИС /2018/*** | ***Гурван Эрдэнэ ДС /2017/*** | ***Газарчин ДС /2017/*** | ***НСС ДС /2019/*** |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | *Сэтгэлгээний түүх соёл* | 2 | | 3 | 2 | | |
| 2 | *Англи хэл* | 6 | 8 | 11 | 6 | 12 | 8 |
| 3 | *Орос хэл* | | 3 | | | | |
| 4 | *Солонгос хэл* | | | | | | 8 |
| 5 | *Биеийн тамир* | 2 | 3 | | | 3 | 2 |
| 6 | *Монгол хэл бичиг, найруулга зүй /Монгол бичиг/* | 3 | 2 | 3 | | 6 | 3 |
| 7 | *Мэдээлэл харилцааны технологи* | 2 | 3 | 3 | 3 | 3 | 3 |
| 8 | *Хэрэглээний программчлал* | | | | 3 | | |
| 9 | *Статистикийн онол* | | | | 2 | | |
| 10 | *Монголын түүх, соёл* | 3 | 3 | 3 | | 3 | 2 |
| 11 | *Эрх зүй / Боловсролын эрх зүй* | 2 | | 1 | 3 | 3 | |
| 12 | *Улс төр судлал* | 2 | | | 2 | | 2 |
| 13 | *Бүтээлч сэтгэлгээ* | 1 | | 3 | | | |
| 14 | *Гамшигийн менежмент* | 1 | | | | | 1 |
| 15 | *Философийн үндэс* | | 3 | | | 3 | 2 |
| 16 | *Эдийн засгийн онолын үндэс* | | 3 | | 6 | | |
| 17 | *Маркетингийн үндэс* | | | | 2.5 | | |
| 18 | *Менежментийн үндэс* | | | | 2.5 | | |
| 19 | *Математикийн онолын үндэс* | | 2 | | | | |
| 20 | *Эрүүл мэндийн боловсрол* | | 1 | | | 1 | |
| 21 | *Хүүхдийн сэтгэл судлал* | 3 | 6 | 3 | 4 | 5 | 3 |
| 22 | *Багш мэргэжлийн удиртгал* | 1 | 1 | | | | |
| 23 | *Хүний хөгжлийн сэтгэл судлал* | 2 | | 3 | 2 | 6 | 2 |
| 24 | *Суралцахуй ба багшлахуйн үндэс* | 3 | | | | | |
| 25 | *Хүний хөгжил, харилцааны ёс зүй эрх зүй* | | | 6 | 2 | | |
| 26 | *Судалгааны арга зүй* | 2 | | | | 2 | 2 |
| 27 | *Боловсролын сэтгэл судлал* | 4 | 2 | | 3 | | 3 |
| 28 | *Сургалтын онол, арга зүй* | 2 | | | | | |
| 29 | *Сурган хүмүүжүүлэх зүй* | | 2 | 3 | 3 | 3 | 3 |
| 30 | *Хүүхдийн сурган хүмүүжүүлэх зүй* | 3 | 6 | 3 | 4 | 6 | 4 |
| 31 | *Ажиглах дадлага* | | 1 | 2 | | 3 | |
| 32 | *Танилцах дадлага* | 1 | 2 | | | | 2 |
| 33 | *Судлах дадлага* | 3 | | | | | |
| 34 | *Дагалдан суралцах дадлага* | 3 | | | | | |
| 35 | *Туршин заах дадлага* | 3 | | | | 4 | 4 |
| 36 | *Багшлах дадлага* | 4 | 3 | 2 | 15 | 5 | 4 |
| 37 | *Мэргэшүүлэх дадлага* | | | 2 | | | |
| 38 | *Удирдах дадлага* | | | | | | 4 |
| 39 | *Хүүхдийн бие бялдрын хөгжил* | 2 | | | | | |
| 40 | *Хүүхдийн хэл ярианы хөгжил* | 2 | | 3 | | | |
| 41 | *Хүүхдийн эрүүл ахуй, асаргаа* | 3 | 2 | 3 | 2 | | 2 |
| 42 | *Хүүхдийн уран зохиол* | 2 | 3 | 3 | 4 | 3 | 3 |
| 43 | *Хүүхдийн математик төсөөллийн хөгжил* | 2 | | | | | |
| 44 | *Хүүхдийн дүрслэн урлахуйн хөгжил* | 2 | 2 | 3 | | 2 | |
| 45 | *Хөгжмийн боловсрол* | 2 | | 3 | 4 | | 3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 46 | Уран уншлага | 2 | 5 | | | | |
| 47 | Монгол уламжлалт сургалт, боловсрол /судлал/ | 2 | | | | | 2 |
| 48 | Тоглонгоо суралцахуйн онол, арга зүй | 2 | | 4 | | | |
| 49 | Байгаль орчинтой танилцах арга зүй | 3 | 3 | | 4 | 4 | 4 |
| 50 | Хөгжимт хөдөлгөөнийг хөгжүүлэх арга зүй | 2 | 3 | 3 | 6 | 3 | 2 |
| 51 | Тусгай хэрэгцээт боловсрол | 2 | 2 | 3 | 2 | 2 | 2 |
| 52 | Цэцэрлэгийн сургалтын орчин | 2 | | 3 | | | |
| 53 | Цэцэрлэгийн сургалтын хөтөлбөр | 2 | | | | | 2 |
| 54 | Хүүхдийн хөгжлийн ажиглалт, үнэлгээ | 2 | | 3 | | | |
| 55 | Найрал дуу | 1 | | | | | |
| 56 | Эцэг, эхийн оролцоог дэмжих арга зүй | 2 | 2 | 3 | 2 | 2 | 2 |
| 57 | Цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх арга зүй | 2 | 2 | | 4 | | |
| 58 | Үйлийн судалгаа | 2 | | | | | |
| 59 | Бие бялдрыг хөгжүүлэх арга зүй | 1 | 4 | 4 | 3 | 4 | 4 |
| 60 | Хэрэглэгчний сэтгэл судлал /харилцааны/ | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 |
| 61 | Математик төсөөллийг хөгжүүлэх арга зүй | 2 | 8 | 7 | 4 | 7 | 6 |
| 62 | Бүжиглэх ур чадвар | 2 | | | | | |
| 63 | Дүрслэн урлахуйг хөгжүүлэх арга зүй | 3 | 5 | 4 | 4 | 7 | 6 |
| 64 | Хүүхдийн дуу хөгжим | 3 | 5 | | 3 | 4 | |
| 65 | Хэл яриаг хөгжүүлэх арга зүй | 2 | 8 | 3 | 4 | 7 | 6 |
| 66 | Зураг, урлал | 2 | | | | | |
| 67 | Хөгжмийн боловсролын онол, арга зүй | 3 | 3 | 3 | | 4 | 2 |
| 68 | Хэл засал | 2 | | | | | |
| 69 | Хүүхдийн анатоми, физиологи | | 2 | 3 | 4 | 3 | 2 |
| 70 | Хүүхдийн хоол тэжээл, эрүүл ахуй | | 2 | | | 3 | 2 |
| 71 | Экологи, байгаль хамгаалал | | 2 | 3 | | | 2 |
| 72 | Сургуулийн өмнөх боловсролын удирдлага | | 2 | | 4 | 3 | 2 |
| 73 | Амжилтад хөтлөх ур чадвар | | | | | | 3 |
| 74 | Цахим сургалтын арга зүй | | | 3 | | | |
| 75 | Курсын ажил | | | 2 | | | |
| 76 | Сургуулийн өмнөх боловсролын технологи | | | | 6 | | |
| **Нийт хичээл судалсан багц цаг** | | **121** | **121** | **120** | **127** | **128** | **121** |

*Эх сурвалж: Түүвэрт хамрагдсан цэцэрлэгүүдийн багш нарын дээд боловсролын дипломууд*
*Жич: Зарим хичээлийг дүйцүүлэн нэгтгэсэн болно.*
*Тухайн хичээл байхгүй*

## *Хавсралт 8*

2016-2019 оны хичээлийн жилд төрийн болон хувийн их дээд сургуульд СӨБ-ын багш мэргэжлээр суралцагчдын судалгаа /суралцагсдын тоо/

| **№** | **Сургуулийн нэр** | **2016-2017 оны хичээлийн жилийн суралцагчийн тоо** | | | **2017-2018 оны хичээлийн жилийн суралцагчийн тоо** | | | **2018-2019 оны хичээлийн жилийн суралцагчийн тоо** | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Төрийн өмчийн их дээд сургууль** | | **Нийт** | **Шинээр элссэн** | **Төгсөх анги** | **Нийт** | **Шинээр элссэн** | **Төгсөх анги** | **Нийт** | **Шинээр элссэн** | **Төгсөх анги** |
| 1 | МУБИС СӨБС | 1389 | 374 | 335 | 1454 | 396 | 364 | 1190 | 240 | 351 |
| 2 | МУБИС СӨБС аргазүй | 49 | 8 | 47 | 68 | 7 | 32 | 127 | 19 | 66 |
| 3 | МУБИС тусгай хэрэгцээт | 56 | 0 | 23 | 62 | 29 | 0 | 108 | 31 | 9 |
| 4 | Ховд ИС | 172 | 68 | 65 | 167 | 60 | 49 | 196 | 78 | 74 |
| 5 | Архангай МУБИС | 416 | 85 | 275 | 275 | 89 | 113 | 296 | 113 | 72 |
| 6 | Баян-Өлгий БС | 132 | 52 | 52 | 109 | 30 | 42 | 99 | 30 | 38 |
| 7 | Дорнод ИС | 111 | 17 | 36 | 86 | 15 | 35 | 45 | 7 | 18 |
| **Хувийн их дээд сургууль** | | | | | | | | | | |
| 1 | Аварга ДС | 10 | 10 | 0 | 4 | 2 | 0 | 6 | 1 | 0 |
| 2 | Гурван эрдэнэ БДС | 158 | 15 | 68 | 121 | 9 | 82 | 60 | 12 | 22 |
| 3 | Дархан ДС | 201 | 33 | 92 | МУБИС-д нэгдсэн | | | 116 | 28 | 37 |
| 4 | Сити ДС | 77 | 37 | 108 | 55 | 20 | 0 | 110 | 49 | 25 |
| 5 | Хүмүүнлэг Дархан | 67 | 15 | 0 | 71 | 9 | 32 | 94 | 47 | 23 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | *Этүгэн ИС* | *0* | *0* | *0* | *2* | *2* | *0* | *4* | *3* | *0* |
| 7 | *Газарчин ДС* | *173* | *54* | *40* | *329* | *121* | *85* | *342* | *90* | *82* |
| 8 | *Засагт хан ДС* | *47* | *37* | *0* | *60* | *14* | *0* | *190* | *51* | *61* |
| 9 | *Зохиомж ДС* | *243* | *65* | *70* | *209* | *36* | *94* | *145* | *32* | *70* |
| 10 | *Их Засаг ИС* | *0* | *0* | *0* | *16* | *16* | *0* | *14* | *14* | *0* |
| 11 | *Маргад ДС* | *240* | *80* | *83* | *158* | *33* | *64* | *47* | *12* | *14* |
| 12 | *МҮИС* | *81* | *81* | *0* | *105* | *24* | | *150* | *36* | *0* |
| 13 | *НССДС* | *0* | *0* | *0* | *20* | *6* | *0* | *23* | *2* | *9* |
| 14 | *Орхон ИС* | *60* | *6* | *31* | *41* | *6* | *26* | *20* | *6* | *0* |
| 15 | *Отгонтэнгэр ИС* | *183* | *56* | *91* | *154* | *59* | *65* | *72* | *34* | *6* |
| 16 | *Сэрүүлэг ИС* | *340* | *18* | *86* | *392* | *0* | *152* | *147* | *33* | *59* |
| 17 | *ТДС* | *16* | *16* | *0* | *16* | *9* | *0* | *31* | *6* | *0* |
| 18 | *Улаанбаатар эрдэм ИС* | *173* | *65* | *18* | *246* | *0* | *21* | *332* | *97* | *72* |
| 19 | *Хангай ДС* | *20* | *8* | *0* | *27* | *5* | *7* | *16* | *0* | *10* |
| 20 | *ХИДС* | *20* | *20* | *0* | *17* | *5* | *0* | *9* | *0* | *0* |
| 21 | *Чингис хаан ДС* | *24* | *3* | *0* | *24* | *3* | *20* | *12* | *4* | *4* |
| 22 | *ЭЗҮДС* | *0* | *0* | *0* | *0* | *0* | *0* | *68* | *12* | *26* |
| 23 | *Энх-Орчлон ДС* | *15* | *8* | *0* | *0* | *0* | *0* | *0* | *0* | *0* |
| 24 | *Нийгмийн ухааны ДС* | *0* | *0* | *0* | *6* | *0* | *2* | *0* | *0* | *0* |
| | ***Нийт дүн*** | ***4473*** | ***1231*** | ***1520*** | ***4294*** | ***1005*** | ***1285*** | ***4069*** | ***1087*** | ***1148*** |

*Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик мэдээ*

**_Хавсралт 9_**

Тусгай зориулалтын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

| № | Аймаг, нийслэл | 2016 он | | | 2017 он | | | 2018 он | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэмнэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэмнэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хэмнэлт |
| 1 | Архангай | 7,913.9 | 7,853.4 | 60.5 | 8,120.1 | 8,110.7 | 9.4 | 8,745.0 | 8,719.1 | 25.9 |
| 2 | Баян-Өлгий | 9,057.8 | 9,047.5 | 10.3 | 9,402.4 | 9,402.2 | 0.2 | 9,801.3 | 9,798.1 | 3.2 |
| 3 | Баянхонгор | 8,261.4 | 8,003.4 | 258.0 | 8,863.8 | 8,858.8 | 5.0 | 9,495.0 | 9,445.1 | 49.9 |
| 4 | Булган | 6,049.7 | 5,507.7 | 542.0 | 6,193.2 | 6,193.2 | 0.0 | 6,814.8 | 6,759.0 | 55.8 |
| 5 | Говь-Алтай | 6,119.3 | 5,877.3 | 242.0 | 6,341.8 | 6,341.8 | 0.0 | 6,490.7 | 6,444.5 | 46.2 |
| 6 | Дорнод | 6,808.0 | 6,784.5 | 23.5 | 7,195.1 | 7,170.2 | 24.9 | 7,596.6 | 7,529.1 | 67.5 |
| 7 | Дорноговь | 8,443.7 | 8,294.6 | 149.1 | 8,445.4 | 8,442.8 | 2.6 | 8,883.7 | 8,879.1 | 4.6 |
| 8 | Дундговь | 4,645.8 | 4,628.1 | 17.7 | 5,012.8 | 5,004.9 | 7.9 | 5,177.9 | 5,177.9 | 0.0 |
| 9 | Завхан | 7,743.9 | 7,743.8 | 0.1 | 8,074.3 | 8,074.3 | 0.0 | 8,613.4 | 8,581.3 | 32.1 |
| 10 | Өвөрхангай | 8,649.6 | 8,649.6 | 0.0 | 8,989.4 | 8,989.4 | 0.0 | 9,535.7 | 9,531.8 | 3.9 |
| 11 | Өмнөговь | 7,058.6 | 7,040.8 | 17.8 | 7,074.9 | 7,073.9 | 1.0 | 7,512.7 | 7,288.6 | 224.1 |
| 12 | Сүхбаатар | 7,071.8 | 7,057.4 | 14.4 | 7,436.6 | 7,421.3 | 15.3 | 7,870.0 | 7,750.9 | 119.1 |
| 13 | Сэлэнгэ | 11,175.8 | 11,033.6 | 142.2 | 11,863.3 | 11,862.7 | 0.6 | 12,083.1 | 12,077.3 | 5.8 |
| 14 | Төв | 8,768.7 | 8,679.3 | 89.4 | 9,198.1 | 9,100.0 | 98.1 | 9,419.3 | 9,343.0 | 76.3 |
| 15 | Увс | 6,919.9 | 6,837.0 | 82.9 | 7,134.5 | 7,112.9 | 21.6 | 7,543.3 | 7,505.7 | 37.6 |
| 16 | Ховд | 7,699.8 | 7,699.8 | 0.0 | 8,220.5 | 8,220.5 | 0.0 | 8,739.9 | 8,709.9 | 30.0 |
| 17 | Хөвсгөл | 11,186.5 | 11,098.7 | 87.8 | 11,752.3 | 11,749.8 | 2.5 | 12,341.6 | 12,328.2 | 13.4 |
| 18 | Хэнтий | 8,544.3 | 8,501.2 | 43.1 | 8,715.4 | 8,691.6 | 23.8 | 8,870.8 | 8,825.8 | 45.0 |
| 19 | Дархан-Уул | 9,581.9 | 9,475.1 | 106.8 | 9,881.5 | 9,868.9 | 12.6 | 10,304.0 | 10,285.5 | 18.5 |
| 20 | Улаанбаатар | 103,753.3 | 102,782.4 | 970.9 | 112,995.9 | 112,796.2 | 199.7 | 131,199.6 | 128,841.3 | 2,358.3 |
| 21 | Орхон | 11,044.3 | 10,822.6 | 221.7 | 11,570.7 | 11,527.7 | 43.0 | 12,242.2 | 12,190.1 | 52.1 |
| 22 | Говь-Сүмбэр | 1,798.1 | 1,767.5 | 30.6 | 1,853.1 | 1,738.6 | 114.5 | 1,987.2 | 1,968.9 | 18.3 |
| | Нийт | 268,296.1 | 265,185.1 | 3,111.0 | 284,335.1 | 283,752.3 | 582.8 | 311,267.4 | 307,979.9 | 3,287.5 |

*Эх сурвалж: Хүнс нийлүүлэгч компаниудын санхүүгийн тайлан*

**Хавсралт 10**

Төрийн өмчийн цэцэрлэгүүдийн зардлын зарцуулалт (зардлын зүйлээр, сая төгрөгөөр)

| № | Зардлын нэр | 2016 он | | | 2017 он | | | 2018 он | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төлөв-лөгөө | Гүйцэтгэл | Хувь | Төлөв-лөгөө | Гүйцэтгэл | Хувь | Төлөв-лөгөө | Гүйцэтгэл | Хувь |
| 1 | Цалин хөлс, нэмэгдэл урамшил НДШ | 163,525.9 | 161,082.6 | 98.5 | 170,617.7 | 170,232.9 | 99.8 | 188,887.0 | 186,512.0 | 98.7 |
| 2 | Хоол, хүнс | 45,581.9 | 44,684.5 | 98.0 | 46,260.2 | 46,137.3 | 99.7 | 47,744.1 | 47,257.4 | 99.0 |
| 3 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 24,514.6 | 23,976.4 | 97.8 | 24,730.7 | 24,566.9 | 99.3 | 27,397.3 | 26,830.4 | 97.9 |
| 4 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,892.3 | 2,895.3 | 100.1 | 3,232.7 | 3,239.6 | 100.2 | 4,946.4 | 4,949.3 | 100.1 |
| 5 | Хангамж, бараа материалын зардал | 2,804.3 | 2,836.9 | 101.2 | 3,217.9 | 3,255.4 | 101.2 | 3,588.7 | 3,589.0 | 100.0 |
| 6 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,914.3 | 1,788.6 | 93.4 | 1,989.5 | 1,938.3 | 97.4 | 2,546.6 | 2,491.7 | 97.8 |
| 7 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,043.3 | 2,084.5 | 102.0 | 1,936.6 | 1,954.2 | 100.9 | 2,394.6 | 2,455.7 | 102.6 |
| 8 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 730.2 | 704.1 | 96.4 | 599.3 | 595.4 | 99.3 | 838.9 | 817.1 | 97.4 |
| 9 | Томилолт, зочны зардал | 132.8 | 126.1 | 95.0 | 130.5 | 124.5 | 95.5 | 157.2 | 148.0 | 94.1 |
| | Нийт | 244,139.5 | 240,179.0 | 98.4 | 252,715.1 | 252,044.5 | 99.7 | 278,500.8 | 275,050.4 | 98.8 |

*Эх сурвалж: Сангийн яам*

**Хавсралт 11**

Нийслэлийн төрийн өмчийн цэцэрлэгүүдэд хүнс нийлүүлэгч компаниудын үйл ажиллагааны үзүүлэлтүүд (сая төгрөгөөр)

| № | Байгууллага | Үзүүлэлт | 2016 он | | 2017 он | | 2018 он | | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| 1 | "Хүнс хангамж" ОНӨААТҮГ | Борлуулалтын орлого | 3,982.2 | 4,098.1 | 4,238.9 | 4,641.4 | 4,654.5 | 4,844.8 | 13,584.2 |
| | | Борлуулалтын өртөг | 3,659.6 | 379.4 | 3,899.8 | 4,235.9 | 4,123.9 | 4,410.3 | 9,025.6 |
| | | Үйл ажиллагааны зардал | 296.7 | 297.8 | 306.1 | 335.3 | 450.5 | 399.6 | 1,032.7 |
| | | Тайлант үеийн цэвэр ашиг | 14.2 | 3.8 | 25.1 | 57.6 | 61.8 | (4.8) | 56.7 |
| | | Ногдол ашиг | - | 3.8 | - | 51.9 | - | - | 55.7 |
| 2 | "Өсөөр үе" ОНӨААТҮГ | Борлуулалтын орлого | 4,932.8 | 5,392.9 | 5,582.9 | 5,777.9 | 5,943.0 | 6,068.3 | 17,239.0 |
| | | Борлуулалтын өртөг | 4,907.2 | 5,001.1 | 5,524.2 | 5,645.7 | 5,841.6 | 5,578.7 | 16,225.6 |
| | | Үйл ажиллагааны зардал | 337.3 | 309.3 | 381.2 | 359.1 | 444.5 | 404.5 | 1,072.8 |
| | | Тайлант үеийн цэвэр ашиг | 25.6 | 72.0 | 51.9 | 130.9 | 90.1 | 75.1 | 278.1 |
| | | Ногдол ашиг | - | 14.4 | - | 130.9 | - | 37.6 | 182.9 |
| 3 | "Багачууд Хүнс" ОНӨААТҮГ | Борлуулалтын орлого | 3,546.1 | 3,522.9 | 3,654.7 | 3,852.9 | 4,096.9 | 3,745.8 | 11,121.6 |
| | | Борлуулалтын өртөг | 3,515.3 | 3,112.3 | 3,604.9 | 3,344.8 | 4,029.8 | 3,280.7 | 9,737.8 |
| | | Үйл ажиллагааны зардал | 317.7 | 329.8 | 479.3 | 343.6 | 554.4 | 412.3 | 1,085.8 |
| | | Тайлант үеийн цэвэр ашиг | 30.8 | 37.0 | 49.8 | 127.8 | 67.1 | 7.8 | 172.6 |
| | | Ногдол ашиг | - | 22.8 | - | 66.1 | - | 6.5 | 95.4 |
| 4 | "Асгат" ОНӨААТҮГ | Борлуулалтын орлого | 3,423.3 | 3,422.5 | 3,307.0 | 3,718.9 | 3,370.9 | 3,847.9 | 10,989.2 |
| | | Борлуулалтын өртөг | 3,393.3 | 3,039.9 | 3,274.5 | 3,299.2 | 3,339.9 | 3,436.7 | 9,775.8 |
| | | Үйл ажиллагааны зардал | 406.3 | 397.2 | 444.4 | 432.0 | 506.4 | 420.9 | 1,250.1 |
| | | Тайлант үеийн цэвэр ашиг | 25.8 | 27.5 | 27.7 | 34.2 | 26.5 | 32.4 | 94.1 |
| | | Ногдол ашиг | - | 5.5 | - | 30.8 | - | 16.2 | 52.5 |

*Эх сурвалж: Хүнс нийлүүлэгч компаниудын санхүүгийн тайлан*

**Хавсралт 12**

БСШУСЯ-аас Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, хэрэгжилтэд хийсэн үнэлгээ

| ЗГҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Нийт хөрөнгийн хэмжээ /сая.төгрөг/ | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн, хэрэгжилтийн хувийг үнэлж тайлагнасан | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2016 он | | 2017 он | | 2018 он | |
| | | | | | | Хүрсэн түвшин | хувь | Хүрсэн түвшин | хувь | Хүрсэн түвшин | хувь |
| 3.2.2. "Хүүхэд бүр цэцэрлэгт" хөтөлбөрийг хэрэгжүүлж хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгоно. | 1 | Цэцэрлэг барих төр, орон нутгийн болон олон улсын тусламжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх | 2016-2020 | Нийт 57,077.0 үүнээс<br><br>2017 онд 32,286.0<br><br>2018 онд 13,031.0<br><br>2019 онд 11,760.0 | СӨБ-д хамрагдаагүй хүүхдийн тоог 2017 онд 7 хувиар, 2018 онд 29 хувиар, 2019 онд 26 хувиар тус тус буурах | 2015 онд цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийг суурь болгож тайлагнаагүй, нийслэлийн хэмжээнд цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоог 12609-өөр нэмэгдүүлсэн байна. | үнэлээгүй | 2017 онд улсын төсөв, концессын гэрээ, олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтаар 3,570 хүүхдийн хүчин чадал бүхий 29,584 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 цэцэрлэгийн барилгыг шинээр ашиглалтад оруулсан гэж тайлагнасан ч 2017 онд цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийн тоог 7 хувиар буурах гэсэн зорилгоо хангасан эсэхийг бүрэн тайлагнаагүй, | хүрсэн түвшнийг хангасан эсэх нь тодорхойгүй байхад 100% -р үнэлсэн | 2016-2020 онд цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийн тоо 27 хувиар буурсан гэж тайлагнасан ч хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаагүй. | Хүрсэн түвшнийг бүрэн хангаагүй байхад 100%-р үнэлсэн |
| | 2 | Хөдөө орон нутагт малчдын хүүхдэд зориулсан гэр цэцэрлэгийн тоог өсгөх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх | 2017-2020 | Нийт 2,000.0<br><br>2017 онд 500.0<br><br>2018 онд 500.0<br><br>2019 онд 500.0<br><br>2020 онд 500.0 | Жил бүр 50 гэр цэцэрлэг нийлүүлэх, малчны нийт 1000 хүүхдийг хамруулах | | | 2016 -2017 оны хичээлийн жилд 70 гэр цэцэрлэгийг нийлүүлж, малчны болон эмзэг бүлгийн өрхийн 1500 хүүхдийг хамруулсан гэж тайлагнасан ч хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаагүй | 100% | 2018 онд нийт 28 гэр нийлүүлсэн / улсын төсвийн хөрөнгөөр 20 гэр, НҮБ-ын "Хүүхдийн сан"-гийн нэмэлт санхүүжилтээр 8 гэр/ гэж тайлагнасан ч хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаагүй | Хүрэх түвшнийг бүрэн хангаагүй байхад 100%-р үнэлсэн |
| | 3 | Хувийн хэвшлийн болон байгууллагын цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх | 2017-2020 | Нийт 7,200.0<br><br>2017 онд 1,800.0<br><br>2018 онд 1,800.0 | Жил бүр хувийн цэцэрлэгийг 60-аар, байгууллагын цэцэрлэгийг 10-аар нэмэгдүүлэх | | | Тухайн жилийн хувийн цэцэрлэг, байгууллагын цэцэрлэгийн тоог хэдээр нэмэгдүүлснийг болон хөрөнгийн зарцуулалтыг тайлагнаагүй | 100% гэж үнэлсэн | 2018-2019 онд төрийн бус өмчийн 8 цэцэрлэг, байгууллагын цэцэрлэг 1 байгуулагдсан... гэж, хөрөнгийн | Хүрэх түвшнийг бүрэн хангаагүй байхад 1 00%-р үнэлсэн |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | *2019 онд 1,800.0*<br><br>*2020 онд 1,800.0* | | | | | | *зарцуулалтыг тайлагнаагүй.* | |
| | *4* | *Төрийн өмчийн цэцэрлэгт хүүхдийн хоолны зардлыг төрөөс болон эцэг эх, асран хамгаалагчаас хариуцах хувь, хэмжээг тогтоон хэрэгжүүлэх* | *2017-2020* | *-* | *2018-2020 он тус бүрд нийт хоолны зардлын 53 хувийг улсын төсвөөс, 47 хувийг эцэг эх, асран хамгаалагч нь хариуцдаг болох* | | | *Хүүхдийн хоолны зардлын эцэг, эхээс санхүүжүүлэх хувь хэмжээг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газарт өргөн барьсан.* | *70%* | *Зорилт хэрэгжээгүй* | *Хүрэх түвшнийг хангаагүй байхад 100%-р үнэлсэн* |
| | *5* | *Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний оновчтой шинэ арга, технологийг судалж, хэрэгжүүлж эхлэх* | *2016-2017* | *-* | *2017 онд СӨБ-ын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх шинэ хувилбарыг сонгож хэрэгжүүлж эхлэх,*<br><br>*2018-2019 онд хэрэгжилтийн явцаар үнэлэх,*<br><br>*СӨБ-ын үйлчилгээний хүртээмж нэмэгдэх* | | *үнэлээгүй* | *2017 оны хичээлийн жилд нийслэлийн хэмжээнд төрийн бус өмчийн 136 цэцэрлэгт 3087 хүүхдийг хамруулж, 2.5 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүллээ... гэж*<br><br>*Төрийн өмчийн цэцэрлэгийг түшиглэн 11 байгууллагын дэргэд 29 бүлэг шинээр байгуулагдаж, 1052 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамрууллаа... гэж тайлагнасан.* | *100%* | | *үнэлээгүй* |

*Эх сурвалж: Засгийн газрын Хяналт шинжилгээ,үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим сан*